МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2019 оны 12 сарын 30 өдөр Дугаар А/611 Улаанбаатар хот

Эрүүл мэндийн салбарын статистик мэдээ, мэдээллийн журам, бүртгэлийн маягтыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.19, Статистикийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 (з) дахь хэсгийг тус тус үндэслэн эрүүл мэндийн мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн мэдээллийн мэргэжилтэн, биостатистикч эмчийн эрх, үүргийг нэгдүгээр, эрүүл мэндийн салбарын албан ёсны статистикийн мэдээ тайлан гаргах, мэдээлэх журмыг хоёрдугаар, хувийн хэвшлийн эмнэлгийн мэдээ, тайлан гаргах, мэдээлэх журмыг гуравдугаар, халдварт өвчин, хамшинж, сэжигтэй тохиолдлыг бүртгэх, мэдээлэх журмыг дөрөвдүгээр, бэлгийн замаар дамжих халдварын тохиолдлыг бүртгэх, мэдээлэх журмыг тавдугаар, сүрьеэ өвчнийг бүртгэх, мэдээлэх журмыг зургаадугаар, хорт хавдрыг бүртгэх, мэдээлэх журмыг долоодугаар, хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийг бүртгэх, мэдээлэх журмыг наймдугаар, уламжлалт анагаахын тусламж, үйлчилгээний мэдээг бүртгэх, мэдээлэх журмыг есдүгээр, эрүүл мэндийн бүртгэлийн болон тайлангийн маягтын жагсаалт, хадгалах хугацааг аравдугаар, шинэчлэн боловсруулсан анхан шатны бүртгэлийн болон тайлангийн маягтын загварыг арваннэгдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Бүртгэл, тайлангийн шинэчлэгдсэн маягтын загвар, хөтлөх зааврыг шинэчлэн боловсруулж, хэвлүүлэх, маягтад өөрчлөлт орсонтой холбогдуулан эрүүл мэндийн статистикийн програм хангамжийг шинэчлэх үйл ажиллагааг тус тус 2020 оны 1 дүгээр сард багтаан зохион байгуулахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/-д даалгасугай.

3. Бүртгэл, тайлангийн маягтуудыг хэвлүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн төсөвт тусгах, өвчний түүхийг архивлах, хадгалах өрөөг орчин үеийн шаардлагад нийцсэн тоног төхөөрөмжөөр тоноглохыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын болон өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

• 141200041

4. Тушаалыг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Я.Амаржаргал/-т даалгасугай.

5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2012 оны 95, 2013 оны 446 дугаар тушаалын 3, 4, 5, 6, 7 дугаар хавсралт, 2013 оны 450 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД Д.САРАНГЭРЭЛ

Эрүүл мэндийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 30 өдрийн А/611 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН МЭДЭЭЛЛИЙН МЭРГЭЖИЛТЭН, БИОСТАТИСТИКЧ ЭМЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

Нэг: Эрүүл мэндийн мэдээллийн мэргэжилтэн, биостатистикч, тархварзүйч эмчийн эрх

1. Сарын мэдээ, улирал, жилийн тайлан, эрүүл мэндийн мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох асуудлаар санал боловсруулж удирдлага болон дээд байгууллагуудад танилцуулах.

2. Сарын мэдээ, улирал, жилийн тайлан мэдээлэлд хайхрамжгүй хандсан (маягтыг буруу, дутуу хөтөлсөн, хугацаа хожимдуулсан, үндэслэл муутай мэдээлэл өгсөн), мэдээ тасалсан зөрчлийг цаг тухайд нь илрүүлж, хариуцлагагүй хандсан эмч, эмнэлгийн мэргэжилтэнг тухайн байгууллагын удирдлагад танилцуулж, хариуцлага тооцох санал оруулах.

3. Тухайн тайлангийн жилд статистик мэдээ, мэдээлэлд идэвх санаачлага, үр бүтээлтэй ажилласан ажилтныг урамшуулах ажлыг зохион байгуулж, тухайн байгууллагын удирдлагын зөвлөлийн түвшинд хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх

4. Үндэсний статистикийн хорооны зөвшөөрсөн, Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсанаас бусад загварын маягт, аргачлалаар мэдээ, мэдээлэл гаргаж өгөхөөс татгалзах.

5. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын мэдээллийн мэргэжилтэн, Статистикийн улсын байцаагч нь албан ёсны статистикийн мэдээллийг батлагдсан буюу зөвшөөрөгдсөн аргачлалын дагуу үнэн зөв, хугацаанд гаргаж өгч байгаа байдалд хяналт шалгалт хийх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар акт, шаардлага бичих, зөрчил дутагдал гаргасан хүмүүст сахилгын арга хэмжээ авахуулах саналыг холбогдох албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх.

6. Мэдээллийн мэргэжилтэн, биостатистикч эмч нар нь мэргэжлийн дагуу суралцах, мэдлэгээ дээшлүүлэх чиглэлээр гадаад, дотоодын сургалтад хамрагдах, суралцах эрхтэй.

Хоёр: Эрүүл мэндийн мэдээллийн мэргэжилтэн, биостатистикч, тархварзүйч эмчийн үүрэг

1. Эрүүл мэндийн статистикийн сарын мэдээ, улирал, жилийн тайланг тогтоосон хугацаанд үнэн зөв гаргаж мэдээлэх.

2. Харъяалах нутаг дэвсгэрийн хэмжээний бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудад мэдээ цуглуулах анхан шатны бүртгэлийн маягтын хөтлөлтийн байдал, бүртгэл мэдээллийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах, мэргэжлийн арга зүй, зөвлөмжөөр байнга хангах.

3. Эрүүл мэндийн статистикийн сарын мэдээ, улирал, жилийн тайланд дүн шинжилгээ хийж, хүн амын эрүүл мэндийн байдалд гарч байгаа өөрчлөлтүүдийн талаарх мэдээллийг удирдлага болон эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудад хүргэх.

4. Тухайн нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийн байдалд үнэлгээ өгөх, хүн амын эрүүл мэндийн сүүлийн 20-оос доошгүй жилийн үзүүлэлтүүдээр мэдээллийн сан үүсгэх, тогтмол баяжуулах.

5. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд эрүүл мэндийн статистик мэдээллийн чиглэлээр сургалт зохион байгуулах.

6. Эрүүл мэндийн статистикийн бүртгэл, бичиг баримтыг холбогдох хууль, журмын дагуу архивлан хадгалах.

7. Эрүүл мэндийн яамнаас зөвшөөрөгдсөн, эрүүл мэндийн байгууллагуудад хэрэглэгдэж буй програм хангамжуудыг эзэмшиж, үйл ажиллагаандаа ашиглах, нэвтрүүлэх чиглэлээр санаачлагатай ажиллаж, сургалт явуулах.

8. Өвчний болон үйлдлийн олон улсын ангиллыг мөрдөх, тэдгээрийг нэвтрүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах үүрэгтэй.

Гурав: Эрүүл мэндийн хөгжлийн төвийн мэдээллийн мэргэжилтэн, биостатистикч, тархварзүйч эмчийн эрх, үүрэг

1. Эрүүл мэндийн хөгжлийн төв нь аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын мэдээллийн мэргэжилтэн, биостатистикч эмч нарын тухайн жилийн үйл ажиллагааг үнэлэх журам боловсруулж мөрдүүлэх, журмын дагуу үнэлгээг хийж хариуцлага тооцох болон урамшуулах саналыг Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газруудад дараа оны хоёрдугаар улиралд багтаан хүргүүлэх.

2. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын мэдээллийн мэргэжилтэн, биостатистикч эмч нарыг мэргэжлийн ур чадвар, ажлын дадлага, туршлагыг үндэслэн Үндэсний статистикийн хорооны даргад "Статистикийн улсын байцаагч"-аар томилох буюу чөлөөлөх тухай асуудлыг тавьж шийдвэрлүүлэх.

3. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас эрүүл мэндийн мэдээллийн чиглэлээр гарч буй заавар, зөвлөмж, аргачлал, Өвчний болон үйлдлийн олон улсын ангиллыг мөрдөх тэдгээрийг нэвтрүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах эрхтэй.

4. Үндэсний түвшинд тооцох эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтийн тодорхойлолт, тооцох аргачлалыг шинэчлэн боловсруулах, эрүүл мэндийн сар, улирал, жилийн статистикийн үзүүлэлтүүдийн эмхэтгэлийг боловсронгуй болгох.

5. Үндэсний түвшинд мэдээ, мэдээллийг цуглуулах, нэгтгэн боловсруулах, дүн шинжилгээ хийх, эрүүл мэндийн салбарын үндсэн үзүүлэлтүүдийг тооцох, эмхэтгэн түгээх, эргэн мэдээлэх.

6. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас эрүүл мэндийн мэдээллийн чиглэлээр гарч буй заавар, зөвлөмж, аргачлалыг нэвтрүүлэхэд санаачлага гарган дээд шатны байгууллагад санал оруулж шийдвэрлүүлэх.

7. Бүх шатны эрүүл мэндийн байгууллагын мэдээ, тайлангийн чанарт хяналт хийх, мэргэжил арга зүйгээр хангах, мэдээллийн мэргэжилтэн, биостатистикч эмч, бүртгэл мэдээллийн ажилтнуудийг чадавхижуулах, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллах үүрэгтэй.

Эрүүл мэндийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 30. өдрийн А/611 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН АЛБАН ЁСНЫ СТАТИСТИКИЙН МЭДЭЭ, ТАЙЛАН ГАРГАХ, МЭДЭЭЛЭХ ЖУРАМ

Нэг. Сарын мэдээ, тайлан

1.1 Өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагууд нь хүн амын төрөлт, нас баралт, эх, хүүхдийн эндэгдэл, амбулатори, стационарын тусламж, үйлчилгээний үзүүлэлтүүд, амбулатори, стационарын өвчлөлийг өдөр бүр бүртгэн, тохиолдол тус бүрээр цахим мэдээний сан бүрдүүлнэ.

1.2 Өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагууд нь бүртгэгдсэн хүн амын төрөлт, нас баралт, эх, хүүхдийн эндэгдэл, амбулатори, стационарын тусламж, үйлчилгээний үзүүлэлтүүдийг улсын тайлан маягт ЭМТ-501.1-ын дагуу сар бүр цахим хэлбэрээр мэдээлнэ.

1.3 Хүн амын төрөлт, нас баралтын мэдээг "Нэг иргэн-нэг бүртгэл" цахим бүртгэлд мэдээлэгдсэн тохиолдолд сарын мэдээнд оруулах ба эх, хүүхэд, эмнэлгээс гараагүй байгаа хэдий ч төрөлтийн тоонд оруулан мэдээлнэ.

1.4 Эрүүл мэндийн байгууллагууд нь сэжигтэй болон онош нь батлагдаагүй өвчлөлийг тухайн сарын мэдээнд оруулалгүй, онош баталгаажсаны дараа мэдээлнэ.

1.5 Сарын мэдээ, тайланг гаргахдаа явуулын хүн амын өвчлөл, төрөлт, нас баралтыг тухайн тохиолдлыг бүртгэсэн эрүүл мэндийн байгууллага мэдээлж, харин тогтмол хаяг гэсэн асуултад тухайн хүний байнга оршин суугаа газрыг бичнэ. Явуулын хүн ам гэдэг ойлголтод 6 сараас бага хугацаагаар оршин суугаа болон албан буюу хувийн хэргээр зорчигчдыг оруулж бүртгэнэ.

1.6 Өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллага нь сарын мэдээг тухайн сарын сүүлчийн өдрөөр тасалбар болгож авна.

1.7 Сарын мэдээний нэгтгэлийг өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, аймаг, дүүрэг, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төв, тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгүүд нь дараа сарын 2-ны өдрийн дотор, аймаг, нийслэлийн түвшинд дараа сарын 4-ний өдрийн дотор багтаан дараагийн шатны эрүүл мэндийн байгууллагад мэдээлнэ.

1.8 Эрүүл мэндийн хөгжлийн төв нь үндэсний түвшинд сарын мэдээний нэгтгэлийг гаргаж Үндэсний статистикийн хороонд дараа сарын 6-ны өдрийн дотор, Эрүүл мэндийн яам болон бусад холбогдох байгууллагуудад дараа сарын 7-ны өдрийн дотор хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

1.9 Эрүүл мэндийн хөгжлийн төв нь Улсын Их Хурал, Засгийн газарт хүргүүлэх мэдээ, мэдээллийг Эрүүл мэндийн яамны холбогдох газар, хэлтсээр дамжуулан дараа сарын 7-ны өдрийн дотор хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

Хоер. Улирлын мэдээ, тайлан

2.1 Өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагууд нь эрүүл мэндийн бүртгэл тайлангийн программд хүн амын төрөлт, нас баралт, халдварт болон халдварт бус өвчний тохиолдол бүрийг шивж, цахим мэдээний санг үүсгэнэ.

2.2 Өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагууд нь хүн амын төрөлт, нас баралт, халдварт болон халдварт бус өвчний мэдээ, эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн цахим мэдээний санг өдөр, сар, улирлаар нэгтгэж, тайлан гаргах ба улирлын тайланг дараа улирлын эхний сарын 15-ны өдрийн дотор бүрдүүлсэн байна.

2.3 Үндэсний түвшинд хүн амын төрөлт, нас баралт, халдварт болон халдварт бус өвчний мэдээ, эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн цахим мэдээний санг улирлаар нэгтгэн, дараа улирлын эхний сарын 30-ны өдрийн дотор аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт эргэн мэдээлнэ.

2.4 Өрхийн эрүүл мэндийн төв болон хувийн хэвшлийн эмнэлгүүдийн эдийн засгийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь Үндэсний статистикийн хорооны даргын 2018 оны 12 сарын 26-ны өдрийн А/156 дугаар тушаалаар батлагдсан "Эрүүл мэндийн хувийн хэвшлийн байгууллагын албан ёсны улирлын мэдээний маягт"-ын дагуу улирал болон жилийн тайланг гаргана.

2.5 "Эрүүл мэндийн хувийн хэвшлийн байгууллагын 20... оны ...-р улирлын мэдээ"-г эрүүл мэндийн байгууллагууд нь аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт улирал бүрийн дараа сарын 15-ны өдрийн дотор, жилийн эцсийн мэдээг дараа оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор цахим болон цаасан хэлбэрээр тус тус хүргүүлнэ.

<u>Гурав. Жилийн тайлан</u>

3.1 Өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагууд жилийн үйл ажиллагааны тайланг тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон, батлагдсан маягтын дагуу нэгтгэн дараа оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлнэ.

3.2 Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар нь аймаг, нийслэлийн түвшинд эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны жилийн тайланг хүлээн авч, нэгтгэх, дүгнэх, эргэн мэдээлэх ажлыг удирдан зохион байгуулна.

3.3 Тухайн жилийн сар, улирлын мэдээнүүд нь өссөн дүнгээр жилийн тайланд тусгагдана.

3.4 Эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны жилийн тайланг хүлээн авч, нэгтгэхдээ үндсэн материалтай нь тулган шалгаж, дүгнэлт хийнэ.

3.5 Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн төрөлжсөн мэргэшлийн кабинетын эмч нар нь жилийн үйл ажиллагааны тайланг батлагдсан маягтын дагуу нэгтгэн, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын мэдээллийн мэргэжилтэнд дараа оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор хүлээлгэн өгнө.

3.6 Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар нь эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны жилийн тайланг батлагдсан маягт, зааврын дагуу нэгтгэн дараа оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Эрүүл мэндийн хөгжлийн төвд цахим болон цаасан хэлбэрээр баталгаажуулан хүргүүлнэ.

3.7 Тусгай мэргэжлийн төв, Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгүүд нь аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн төрөлжсөн мэргэшлийн кабинетаас ирүүлсэн жилийн тайланг нэгтгэж, Эрүүл мэндийн хөгжлийн төвд дараа оны 2 дугаар сарын 1-ний өдрийн дотор цахим болон цаасан хэлбэрээр баталгаажуулан хүргүүлнэ.

3.8 Эрүүл мэндийн хөгжлийн төв нь үндэсний түвшинд эрүүл мэндийн байгууллагуудын жилийн тайлангийн нэгтгэл, статистик боловсруулалт хийж, үндэсний хэмжээнд гаргах эрүүл мэндийн үзүүлэлтүүдийг тооцно.

Дөрөв. Эргэн мэдээлэл

4.1 Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар нь өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, аймаг, дүүрэг, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн сар, улирал, жилийн мэдээ, тайланд нэгтгэл, дүгнэлт хийж харьяа эрүүл мэндийн байгууллагуудад эргэн мэдээлнэ.

4.2 Эрүүл мэндийн хөгжлийн төв нь сар бүрийн "Эрүүл мэндийн статистикийн мэдээлэл" эмхэтгэлийг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт дараа сарын 07-ны өдрийн дотор цахим хуудсаар эргэн мэдээлнэ.

4.3 Эрүүл мэндийн хөгжлийн төв нь хүн амын амбулатори, стационарын өвчлөл, нас баралтын цахим мэдээний санд улирал тутам нэгтгэл, дүгнэлт хийж аймаг нийслэлийн Эрүүл мэндийн газар, Тусгай мэргэжлийн төв, Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгүүдэд дараа улирлын эхний сарын 15-ны өдрийн дотор цахим хуудсаар эргэн мэдээлнэ.

4.4 Эрүүл мэндийн хөгжлийн төв нь эрүүл мэндийн байгууллагуудын жилийн тайлангийн нэгтгэлд статистик боловсруулалт хийж, эрүүл мэндийн салбарын үндэсний хэмжээнд гаргах үзүүлэлтүүдийг тооцож, дүгнэлт хийн, эмхэтгэл болгон хэвлүүлж, Эрүүл мэндийн яам, Үндэсний статистикийн хороо болон холбогдох бусад байгууллага, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт дараа жилийн 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор хүргүүлнэ.

4.5 Сар, улирал, жилийн эрүүл мэндийн статистикийн эмхэтгэл, мэдээллийг хэвлүүлэн мэдээлэл хэрэглэгчдэд түгээх зардлыг тухайн эрүүл мэндийн байгууллага нь жилийн төсвийн төлөвлөгөөнд суулган, санхүүжилтийг шийдвэрлэнэ.

Тав. Мэдээлэх урсгал

Эрүүл мэндийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 30 өдрийн A/672 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

ХУВИЙН ХЭВШЛИЙН ЭМНЭЛГИЙН СТАТИСТИКИЙН МЭДЭЭ, ТАЙЛАН ГАРГАХ, МЭДЭЭЛЭХ ЖУРАМ

Нэг. Сарын мэдээ, тайлан

1.1 Монгол улсын "Статистикийн тухай" хуулийн 2 дугаар бүлгийн 6 дугаар зүйлд заасны дагуу албан ёсны статистик мэдээллийг тогтсон хугацаанд, батлагдсан маягтаар аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газраас зөвшөөрөл авсан хувийн хэвшлийн эмнэлгүүд нь аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт, Эрүүл мэндийн яамнаас тусгай зөвшөөрөл авсан хувийн хэвшлийн эмнэлгүүд нь Эрүүл мэндийн хөгжлийн төвд тус тус гарган хүргүүлнэ.

1.2 Хувийн хэвшлийн эмнэлэг нь бүртгэгдсэн хүн амын төрөлт, нас баралт, эх, хүүхдийн эндэгдэл, амбулатори, стационарын тусламж үйлчилгээний үзүүлэлтүүд, халдварт болон халдварт бус өвчний сарын мэдээг тухайн сарын сүүлчийн өдрөөр тасалбар болгон, улсын тайлан маягт ЭМТ-501.1-ын дагуу сар бүр цахим хэлбэрээр мэдээлнэ.

1.3 Хүн амын төрөлт, нас баралтын мэдээг "Нэг иргэн-нэг бүртгэл" цахим бүртгэлд мэдээлэгдсэн тохиолдолд сарын мэдээнд оруулах ба эх, хүүхэд, эмнэлгээс гараагүй байгаа хэдий ч төрөлтийн тоонд оруулан мэдээлнэ.

1.4 Хувийн хэвшлийн эмнэлэг нь сэжигтэй болон онош нь батлагдаагүй өвчлөлийг тухайн сарын мэдээнд оруулалгүй, онош баталгаажсаны дараа мэдээлнэ.

1.5 Сарын мэдээг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газраас зөвшөөрөлтэй хувийн хэвшлийн эмнэлгүүд нь тухайн аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газарт, Эрүүл мэндийн яамнаас тусгай зөвшөөрөл авсан хувийн хэвшлийн эмнэлгүүд нь Эрүүл мэндийн хөгжлийн төвд дараа сарын 2-ны өдрийн дотор тус тус мэдээлнэ.

Хоёр. Улирлын мэдээ, тайлан

2.1 Хувийн хэвшлийн эмнэлэг нь хүн амын амбулатори, стационарын өвчлөл, нас баралтыг өдөр бүр бүртгэн, эрүүл мэндийн бүртгэл тайлангийн програм хангамжид цахим мэдээний сан үүсгэнэ.

2.2 Цахим мэдээний санг өдөр, сар, улирлаар нэгтгэж, тайланг өдөр, сар, улирлаар гарган аймаг, нийслэлийн түвшинд тухайн аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт дараа улирлын эхний сарын 10-ны өдрийн дотор, Эрүүл мэндийн яамнаас тусгай зөвшөөрөл авсан хувийн хэвшлийн эмнэлгүүд нь Эрүүл мэндийн хөгжлийн төвд дараа улирлын эхний сарын 10-ны өдрийн дотор цахим хэлбэрээр тус тус мэдээлнэ.

2.3 Үндэсний статистикийн хорооны даргын 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/156 дугаар тушаалаар батлагдсан Улсын тайлан маягт ЭМТ-6-аар "Эрүүл мэндийн хувийн хэвшлийн байгууллагын 20..оны ...-р улирлын мэдээ"-г улирал тутам гаргана.

2.4 “Эрүүл мэндийн хувийн хэвшлийн байгууллагын 20..оны ...-р улирлын мэдээ”-г аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газраас зөвшөөрөл авсан хувийн хэвшлийн эмнэлэг нь тухайн аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт, Эрүүл мэндийн яамнаас тусгай зөвшөөрөл авсан хувийн хэвшлийн эмнэлгүүд нь Эрүүл мэндийн хөгжлийн төвд дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор цахим хэлбэрээр тус тус мэдээлнэ.

2.5 Эрүүл мэндийн хөгжлийн төв нь “Эрүүл мэндийн хувийн хэвшлийн байгууллагын 20..оны ...-р улирлын мэдээ”-г нэгтгэн дараа улирлын эхний сарын 25-ны өдрийн дотор Үндэсний статистикийн хороонд хүргүүлнэ.

Гурав. Жилийн тайлан

3.1 Хувийн хэвшлийн эмнэлэг нь жилийн тайлан мэдээг тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон, батлагдсан маягтын дагуу гаргаж, нэгтгэн дараа оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт, Эрүүл мэндийн яамнаас тусгай зөвшөөрөл авсан хувийн хэвшлийн эмнэлгүүд нь Эрүүл мэндийн хөгжлийн төвд мөн хугацаанд баталгаажуулан цахим болон цаасан хэлбэрээр тус тус хүргүүлнэ.

3.2 Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар нь хувийн хэвшлийн эмнэлгүүдийн жилийн эцсийн үйл ажиллагааны тайланг батлагдсан маягт, аргачлалын дагуу нэгтгэн, дараа оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн дотор багтаан Эрүүл мэндийн хөгжлийн төвд цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлнэ.

3.3 Үндэсний статистикийн хорооны даргын 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/156 дугаар тушаалаар батлагдсан Улсын тайлан маягт ЭМТ-6-аар “Эрүүл мэндийн хувийн хэвшлийн байгууллагын 20..оны ...-р улирлын мэдээ”-г жилийн эцсийн байдлаар дараа оны 3 дугаар сарын 01-ний өдрийн дотор Эрүүл мэндийн хөгжлийн төвд цаасан болон цахим хэлбэрээр тус тус хүргүүлнэ.

3.4 Эрүүл мэндийн хөгжлийн төв нь “Эрүүл мэндийн хувийн хэвшлийн байгууллагын 20..оны ...-р улирлын мэдээ”-г жилийн эцсийн байдлаар нэгтгэн дараа оны 3 дугаар сарын 12-ны өдрийн дотор Үндэсний статистикийн хороонд хүргүүлнэ.

Эрүүл мэндийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 30 өдрийн А/611 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт

ХАЛДВАРТ ӨВЧИН, ХАМШИНЖ, СЭЖИГТЭЙ ТОХИОЛДЛЫГ БҮРТГЭХ, МЭДЭЭЛЭХ ЖУРАМ

Нэг. Долоо хоногийн мэдээ

1.1 Өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагууд нь бүртгэгдсэн халдварт өвчний хамшинж, сэжигтэй тохиолдлын мэдээг долоо хоног бүрийн даваа гаригт харьяа аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, дүүргийн эрүүл мэндийн төвд мэдээлэх хуудасны I хэсгээр мэдээлнэ.

1.2 Аймаг, нийслэлийн нийслэлийн эрүүл мэндийн газар нь харьяа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагуудаас ирүүлсэн халдварт өвчний хамшинж, сэжигтэй тохиолдлын мэдээг долоо хоног бүр нэгтгэж, мягмар гаригт цахимаар Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Тандалтын Үндэсний нэгжийн www.nccd.gov.mn/ewar/ вэб хаяг руу илгээнэ.

1.3 Халдварт өвчний онош батлагдсан тохиолдолд "Халдварт өвчин, хамшинж, сэжигтэй тохиолдлыг мэдээлэх хуудас"-ны I, II хэсгийг хамт бөглөж мэдээлнэ.

1.4 Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Тандалтын үндэсний нэгж нь аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газраас ирүүлсэн мэдээг нэгтгэн дүгнэж долоо хоногийн пүрэв гариг бүр эргэн мэдээлнэ.

1.5 "Халдварт өвчин, хамшинж, сэжигтэй тохиолдлыг мэдээлэх хуудас" өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагуудад хөтлөгдөж, статистикийн албанд нэгтгэнэ.

1.6 Долоо хоногийн мэдээнд эпидемиологийн хуанлигаар өмнөх долоо хоногийн ням гаригаас дараа долоо хоногийн ням гариг хүртэлх мэдээг хамруулна.

1.7 Босго үзүүлэлтэд хүрсэн тохиолдолд долоо хоногийн мэдээг хүлээхгүйгээр 24 цагийн дотор дараагийн шатны эрүүл мэндийн байгууллагад мэдээлнэ.

1.8 Халдварт өвчин, хамшинж, сэжигтэй тохиолдлын долоо хоногийн нэгдсэн мэдээг захиргааны статистикийн мэдээлэл ЭМТ-301.1 тайлангийн маягтын дагуу нэгтгэн Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Тандалтын үндэсний нэгжид мэдээлнэ.

Хоёр. Сарын мэдээ

2.1 Өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагууд халдварт өвчний онош батлагдсан тохиолдлуудын мэдээг нэгтгэнэ.

2.2 Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, эмнэлэг, аймаг, дүүрэг, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төв, дүүргийн эрүүл мэндийн төв, хувийн хэвшлийн

эмнэлгүүд онош батлагдсан халдварт өвчний мэдээг сар бүрийн 02-ны өдрийн дотор харьяа аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газарт мэдээлнэ.

2.3 Онош батлагдсан халдварт өвчний тохиолдлуудыг "Халдварт өвчин, хамшинж, сэжигтэй тохиолдлыг мэдээлэх хуудас"-аар мэдээлж, эрүүл мэндийн бүртгэл тайлангийн программд шивж, мэдээллийн сан үүсгэнэ.

2.4 Оношийг лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн баталгаажуулахаас гадна зарим шинэ ба ховор халдварын үед үүсгэгчийн хэв шинжээс шалтгаалан өвөрмөц оношлуурууд тохирохгүй нөхцөлд ерөнхий мэргэжилтэн, зөвлөх эмчийн үзлэгээр эмнэлзүйн шинж тэмдэг, тархвар судлалын судалгааны дүгнэлтийг үндэслэн эцсийн онош тавина.

2.5 Сарын мэдээнд тухайн сарын 1-ний өдрөөс эхлэн дараагийн сарын 1-ний өдөр хүртэлх мэдээг хамруулна.

Гурав. Жилийн тайлан

3.1 Халдварт өвчний онош баталгаажсан тохиолдлуудын долоо хоног, сарын мэдээг өссөн дүнгээр нэгтгэж жилийн тайланд тусгана.

3.2 Аймаг, дүүргийн халдвар судлаач, тархвар зүйч эмч нь үйл ажиллагааны жилийн тайланг "Захиргааны статистикийн мэдээлэл ЭМТ-301 тайлан" маягтын дагуу нэгтгэн дараа оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт цаасан хэлбэрээр хүргүүлнэ.

3.3 Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар нь "Халдварт өвчин судлалын кабинетийн үйл ажиллагааны жилийн тайлан"-г нэгтгэж дараа оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Халдварт өвчин судлалын үндэсний төвд цаасан хэлбэрээр хүргүүлнэ.

3.4 Халдварт өвчин судлалын үндэсний төв нь аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газраас ирүүлсэн "Халдварт өвчин судлалын кабинетийн үйл ажиллаагааны жилийн тайлан"-г хүлээн авч нэгтгэн Эрүүл мэндийн хөгжлийн төвд цахим болон цаасан хэлбэрээр баталгаажуулан дараа оны 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ.

Дөрөв. Мэдээлэх урсгал

Эрүүл мэндийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 30 өдрийн 176 дугаар тушаалын тавдугаар хавсралт

БЭЛГИЙН ЗАМААР ДАМЖИХ ХАЛДВАРЫН ТОХИОЛДЛЫГ БҮРТГЭХ, МЭДЭЭЛЭХ ЖУРАМ

Нэг. Бэлгийн замаар дамжих халдварыг бүртгэх

1.1 Өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн /лаборатори бүхий/ байгууллагууд нь бэлгийн замаар дамжих халдвар, төрөлхийн тэмбүүгийн тохиолдлыг "Бэлгийн замаар дамжих халдварыг мэдээлэх хуудас" маягтаар бүртгэн харьяа аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт мэдээлнэ.

1.2 Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв нь Бэлгийн замаар дамжих халдварыг хам шинжээр оношлон "Бэлгийн замаар дамжих халдварыг мэдээлэх хуудас" маягтын дагуу бүртгэн аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт мэдээлнэ.

1.3 Төрөлхийн тэмбүүгийн сэжигтэй тохиолдлыг тухайн харьяаллын Бэлгийн замаар дамжих халдварын кабинетын эмч оношийг баталгаажуулан, халдвар судлаач эмч мэдээлнэ.

1.4 Хүний дархлал хомсдолын вирус (ХДХВ)-ийн халдварын сэжигтэй тохиолдлыг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн нэгдсэн лабораторийн албанд баталгаажуулж Халдварт өвчин судлалын үндэсний төвийн ДОХ/ БЗДХ-ын тандалт судалгааны албанд "ХДХВ-ийн халдвар, Дархлалын олдмол хомсдол (ДОХ)-ын өвчлөлийг мэдээлэх хуудас" маягтаар бүртгэн мэдээлнэ.

1.5 Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, аймгийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ, дүүргийн эрүүл мэндийн төв, тусгай зөвшөөрөл бүхий хувийн хэвшлийн эмнэлэг, клиник, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн эмэгтэйчүүдийн эмч жирэмсэн эмэгтэйчүүдийн тэмбүү илрүүлэх шинжилгээгээр тэмбүүгийн халдвар илэрсэн тохиолдолд тухайн харъяаллын БЗДХ-ын кабинетийн эмчид илгээн "Тэмбүүгийн халдвартай жирэмсэн эмэгтэйн хяналтын бүртгэл"-ийн маягтаар бүртгэн, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар болон Халдварт өвчин судлалын үндэсний төвийн ДОХ/БЗДХ-ын тандалт судалгааны албанд мэдээлнэ.

1.6 Аймгийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ-ийн төрөх тасаг, амаржих газрууд, эрүүл мэндийн яамнаас тусгай зөвшөөрөл авсан хувийн хэвшлийн эмнэлэг, клиник, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд, амаржих газар төрөх тасагт илэрсэн өвчлөлийг "Тэмбүү илрүүлэх шинжилгээний бүртгэл" маягтаар бүртгэн аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар болон Халдварт өвчин судлалын үндэсний төвийн ДОХ/БЗДХ-ын тандалт судалгааны албанд мэдээлнэ.

1.7 Өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагууд нь тэмбүүгийн халдвар илрүүлэх шинжилгээг "Серологийн шинжилгээний бүртгэл", ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээг "ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээний бүртгэл"-ийн маягтын дагуу

бүртгэн аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн ДОХ/ БЗДХ-ын тандалт судалгааны албанд мэдээлнэ.

1.8 Аймаг, дүүрэг, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо эмчилгээний төв, дүүргийн эрүүл мэндийн төвүүдийн Бэлгийн замаар дамжих халдварын кабинетын эмч нь "Бэлгийн замаар дамжих халдварыг мэдээлэх хуудас" маягтын дагуу бүртгэгдсэн тохиолдлыг эрүүл мэндийн бүртгэл тайлангийн програмд шивж, мэдээний санг үүсгэнэ.

Хоёр. Сарын мэдээ

2.1 Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар нь онош батлагдсан Бэлгийн замаар дамжих халдвар, төрөлхийн тэмбүүгийн тохиолдлыг нэгтгэн дараа сарын 4-ний өдрийн дотор цахим хэлбэрээр Эрүүл мэндийн хөгжлийн төвд сар бүр мэдээлнэ.

2.2 Өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагууд онош батлагдсан тохиолдлын дагуу цахим мэдээний санг "Бэлгийн замаар дамжих халдварыг мэдээлэх хуудас" АМ-3 маягтын дараа сарын 04-ний өдрийн дотор бүрдүүлнэ.

2.3 Бэлгийн замаар дамжих халдварын шинжилгээний тайланг эрүүл мэндийн байгууллагын лабораторийн эмч, лаборант нар сар, улирлаар гарган дараа сарын 10-ны өдрийн дотор цахим болон цаасан хэлбэрээр Халдварт өвчин судлалын үндэсний төвийн ДОХ/БЗДХ-ын тандалт судалгааны албанд ирүүлнэ.

2.4 Хам шинжийн оношилгооны сарын тайланг өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмч нар нэгтгэн гаргаж аймгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төв, дүүргийн эрүүл мэндийн төвийн Бэлгийн замаар дамжих халдварын кабинетийн эмчид цахим хэлбэрээр дараа сарын 5-ны өдрийн дотор хүргүүлнэ.

2.5 Бэлгийн замаар дамжих халдварын кабинетийн эмч нь хам шинжийн оношилгооны сарын тайлангийн нэгтгэлийг дараа сарын 10-ны өдрийн дотор цахим хэлбэрээр Халдварт өвчин судлалын үндэсний төвийн ДОХ/БЗДХ-ын тандалт судалгааны албанд ирүүлнэ.

Гурав. Жилийн тайлан

3.1 Сарын мэдээг өссөн дүнгээр гаргаж жилийн тайланд тусгана.

3.2 Аймгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төв, дүүргийн эрүүл мэндийн төвийн БЗДХ-ын кабинетийн эмч, хувийн хэвшлийн эмнэлгүүд нь үйл ажиллагааны жилийн тайланг "Захиргааны статистикийн мэдээлэл ЭМТ-304 тайлан" маягтын дагуу гарган дараа оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор харьяа аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газарт цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

3.3 Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, Тусгай мэргэжлийн төв, Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Тусгай эмнэлэг, Эрүүл мэндийн яамнаас тусгай зөвшөөрөлтэй хувийн хэвшлийн эмнэлгүүд, төрийн бус байгууллагууд нь үйл ажиллагааны жилийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Халдварт өвчин судлалын үндэсний төвийн ДОХ/БЗДХ-ын тандалт судалгааны албанд цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

3.4 Халдварт өвчин судлалын үндэсний төвийн ДОХ/БЗДХ-ын тандалт судалгааны алба нь аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Тусгай мэргэжлийн төв, Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Тусгай эмнэлэг, Эрүүл мэндийн яамнаас тусгай зөвшөөрөлтэй хувийн хэвшлийн эмнэлгүүдээс ирүүлсэн "Захиргааны статистикийн мэдээлэл ЭМТ-304 тайлан"-г хүлээн авч нэгтгэн, баталгаажуулж цахим болон цаасан хэлбэрээр дараа оны 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлнэ.

Дөрөв. Мэдээлэх урсгал

Эрүүл мэндийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 30 өдрийн А/611 дугаар тушаалын зургаадугаар хавсралт

СҮРЬЕЭ ӨВЧНИЙГ БҮРТГЭХ, МЭДЭЭЛЭХ ЖУРАМ

Нэг. Сүрьеэ өвчнийг бүртгэх

1.1 Аймаг, дүүрэг, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төв, дүүргийн эрүүл мэндийн төв, хувийн хэвшлийн эмнэлгүүд нь онош батлагдсан шинээр илэрсэн сүрьеэгийн тохиолдлыг "Шинээр илэрсэн сүрьеэ өвчнийг мэдээлэх хуудас" АМ-4 маягтаар бүртгэн аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газарт мэдээлнэ.

1.2 Сүрьеэ өвчний улмаас нас барсан тохиолдлыг "Нас барсан тухай эмнэлгийн гэрчилгээ" АМ-7 маягтаар бүртгэн мэдээлэх бөгөөд сарын мэдээнд зөвхөн шинээр илэрсэн сүрьеэ өвчний улмаас нас барсан тохиолдлыг мэдээлнэ.

1.3 Аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансерийн эмч нь "Шинээр илэрсэн сүрьеэ өвчнийг мэдээлэх хуудас" АМ-4 маягтын дагуу эрүүл мэндийн бүртгэл тайлангийн программд шивж цахим мэдээний сан үүсгэнэ.

1.4 Эмэнд дасалтай сүрьеэгийн сэжигтэй тохиолдол бүрийг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн лавлах лабораториор баталгаажуулж олон эмэнд дасалтай сүрьеэтэй /ОЭДС/-тэй өвчтөний эмчилгээ хяналтын карт" ОЭДС-1 маягтаар бүртгэнэ.

Хоёр. Сарын мэдээ

2.1 Аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансерийн эмч нь тухайн сард шинээр илэрсэн сүрьеэгийн өвчлөл, нас баралтын тохиолдлыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт дараа сарын 02-ны өдрийн дотор, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар нь дараа сарын 4-ний өдрийн дотор цахим хэлбэрээр Эрүүл мэндийн хөгжлийн төвд мэдээлнэ.

2.2 Аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансерийн эмч нь "Шинээр илэрсэн сүрьеэ өвчнийг мэдээлэх хуудас" АМ-4 маягтаар үүссэн цахим мэдээний санг дараа сарын 10-ны өдрийн дотор Халдварт өвчин судлалын үндэсний төвийн СТСА-д сар бүр ирүүлнэ.

Гурав. Жилийн тайлан

3.1 Сарын мэдээг өссөн дүнгээр гаргаж жилийн тайланд тусгана.

3.2 Аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансерийн үйл ажиллагааны жилийн тайланг "Захиргааны статистикийн мэдээлэл ЭМТ-302 тайлан" маягтын дагуу сүрьеэгийн зохицуулагч эмч гарган дараа оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

3.3 Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар нь үйл ажиллагааны жилийн тайланг хүлээн авч нэгтгэн дараа оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Халдварт өвчин судлалын үндэсний төвийн СТСА -д цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

3.4 Халдварт өвчин судлалын үндэсний төвийн СТСА нь аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газраас ирүүлсэн "Захиргааны статистикийн мэдээлэл ЭМТ-302 тайлан"-г хүлээн авч нэгтгэн баталгаажуулж, цахим болон цаасан хэлбэрээр дараа оны 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлнэ.

Дөрөв. Мэдээлэх урсгал

Эрүүл мэндийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 30 өдрийн А/601 дугаар тушаалын долоодугаар хавсралт

ХОРТ ХАВДРЫГ БҮРТГЭХ, МЭДЭЭЛЭХ ЖУРАМ

Нэг. Хорт хавдрыг бүртгэх

1.1 Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төв, дүүргийн эрүүл мэндийн төвүүд, тусгай эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, хувийн хэвшлийн эмнэлгүүд нь онош батлагдсан шинээр илэрсэн хорт хавдрын тохиолдлыг "Хорт хавдрыг мэдээлэх хуудас" АМ-5 маягтаар бүртгэн аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт мэдээлнэ.

2.1 Хорт хавдар өвчний улмаас нас барсан тохиолдлыг "Нас барсан тухай эмнэлгийн гэрчилгээ" АМ-7 маягтаар бүртгэн мэдээлэх бөгөөд сарын шуурхай мэдээлэлд нийт (шинэ, хуучин) хорт хавдар өвчний улмаас нас барсан тохиолдлыг мэдээлнэ.

2.2 Аймаг, дүүргийн хавдрын кабинетийн эмч нь "Хорт хавдрыг мэдээлэх хуудас"-аар (АМ-5 маягт), "Нас барсан тухай эмнэлгийн гэрчилгээ"-ээр (АМ-7 маягт) бүртгэгдсэн тохиолдлыг эрүүл мэндийн бүртгэл тайлангийн программд цахим мэдээний санг үүсгэнэ.

Хоёр. Сарын мэдээ

2.3 Аймаг, дүүргийн хавдрын кабинетийн эмч нь тухайн сард шинээр илэрсэн хорт хавдрын өвчлөл, хорт хавдрын нийт нас баралтын тохиолдлыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт дараа сарын 02-ны өдрийн дотор, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар нь дараа сарын 4-ний өдрийн дотор цахим хэлбэрээр Эрүүл мэндийн хөгжлийн төвд мэдээлнэ.

2.4 Тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Эрүүл мэндийн яамнаас тусгай зөвшөөрөл авсан хувийн хэвшлийн эмнэлгүүд нь тухайн сард шинээр илэрсэн хорт хавдрын өвчлөл, хорт хавдрын нийт нас баралтын тохиолдлыг дараа сарын 2-ны өдрийн дотор цахим хэлбэрээр Эрүүл мэндийн хөгжлийн төвд мэдээлнэ.

2.5 Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төв, дүүргийн эрүүл мэндийн төв, тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, хувийн хэвшлийн эмнэлгүүд нь "Хорт хавдрыг мэдээлэх хуудас" АМ-5 маягтаар үүссэн цахим мэдээний санг дараа сарын 10-ны өдрийн дотор Хавдар судлалын үндэсний төвд сар бүр ирүүлнэ.

Гурав. Жилийн тайлан

3.1 Сарын мэдээг өссөн дүнгээр гаргаж жилийн тайланд тусгана.

3.2 Аймаг, дүүргийн хавдрын жилийн үйл ажиллагааны тайланг "Захиргааны статистикийн мэдээлэл ЭМТ-303 тайлан" маягтын дагуу хавдрын кабинетийн эмч гарган дараа оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт цаасан хэлбэрээр хүргүүлнэ.

3.3 Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар нь үйл ажиллагааны жилийн тайланг хүлээн авч нэгтгэн дараа оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Хавдар судлалын үндэсний төвд цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

3.4 Хавдар судлалын үндэсний төв нь аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газраас ирүүлсэн "Захиргааны статистикийн мэдээлэл ЭМТ-303 тайлан"-г хүлээн авч нэгтгэн баталгаажуулж, цахим болон цаасан хэлбэрээр дараа оны 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлнэ.

Дөрөв. Мэдээлэх урсгал

Эрүүл мэндийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 30 өдрийн А/641 дугаар тушаалын наймдугаар хавсралт

ХОРТ ХАВДРЫН ЭРТ ИЛРҮҮЛЭГ ҮЗЛЭГИЙГ БҮРТГЭХ, МЭДЭЭЛЭХ ЖУРАМ

Нэг. Хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийг бүртгэх

1.1 Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, аймаг, дүүрэг, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай зөвшөөрөл бүхий хувийн хэвшлийн эмнэлгүүд нь эрт илрүүлэг үзлэгийг Эмчийн үзлэгийн бүртгэл АМ-1А, 1Б маягтаар бүртгэн, үйлчлүүлэгч бүрт эрт илрүүлэг үзлэгийн мэдээлэх хуудас хөтөлж, өвчлөл бүртгэгдсэн тохиолдолд хорт хавдрыг мэдээлэх журмын дагуу мэдээлнэ.

1.2 Эрүүл мэндийн байгууллагуудын эрт илрүүлэг үзлэг хариуцсан эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь эрт илрүүлэг үзлэгийн мэдээлэх хуудсын дагуу цахим мэдээний санг үүсгэнэ.

1.3 Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн хавдар бүртгэгч эмч нь "Эрт илрүүлэг үзлэгийн мэдээлэх хуудас" (ЭИМ маягт)-аар цахим мэдээний сан үүсгэнэ.

1.4 Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төв, тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай зөвшөөрөл бүхий хувийн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нар эрт илрүүлэг үзлэгийн програмд холбогдох эрхийн дагуу нэвтрэх эрхтэй бөгөөд цахим мэдээний сан үүсгэхэд үүргийн дагуу оролцоно.

1.5 Эрт илрүүлэг үзлэгийн цахим програмд нэвтэрч мэдээлийн сан үүсгэх эрхийг аймаг дүүргийн түвшинд хавдар бүртгэгч эмч олгоно. Нийслэл, тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, ЭМЯ-наас тусгай зөвшөөрөл авсан хувийн эмнэлгийн хувьд Хавдар судлалын үндэсний төвөөс олгоно.

Хоёр. Сарын мэдээ

2.1 Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, аймаг, дүүрэг, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг, төрөлжсөн мэргэжлийн төв, тусгай зөвшөөрөл бүхий хувийн хэвшлийн эмнэлгүүд нь эрт илрүүлэг үзлэгийн сарын мэдээг мэдээллийн урсгалын дагуу дараа сарын 1-ний өдрийн дотор цахим хэлбэрээр ирүүлнэ.

2.2 Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, аймаг, дүүрэг, хөдөөгийн нэгдсэн эмнэлгийн эрт илрүүлэг үзлэгийн мэдээг аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн хавдар бүртгэгч эмч, Эрүүл мэндийн газар нь тусгай зөвшөөрөл бүхий хувийн эмнэлгийн үзлэгийн мэдээг нэмж нэгтгэн хянаж, дараа сарын 4-ний өдрийн дотор цахим хэлбэрээр Хавдар судлалын үндэсний төвд сар бүр мэдээлнэ.

2.3 Тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, ЭМЯ-наас тусгай зөвшөөрөл авсан хувийн эмнэлгүүд эрт илрүүлэг үзлэгийн мэдээг дараа сарын 4-ний өдрийн дотор цахим хэлбэрээр Хавдар судлалын үндэсний төвд сар бүр мэдээлнэ.

2.4 Цахим мэдээний санг эрт илрүүлэг үзлэгийн мэдээлэх хуудсаар дараа сарын 05-ны өдрийн дотор үүсгэсэн байна.

Гурав. Жилийн тайлан

3.1 Сарын мэдээг өссөн дүнгээр гаргаж жилийн тайланд тусгана.

3.2 Аймаг, дүүрэг, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн хавдрын кабинетийн эмч, хавдар бүртгэгч нь эрт илрүүлэг үзлэгээр үүссэн цахим мэдээний санг хянаж, үйл ажиллагааны тайланг зохих маягтын дагуу гарган цаасан болон цахим хэлбэрээр дараа оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Хавдар судлалын үндэсний төвд хүргүүлнэ.

3.3 Тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, ЭМЯ-наас тусгай зөвшөөрөл авсан хувийн эмнэлгүүд эрт илрүүлэг үзлэгээр үүссэн цахим мэдээний сан, үйл ажиллагааны тайланг цаасан болон цахим хэлбэрээр дараа оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Хавдар судлалын үндэсний төвд хүргүүлнэ.

3.4 Хавдар судлалын үндэсний төв нь аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газраас ирүүлсэн эрт илрүүлэг үзлэгийн үйл ажиллагааны тайланг хүлээн авч, нэгтгэн цахим болон цаасан хэлбэрээр дараа оны 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлнэ.

Дөрөв. Эргэн мэдээлэх

4.1 Хавдар судлалын үндэсний төвд онош тодруулахаар илгээсэн тохиолдлоос хорт хавдрын онош батлагдвал АМ-5 маягт болон цахим сангаар харьяа аймаг, дүүргийн хавдар бүртгэгчид эргэн мэдээлнэ.

4.2 Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар нь хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийн сарын мэдээг нэгтгэн, хянаж дүн шинжилгээ хийн, дараа сарын 5-ны өдрийн дотор харьяа эрүүл мэндийн байгууллагуудад эргэн мэдээлнэ.

4.3 Хавдар судлалын үндэсний төв нь хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийн мэдээг нэгтгэн, боловсруулж, дүн шинжилгээ хийн холбогдох газруудад эргэн мэдээлнэ.

4.4 Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар нь эрт илрүүлэг үзлэгийн жилийн тайлан, мэдээний санд боловсруулалт дүн шинжилгээ хийн холбогдох газруудад дараа оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор эргэн мэдээлнэ.

Эрүүл мэндийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 30 өдрийн 761 дугаар тушаалын есдүгээр хавсралт

УЛАМЖЛАЛТ АНАГААХЫН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЭДЭЭГ БҮРТГЭХ, МЭДЭЭЛЭХ ЖУРАМ

Нэг. Сарын мэдээ

1.1 Өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагуудын уламжлалт эмчилгээний тасаг, кабинет нь хүн амын өвчлөл, нас баралтыг Уламжлалт анагаах ухааны оношийн дагуу бүртгэж, кодлоно.

1.2 Өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагуудын уламжлалт эмчилгээний тасаг, кабинет нь тухайн эрүүл мэндийн байгууллагад бүртгэгдсэн хүн амын өвчлөл, нас баралтын мэдээллийг Эрүүл мэндийн бүртгэл, тайлангийн программд өдөр бүр бүртгэн цахим мэдээний сан үүсгэнэ.

1.3 Монгол Уламжлалт анагаах ухааны үндэсний төв нь өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагуудын уламжлалт эмчилгээний тасаг, кабинетаас ирүүлсэн өвчлөл, нас баралтын мэдээг нэгтгэж, дараа сарын 05-ны өдрийн дотор Эрүүл мэндийн хөгжлийн төвд мэдээлнэ.

Хоёр. Улирлын мэдээ

2.1 Өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагуудын уламжлалт эмчилгээний тасаг, кабинетад үзүүлсэн уламжлалт анагаахын тусламж үйлчилгээг бүртгэлийн маягт АМ-28А, АМ-28Б, АМ-29А, АМ-29Б, АМ-29В, АМ-29Г маягтын дагуу бүртгэн, тайлангийн ЭМТ-203.6 маягтын дагуу дараа улирлын эхний сарын 10-ны өдрийн дотор Монгол Уламжлалт анагаах ухааны үндэсний төвд мэдээлнэ.

2.2 Монгол Уламжлалт анагаах ухааны үндэсний төв нь өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагуудын уламжлалт эмчилгээний тасаг, кабинетаас ирүүлсэн уламжлалт анагаах ухааны заслын мэдээг улирал бүр нэгтгэж, дараа улирлын эхний сарын 15-ны өдрийн дотор Эрүүл мэндийн хөгжлийн төвд мэдээлнэ.

Гурав. Жилийн тайлан

3.1 Сар, улирлын мэдээг өссөн дүнгээр гаргаж, жилийн тайланд тусгана.

3.2 Өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагуудын уламжлалт эмчилгээний тасаг, кабинетад үзүүлсэн уламжлалт анагаахын тусламж үйлчилгээний мэдээг нэгтгэн дараа оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Монгол Уламжлалт анагаах ухааны үндэсний төвд мэдээлнэ.

3.3 Монгол Уламжлалт анагаах ухааны үндэсний төв нь үйл ажиллагааны жилийн тайланг батлагдсан маягтын дагуу нэгтгэн дараа оны 2 дугаар сарын 01-ны өдрийн дотор Эрүүл мэндийн хөгжлийн төвд цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

Эрүүл мэндийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 30
өдрийн A/61 дугаар тушаалын аравдугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН БҮРТГЭЛИЙН БОЛОН ТАЙЛАНГИЙН МАЯГТЫН ЖАГСААЛТ, ХАДГАЛАХ ХУГАЦАА

Дугаар	Маягтын нэр	Маягтын дугаар	Хөтлөх хүний албан тушаал	Хадгалах хугацаа / жилээр / цаасан хэлбэр	Хадгалах хугацаа / жилээр / цахим хэлбэр
А. ӨРХ, СУМ, ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВҮҮДЭД ХӨТЛӨГДӨХ БҮРТГЭЛИЙН МАЯГТ					
1	Тав хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр	ӨЭ -1.А	Их эмч	Байнга	/-/
2	6-18 настай хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр	ӨЭ-1.Б	Их эмч	Байнга	/-/
3	Өрхийн хүн амын эрүүл мэндийн бүртгэл	ӨЭ-2	Өрхийн сувилагч, сумын болон багийн бага эмч	Байнга	Байнга
4	Хүүхдийн эрүүл өсөлт, хөгжлийн хяналтын карт	ӨЭ-3А	Өрхийн сувилагч, сумын болон багийн бага эмч	20	/-/
5	Хүүхдийн өсөлт, хөгжлийн бүртгэлийн маягт	ӨЭ-3Б	Өрхийн сувилагч, сумын болон багийн бага эмч	20	/-/
6	2 сар хүртэлх хүүхдийн үзлэгийн маягт	ӨЭ-4А	Өрх болон сумын эмч	5	/-/
7	Хоёр сараас 5 хүртэлх насны өвчтэй хүүхдийн үзлэгийн маягт	ӨЭ-4Б	Өрх болон сумын эмч	15	/-/
8	Дархлаажуулалтад хамрагдсан 0-15 настай хүүхдийн нэгдсэн бүртгэл	ӨЭ-5А	Өрх, сумын эмч, өрхийн сувилагч, сумын болон багийн бага эмч	5	/-/
9	Товлолын бус урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан хүмүүсийн бүртгэл	ӨЭ-5.Б	Өрх, сумын эмч, өрхийн сувилагч, сумын болон багийн бага эмч	5	

10	Дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн бүртгэл	ӨЭ-5.В	Өрх, сумын эмч, өрхийн сувилагч, сумын болон багийн бага эмч	5	
11	Урьдчилан сэргийлэх тарилгын орлого, зарлагын өдөр тутмын бүртгэл	ӨЭ-5.Г	Өрх, сумын эмч, өрхийн сувилагч, сумын болон багийн бага эмч	5	
12	0-15 настай хүүхдийг дархлаажуулах сарын төлөвлөгөө ба хамралт	ӨЭ-6.А	Өрх, сумын эмч, өрхийн сувилагч, сумын болон багийн бага эмч	5	
13	Урьдчилан сэргийлэх тарилгаас татгалзсан тухай мэдээлэх хуудас	ӨЭ-6.Б	Өрх, сумын эмч, өрхийн сувилагч, сумын болон багийн бага эмч	5	5
14	Хүүхдийн урьдчилан сэргийлэх тарилгын гэрчилгээ	ӨЭ-7	Вакцины сувилагч	15	15
15	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бүртгэл	ӨЭ-8	Өрхийн их эмч, сувилагч	5	5
16	Хөгжлийн бэрхшээлтэй хүний ахиц дэвшлийг үнэлэх маягт	ӨЭ-9	Өрхийн их эмч, сувилагч	5	5
17	Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүст үзүүлсэн тусламжийн бүртгэл	ӨЭ-10	Өрхийн их эмч, сувилагч	5	5
18	18, 36 сартай хүүхдийн эрүүл мэндийн цогц үзлэгийн маягт	ӨЭ-11	Их эмч	5	5
19	Гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээний бүртгэл	ӨЭ-12	Их эмч, сувилагч	5	5
20	Гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээний хяналтын карт	ӨЭ-13	Их эмч, сувилагч	5	5
21	Эмчийн үзлэгийн бүртгэл	АМ-1А	Их эмч	5	5
22	Халдварт өвчин, хамшинж, сэжигтэй тохиолдлыг мэдээлэх хуудас	АМ-2	Их эмч	5	5
23	БЗДХ-ыг мэдээлэх хуудас	АМ-3	Их эмч	5	5
24	Нас барсан тухай эмнэлгийн гэрчилгээ	АМ-7	Их эмч	20	20
25	Эмнэлгийн магадлагаа	АМ-8	Их эмч	/-/	/-/
26	Энгийн эмийн жор	АМ-9А	Их эмч	1	/-/

27	Мансууруулах эмийн жор	АМ-9Б	Их эмч	1	/-/
28	Хяналтын карт / диспансерийн /	АМ-11	Их эмч	Байнга	Байнга
29	Эмнэлэгт өвчтөн илгээх хуудас	АМ-13А	Их эмч	Өвчний түүхийн хамт	Өвчний түүхийн хамт
30	Эмнэлгээс өвчтөн илгээх хуудас	АМ-13Б	Их эмч	1	/-/
31	Эмнэлэгт өвчтөн илгээх цахим бүртгэлийн хуудас	АМ-13В	Их эмч	1	/-/
32	Жирэмсэн эмэгтэйчүүдийн бүртгэл	АМ-14	Хяналтын эмч, эх баригч бага эмч	5	5
33	Жирэмсэн эмэгтэйчүүдийн хяналтын хөтөч	АМ-15	Хяналтын эмч, эх баригч бага эмч	5	/-/
34	Солилцох хуудас	АМ-16	Хяналтын эмч, эх баригч бага эмч	Төрөлтийн түүхийн хамт	/-/
35	Эхийн эндэгдэл, ноцтой хүндрэлийг мэдээлэх маягт	АМ-17	Их эмч	5	/-/
36	Амбулаториор эмчлүүлэгсдийн карт	АМ-20	Их эмч, сувилагч	/-/	/-/
37	Шинжилгээнд явуулах бичиг	АМ-21/А-Б/	Их эмч, сувилагч	/-/	/-/
38	Хөнгөвчлөх эмчилгээнд хамрагсдын бүртгэл /амбулаторит/	АМ-26А	Их эмч, сувилагч	10	10
39	Настны эрүүл мэндийн бүртгэл	АМ-28	Өрхийн их эмч, сувилагч	5	5
40	Өдрийн эмчилгээний бүртгэл /хүүхэд/	АМ-30А	Их эмч	10	10
41	Өдрийн эмчилгээний бүртгэл /насанд хүрэгчид/	АМ-30Б	Их эмч	10	10
42	29 хоногоос 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг мэдээлэх хуудас	АМ-31	Их эмч	5	5
43	29 хоногоос 5 хүртэлх насны хүүхдийн төрөлхийн хөгжлийн гажгийг мэдээлэх хуудас	АМ-32	Их эмч	5	5

44	Осол гэмтлийн тохиолдлыг бүртгэх хуудас	АМ-33	Их эмч, сувилагч	10	10
45	Бүх нийтээр тэмдэглэх баяр, тэмдэглэлт өдрийн амралтын үеийн эмнэлгийн тусламж, үйлчилгээг мэдээлэх бүртгэл	АМ-36	Их эмч, сувилагч	5	5
46	5 хүртэлх насны хүүхдийн эрт илрүүлэг үзлэгийн маягт	ЭИМ-1	Их эмч	5	5
47	5-18 хүртэлх насны хүүхэд, өсвөр үеийнхний эрт илрүүлэг үзлэгийн маягт	ЭИМ-2	Их эмч	5	5
48	Насанд хүрэгчдийн эрт илрүүлэг үзлэгийн маягт	ЭИМ-3	Их эмч, сувилагч	5	5
49	Артерийн гипертензи, чихрийн шижин хэв шинж 2-ийн эрт илрүүлгийн үзлэгийн бүртгэл	ЭИМ-3.1А	Их эмч, сувилагч	5	5
50	Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгийн маягт	ЭИМ-4.1	Их эмч, сувилагч	5	5
51	Хөхний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгийн маягт	ЭИМ-5.1	Их эмч, сувилагч	5	5

Б. АМБУЛАТОРИ ПОЛИКЛИНИКТ ХӨТЛӨГДӨХ БҮРТГЭЛИЙН МАЯГТ

1	Эмчийн үзлэгийн бүртгэл	АМ-1Б	Их эмч	5	5
2	БЗДХ-ын кабинетын эмчийн үзлэгийн бүртгэл	АМ-1В	Их эмч, сувилагч	5	5
3	Халдварт өвчин, хамшинж, сэжигтэй тохиолдлыг мэдээлэх хуудас	АМ-2.А	Их эмч	5	5
4	Вируст хепатитын сэжигтэй тохиолдлыг мэдээлэх хуудас	АМ-2.Б	Их эмч	5	5
5	БЗДХ-ыг мэдээлэх хуудас	АМ-3	Их эмч	5	5
6	Шинээр илэрсэн сүрьеэ өвчнийг мэдээлэх хуудас	АМ-4	Их эмч	5	5
7	Хорт хавдрыг мэдээлэх хуудас	АМ-5	Их эмч	5	5
8	Гемодиализын хяналтын карт	АМ-6	Их эмч	5	5
9	Нас барсан тухай эмнэлгийн гэрчилгээ	АМ-7	Их эмч, статистикч их эмч	20	20
10	Эмнэлгийн магадлагаа	АМ-8	Их эмч	/-/	/-/
11	Эмийн жор	АМ-9А	Их эмч	1	/-/
12	Мансууруулах эмийн жор	АМ-9Б	Их эмч	1	/-/
13	Уламжлалт эмийн жор	АМ-9В	Их эмч	1	/-/
14	Эрүүл мэндийн хуудас	АМ-10	Их эмч	1	/-/
15	Хяналтын карт /диспансерийн /	АМ-11	Их эмч	Байнга	Байнга
16	Эмнэлэг хяналтын комиссоор орогчдын бүртгэл	АМ-12А	Эмч нарын комиссын нарийн бичгийн дарга	20	20
17	Комиссын шийдвэр	АМ-12Б	Эмч нарын комиссын нарийн бичгийн дарга	5	/-/

18	Эмнэлэгт өвчтөн илгээх хуудас	АМ-13А	Их эмч	Өвчний түүхийн хамт	Өвчний түүхийн хамт
19	Эмнэлгээс өвчтөн илгээх хуудас	АМ-13Б	Их эмч	-	-
20	Эмнэлэгт өвчтөн илгээх цахим бүртгэлийн маягт	АМ-13В	Их эмч	1	/-/
21	Жирэмсэн эмэгтэйчүүдийн бүртгэл	АМ-14А	Хяналтын эмч, эх баригч бага эмч	5	5
22	Тэмбүүгийн халдвартай жирэмсэн эмэгтэйн хяналтын бүртгэл	АМ-14Б	Хяналтын эмч, эх баригч бага эмч	5	5
23	Амаржих газар /төрөх тасаг/ тэмбүү илрүүлэх шинжилгээний бүртгэл	АМ-14В	Эх барих эмэгтэйчүүдийн эмч, эх баригч бага эмч	5	5
24	Жирэмсэн эмэгтэйчүүдийн хяналтын хөтөч	АМ-15	Хяналтын эмч, эх баригч бага эмч	5	/-/
25	Солилцох хуудас	АМ-16	Хяналтын эмч, эх баригч бага эмч	Төрөлтийн түүх хамт	/-/
26	Эхийн эндэгдэл, ноцтой хүндрэлийг мэдээлэх маягт	АМ-17	Их эмч	5	/-/
27	Үр хөндөлтийн түүх	АМ-18	Их эмч	5	5
28	Үр хөндөлтийн бүртгэл	АМ-19	Их эмч, сувилагч	5	5
29	Амбулаториор эмчлүүлэгсдийн карт	АМ-20	Их эмч, эх баригч бага эмч	2	2
30	Шинжилгээнд явуулах бичиг	АМ-21 (А-Г)	Их эмч, сувилагч	/-/	/-/
31	Лабораторийн шинжилгээний хуудсууд	АМ-22 (А-М)	Лаборант	/-/	/-/
32	Лабораторийн шинжилгээний бүртгэл	АМ-23	Их эмч, лаборант	5	10
33	Үйл оношийн кабинетийн шинжилгээний бүртгэл	АМ-24А	Их эмч, сувилагч	5	10
34	Хэвлийн хөндийн эрхтнүүдийн хэт авиан оношилгоо	АМ-24Б	Их эмч, сувилагч	5	10
35	Сэргээн засах эмчилгээний карт	АМ-25А	Их эмч, сувилагч	5	/-/

36	Сэргээн засах эмчилгээний бүртгэл	АМ-25Б	Их эмч, сувилагч	5	5
37	Хөнгөвчлөх эмчилгээнд хамрагсдын бүртгэл /амбулаторит/	АМ-26А	Их эмч, сувилагч	2	2
38	Хөнгөвчлөх эмчилгээнд хамрагсдын бүртгэл /стационарт/	АМ-26Б	Их эмч, сувилагч	2	2
39	Насны эрүүл мэндийн бүртгэл	АМ-27	Их эмч, сувилагч	10	10
40	Зүү засал эмчилгээний карт	АМ-28А	Их эмч	5	5
41	Төөнө засал эмчилгээний карт	АМ-28Б	Их эмч	5	5
42	Дэвтээлгэ засал эмчилгээний карт	АМ-29А	Их эмч	5	5
43	Бариа засал эмчилгээний карт	АМ29Б	Их эмч	5	5
44	Хатгах засал эмчилгээний карт	АМ-29В	Их эмч	5	5
45	Өдрийн эмчилгээний бүртгэл /хүүхэд/	АМ-30А	Их эмч	5	5
46	Өдрийн эмчилгээний бүртгэл /насанд хүрэгчид/	АМ-30Б	Их эмч	5	5
47	29 хоногоос 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг мэдээлэх хуудас	АМ-31	Их эмч	5	5
48	29 хоногоос 5 хүртэлх насны хүүхдийн төрөлхийн хөгжлийн гажгийг мэдээлэх хуудас	АМ-32	Их эмч	5	5
49	Осол гэмтлийн тохиолдлыг бүртгэх хуудас	АМ-33	Их эмч, сувилагч	10	10
50	Хөдөлгөөн заслын үнэлгээний хуудас	АМ-34	хөдөлгөөн засалч	5	5
51	Хөдөлмөр заслын үнэлгээний хуудас	АМ-35	хөдөлмөр засалч	5	5
52	Бүх нийтээр тэмдэглэх баяр, тэмдэглэлт өдрийн амралтын үеийн эмнэлгийн тусламж, үйлчилгээг мэдээлэх бүртгэл	АМ-36	Их эмч, сувилагч	5	5
53	Нүүр амны эмчлэгч эмчийн эмчилгээний бүртгэл	АМ-37	Их эмч	5	5
54	Нүүр амны мэс заслын эмчийн эмчилгээний бүртгэл	АМ-38	Их эмч	5	5

55	Нүүр амны согог заслын эмчийн эмчилгээний бүртгэл	АМ-39	Их эмч		
56	Нүүр амны гажиг заслын эмчийн эмчилгээний бүртгэл	АМ-40	Их эмч	5	5
57	Нүүр амны урьдчилан сэргийлэх үзлэгийн бүртгэл	АМ-41	Их эмч	5	5
58	Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгийн маягт	ЭИМ-4.2	Эх барих эмэгтэйчүүдийн эмч	5	5
59	Хөхний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгийн маягт	ЭИМ-5.2	Мэс заслын эмч, Хавдрын эмч	5	5

В. СТАЦИОНАРТ ХӨТЛӨГДӨХ БҮРТГЭЛИЙН МАЯГТ

1	Өвчний түүх	СТ-1	Эмчлэгч эмч	50	50
	Дотрын эмчийн үзлэгийн хуудас		Эмчлэгч эмч	50	50
Эмэгтэйг жирэмсний хяналтад үзүүлэхэд нь нөхөртэйгээ ирэхийг зөвлөж хоёуланд нь дэвтрийг хэрхэн ашиглах талаар тайлбарлана.

Төрсний дараах эрүүл мэнд: Төрсний дараах эхийн эрүүл мэндийн хяналтийг төрсний дараах гэрийн эргэлтийн төлөвлөгөөний дагуу 24-72 цагийн дотор хянана.

Тав хүртэлх хүүхдийн эрүүл мэндийн хяналт

Хүүхдийн хяналт: Эмнэлгийн мэргэжилтэн хүүхдийг эхийн хэвлийд бүрэлдэх үеэс эхлээд 6 нас хүртэлх өсөлт хөгжил, хоол тэжээл, хүүхдийн хөгжил, эрүүл мэндийн байдлыг хянаж үнэлэн, дэвтэрт тэмдэглэнэ. Эмнэлгийн мэргэжилтэн **эрүүл** хүүхдийг Эрүүл мэндийн сайдын баталсан гэрийн эргэлтийн төлөвлөгөөний дагуу 1 хүртэлх сартай хүүхдийг сард 4 удаа, 2 сартай хүүхдийг сард 2 удаа, 3 сартайгаас 1 нас хүртэл сар тутам, 1-2 настай хүүхдийг улиралд нэг удаа гэрээр эргэнэ.

Санамж: **Гэрийн эргэлтийг заавал гэрт очиж хийнэ.**

Гэрийн эргэлт бол эрүүл хүүхдийн хяналт гэдгийг сана. Эмнэлгийн мэргэжилтэн гэрийн эргэлтээр хүүхдийн биеийн байдал, хоол тэжээл, өсөлт хөгжил, хүүхдийн хөгжил, гэрийн таатай орчин, аюулгүй байдал, эцэг эх, ах, эгчийн сэтгэл санааны байдал, шинэ хүүхэддээ хэрхэн дасах зэрэг олон зүйлийг хянаж үнэлэн тохирсон зөвлөгөө, мэдээлэл өгөх юм. Эмнэлгийн мэргэжилтэн гэрийн эргэлт болон эрүүл мэндийн байгууллагад хүүхдийг ирэх үед нь эрүүл мэндийн байдлыг тухайн насанд тохирсон гэрийн эргэлтийн үнэлгээний хуудсаар хянаж, эрүүл мэндийн талаар “5 хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр”-т тэмдэглэнэ. Хэрвээ хүүхэд гэрийн эргэлтийн үед өвчтэй байвал ХӨЦМ-ийн дагуу үнэлж эмчилгээг шийднэ.

Анхаар: ХӨЦМ-ийн дагуу үнэлэх боломжгүй бол Өвчний карт нээн тэмдэглэл хөтлөн эмчилгээний асуудлыг шийд. “5 хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр” бол эрүүл хүүхдийн хяналтын дэвтэр **өвчний карт биш гэдгийг сана.**

Нэг хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн хяналт

Нярайн эрүүл мэндийн хяналт: Амаржих газраас гэртээ гарсаны дараах 24-72 цагийн дотор гэрийн эргэлт хийж, нярайд эрүүл мэндийн үнэлгээ хийнэ. Энэ бол гэрийн анхны эргэлт юм. Анхны гэрийн эргэлтийг эмч, сувилагч хамт хийнэ. Анхны эргэлтээр эх, нярайн эрүүл мэндийг хамт хянана. Эргэлтээр төрсний дараах 24-72 цагийн гэрийн эргэлтийн өмнөх асуумж, эрүүл мэндийн ажилтанд зориулсан эргэлтийн үнэлгээний дагуу нярайн эрүүл мэндийн байдлыг үнэлж, эцэг эхэд өгөх зөвлөмжийг ашиглан зөвлөгөө өгнө.

Эцэг эхэд зориулсан гэрийн эргэлтийн өмнөх асуумжийн хуудас хөтлөх заавар

Гэрийн эргэлтийн өмнөх асуумжийн хуудас 3 хэсэгтэй.

1. Та хүүхдийнхээ эрүүл мэндийн талаар мэдэхийг хүсч байгаа мэдээллээ эмнэлгийн мэргэжилтэн гэрийн эргэлтээр ирэх үед эцэг эхийн зүгээс асуух асуулт болон зөвлөгөө авах зүйлээ тэмдэглэх юм. Үүнд:
   - Эхийн сэтгэл санааны байдал, хүүхэддээ дасах, хооллох, аюулгүй байдал, гэр бүлийн талаар асуух асуултын өмнөх □ энэ нүдэнд √ тэмдгээр тэмдэглэнэ.
2. Таны хүүхдийн тухай асуумжийн тийм, үгүй, мэдэхгүй гэсэн хариултын өмнөх □ энэ нүдэнд √ тэмдгээр тэмдэглэнэ.
3. Хүүхдийн хөгжлийн тухай асуумжийн тийм үгүй гэсэн хариултын өмнөх □ энэ нүдэнд √ тэмдгээр тэмдэглэнэ.

Эрүүл мэндийн ажилтанд зориулсан гэрийн эргэлтийн үнэлгээний хуудас хөтлөх заавар

1. Паспортын хэсгийг эцэг эхээс асууж үнэлнэ. Эцэг эх хүүхдийн нэр, харилцах хэлийг сонгож тэмдэглэнэ. Гэрийн эргэлтээр очсон он сар өдрийг тэмдэглэнэ.

<u>Өсөлтийг хэмжиж тэмдэглэнэ:</u> Хүүхдийн биеийн жинг хэмжин, килограммаар бичнэ. Жишээ нь: хүүхдийн жин 3 кг 700 гр байвал 3.7 кг гэж бичнэ.

<u>Хүүхдийн биеийн уртыг хэмжин тэмдэглэнэ:</u> Уртын хэмжээг сантиметрээр бичнэ. Жишээ нь: хүүхдийн өндөр 1 метр 12 см байвал 112 см гэж бичнэ.

<u>Хүүхдийн жин, уртын харьцааг тодорхойлно</u>: Биеийн жинг урт/өндөрт нь харьцуулсан харьцааг хэлнэ. Энэ үзүүлэлтээр туранхай, илүүдэл жин, таргалалтыг илрүүлэх ач холбогдолтой. Мөн хүүхдийн хоол тэжээлийн цочмог дутлыг тодорхойлдог.

2. Төрөх үеийн түүхийг эцэг эхээс асуултын дагуу асууж тэмдэглэнэ. Тийм буюу шаардлагатай гэсэн хариултын өмнөх □ энэ нүдэнд √ тэмдгээр тэмдэглэнэ. Үгүй бол онгорхой байна.
3. Нийгэм гэр бүлийн байдал: Үүнийг үнэлэхдээ гэрийн эргэлтийн өмнөх асуумжийг заавал харна. Гэр бүлийн гишүүд шинэ хүүхэддээ дасаж байгаа болон ажил сургуульдаа орох талаар эцэг эхтэй ярилцаж тэмдэглэнэ. Эцэг эхэд сэтгэл гутралын шинж тэмдэг илэрсэн бол □ энэ нүдэнд √ тэмдгээр тэмдэглэнэ.
4. Хүүхдийн хоол тэжээл ба ерөнхий байдал тийм, хэвийн хамрагдсан гэсэн хариултын өмнөх □ энэ нүдэнд √ тэмдгээр тэмдэглэнэ. Үгүй бол онгорхой байна.
5. Бодит үзлэг: Эмнэлгийн мэргэжилтэн бодит үзлэгийг ЗААВАЛ хийнэ. Үзлэг хийхдээ хүүхдийн эх болон гэр бүлийн гишүүдийг хамт байлцуулна. Хүүхэд эрүүл бол “Эрүүл” гэсэн хариултын өмнөх □ энэ нүдэнд √ тэмдгээр тэмдэглэнэ. Өвчтэй бол өөрчлөлт илэрсэн хэсэгт тэмдэглэнэ.
6. Үнэлгээний хэсэгт хүүхэд эрүүл бол “Эрүүл” гэсэн хариултын өмнөх □ энэ нүдэнд √ тэмдгээр тэмдэглэнэ. Өвчтэй бол ХӨЦМ-ийн дагуу үнэлэн ангилал, бусад өвчин илэрвэл тухайн өвчний онош, өсөлт хөгжлийн хоцрогдолтой бол тураал, туранхай, өсөлтийн хоцрогдол болон хоол тэжээлийн дутагдалтай эсэхийг тэмдэглэнэ.
7. Зөвлөгөө мэдээлэл хэсэгт гэрийн эргэлтээр эмнэлгийн мэргэжилтэн өгсөн зөвлөгөөгөө мэдээллээ □ нүдэнд √ тэмдгээр тэмдэглэнэ. Зөвлөгөө өгөхдөө 5 хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр дээрх эцэг эхэд өгөх хүүхдийн насанд тохирох зөвлөмжийн талаар ярилцах, тараах материал өгч болно. Нярайг хөхүүлэх, хуурайлах, угаах, гэрийн аюулгүй таатай орчин, хүүхдэд илрэх аюултай шинжүүдийн талаар зөвлөгөө өгнө. Энэ үед хүүхдийг эхийн сүүгээр дагнан хооллохын чухлыг гэр бүлд ойлгуулж, эхэд шим тэжээллэг хоол идүүлж давтамжийг нэмэгдүүлэх, тайван байлгах талаар зөвлөнө. Гэрийн эргэлтийн өмнөх хуудсыг хэрхэн бөглөх талаар зөвлө.

8. Цаашид авах арга хэмжээний хэсэгт тухайн гэрийн эргэлтийн үнэлгээний байдалд дүгнэлт хийн тухайн үед авсан болон цаашид авах арга хэмжээний талаар тэмдэглэнэ.
9. Гэрийн эргэлтээр очсон эмч, сувилагч нэрээ тод бичиж гарын үсгээ зурна. Мөн эцэг эхийн аль нэгний гарын үсгийг авч баталгаажуулна.
10. Мөн хүүхдээ иргэний бүртгэлд бүртгүүлж, төрсний гэрчилгээ авахыг гэр бүлд нь сануулаарай.

Нэг наснаас тав хүртэлх насны хүүхдийн хяналт

Хүүхдийг нэг нас хүртэл гэрээр болон ӨЭМТ-д ирүүлэн сар бүр үзлэг хийж, дараах хүснэгтэд тэмдэглэнэ.

ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗЛЭГ

(Эрүүл мэндийн үзлэгийг

20 ..... оны ..... сарын ..... нд хүүхэд ..... сар ..... өдөртэй байхад хийв)

Толгойн тойрог: ..... см	Цус багадалт +/-	Хооллолт: □ Сайн □ Хооллолтын бэрхшээлтэй
E D C B A A B C D E E D C B A A B C D E		Хажуугийн зурагт цоорсон эсвэл хэвийн бус шүдийг “X” гэж тэмдэглэнэ үү.
		Шүд: □ эрүүл / □ эмчилгээ шаардлагатай (шүдний тоо .....)
		Шүдний ариун цэврийн байдал: □ Сайн □ Дунд □ Муу
		Буйл/ завьж: □ Хэвийн □ хэвийн бус
Ерөнхий эрүүл мэндийн байдал: □ Эрүүл / □ тогтмол хяналт шаардлагатай		
Вакцин: ..... он ..... сар ..... өдөр		
Эрүүл мэндийн байгууллага эсвэл эмчийн нэр:		

<u>Заавар:</u>

1. Эмнэлгийн мэргэжилтний хүүхдэд эрүүл мэндийн үзлэг хийсэн он сар өдрийг тэмдэглэнэ.
2. Толгойн тойргийг туузан метрээр хэмжиж см-ийг тэмдэглэнэ.
3. Цус багадалттай бол (+) цус багадалтгүй бол (-) гэж тэмдэглэнэ.
4. Хооллолтын бэрхшээлтэй бол □ нүдэнд (√) зөвлөх тэмдгээр тэмдэглэнэ.
5. Шүдний эрүүл мэндийг үнэлнэ. Үүнд:
   - Цооролттой шүд бол | E | X | “X” гэж тэмдэглэнэ.
   - Шүдний эрүүл болон эмчлэх шаардлагатай шүдний тоог бичнэ.
   - Шүдний ариун цэврийг Сайн, Дунд, Муу үнэлгээн дээр □ нүдэнд (√) зөвлөх тэмдгээр тэмдэглэнэ.
   - Буйл, завьжийг хэвийн, хэвийн бус үнэлгээгээр □ нүдэнд (√) зөвлөх тэмдгээр тэмдэглэнэ.

- Ерөнхий биеийн байдал эрүүл бол □ нүдэнд (√) зөвлөх тэмдгээр тэмдэглэнэ.
- Вакцин хийсэн өдрийн он сар өдрийг тэмдэглэнэ.
- Үзлэг хийсэн эмч нэрээ гаргацтай тодорхой бичнэ.

Хүүхдийн өсөлт ба хоол тэжээлийн хөтөлбөрт хамрагдсан талаар тэмдэглэл

Одоогийн нас (сараар)	Өсөлтийн үнэлгээнд хамрагдсан хугацаа (өдөр/сар/он)	Хэмжилт (Тоог бичээд дараа нь өсөлтйн хүснэгтүүд дээр цэгээр тэмдэглэнэ)					Аминдэм, ОН бичил тэжээлийн хангалт			Хөгжлийн үнэлгээ (+, -)	Өвчлөл (A,C, A1, C1, Б)	Хүүхэд хамгаалал (+, -)	Үнэлгээнд ямар хэлбэрээр хамрагдсан, ажиглалт
		Жин (кг)	Урт, өндөр (см)	Бугалганы тойрог	Өсөлтийн үнэлгээ	2 хөлийн хаван (+, -)	Д аминдэм (+, -)	А аминдэм (+, -)	ОНБТ				
14 сар													
16 сар													
18 сар													

Хүснэгтэд тэмдэглэгээ хийхдээ эцэг эх, асран халамжлагчийг аль болох оролцуулах нь чухал.

1. Хоол тэжээл, өсөлт хөгжил, хөгжлийн үнэлгээ хийлгүүлж буй хүүхдийн одоогийн нас сараар.
2. Үзлэг хийсэн он сар эрүүл мэндийн ажилтан хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжил, хоол тэжээл, хөгжлийг үнэлж хянахаар гэрээр нь очсон эсвэл хүүхэд эцэг эхийн хамт ЭМТ-д ирсэн он сар өдөр.
3. Хэмжилт:
   - Өсөлтийн хяналтад хамрагдаж буй хүүхдийн биеийн жинг хэмжиж, жинг килограммаар бичнэ. Жишээ нь: хүүхдийн жин 4 кг 700 гр байвал 4.7 кг гэж бичнэ.
   - Өсөлтийн хяналтад хамрагдаж буй хүүхдийн биеийн урт эсвэл өндрийг хэмжиж хэмжээг сантиметрээр бичнэ. Жишээ нь: хүүхдийн өндөр 1 метр 12 см байвал 112 см гэж бичнэ.
   - Хүүхдийн хоёр хөлд хаван байгаа эсэхийг тодруулж бичнэ. Бүртгэлийн цонхонд хаван байгаа бол (+), байхгүй бол (-) гэж тэмдэглэнэ.
4. Амин дэм бичил бодисын хангалт:
   - А аминдэм уусан эсэх: Тухайн сард А аминдэм уусан 6-59 сартай хүүхдийн мэдээлэл (100,000-200,000 ОУН А аминдэмийг жил бүрийн 5 болон 11 дүгээр саруудад 6-59 сартай хүүхдүүдэд кампаничлан уулгадаг. Энэ нүдэнд А аминдэм уусан бол (+), уугаагүй бол (-) гэж тэмдэглэнэ.
   - Д аминдэм уусан эсэх: Тухайн сард Д аминдэм уусан 0-36 сартай хүүхдийн мэдээлэл (50000 ОУН Д2 аминдэмийг урьдчилан сэргийлэх тунгаар сар бүр). Өндөр тунт Д2 аминдэм хүрэлцээгүй тохиолдолд Д3 аминдэмийг эмчийн зааврын

дагуу дуслаар уух ба энэ тохиолдлыг мөн Д аминдэмийг уусан хэмээн бүртгэнэ. Энэ нүдэнд Д аминдэм уусан бол (+), уугаагүй бол (-) гэж тэмдэглэнэ.

- Олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэл (ОНБТ) авсан эсэх: Бүртгэлийн цонхонд ОНБТ уусан бол (+), уугаагүй бол (-) тэмдэг бичнэ.

5. Хооллолтын байдал (Д,Т,Х,Н):

0-6 сартай хүүхдийн хувьд Д, Т, Х, Н үсгийн аль нэг тэмдэглэгдэнэ. Үүнд:

Д – Эхийн сүүгээр дагнан хооллож (Эхийн хөхний сүүнээс өөр бусад шингэн, ус, цай, шүүс зэргийг огт авахгүй байхыг хэлнэ) байгаа,

Т – Эхийн сүү орлуулагчаар дагнан хооллож байгаа,

Х- Эхийн сүүний зэрэгцээ эхийн сүү орлуулагчаар хооллож байгаа буюу холимог хооллолт,

Н - 6 сар хүрэхээс өмнө нэмэгдэл хоолонд орсон

6. Хөгжлийн үнэлгээ:
5 хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн хөх хуудасны “МИНИЙ ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ ..... САРТАЙДАА” хэсэг дэх хүүхдийн хөгжлийн үзүүлэлтүүдийг тийм/үгүй гэсэн тэмдэглэгээг дугуйлж зурах талаар гэр бүлийн гишүүд эцэг эхэд зааж өгч ЭМТ-д үзүүлэхээр ирэхдээ тэмдэглэж ирэхийг анхааруулна. Асуумжийн дагуу бөглөж, (+) гэж тэмдэглэх ба бөглөөгүй бол (-) гэж тэмдэглэнэ. Тухайн насны хөгжлийн үзүүлэлтүүдийг хийж чадаж байгаа эсэхийг шалгаж, аль нэгийг нь эсвэл хэсэг бүлгийг нь хийж чадахгүй (Хөгжлийн хоцрогдолтой) хүүхдийг дэвтэрт тэмдэглэж дараагийн сар хүртэл хянана. Хүүхдийн хөгжлийн энэхүү үзүүлэлтүүд нь тус дэвтрийн маш чухал хэсэг бөгөөд хүүхдийн танин мэдэхүй, оюуны хөгжлийг зөв үнэлж, дүгнэснээр хүүхдийн хөгжлийн хоцрогдлыг эрт таньж, хөгжлийн бэрхшээлтэй болохоос сэргийлэх чухал хэрэгсэл болно.
7. Өвчлөлийн байдал:

Тухайн сард ямар нэг өвчнөөр өвчилсөн бол А, А1, С, С1, Б үсгийн аль нэгийг тэмдэглэгдэнэ.

А Тухайн сард амьсгалын цочмог халдвараар өвчилсөн (Тухайн сард хүүхэд хэдэн удаа өвчилснийг тооцохгүй).

А1 Тухайн сард амьсгалын цочмог халдвараар өвчилж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан хүүхэд (Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ гэдэгт өвчний улмаас эмнэлэг, эмчид хандах, эм бичүүлж эмийн сангаас авч хэрэглэснийг хэлнэ. Тухайн сард хүүхэд хэдэн удаа өвчилснийг тооцохгүй).

С Тухайн сард суулгалтаар өвчилсөн (тухайн сард хүүхэд хэдэн удаа өвдсөнийг тооцохгүй).

С1 Тухайн сард суулгалтаар өвчилж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авсан хүүхэд (Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ гэдэгт суулгалтын улмаас эмнэлэг, эмчид хандах, эм бичүүлж эмийн сангаас авч хэрэглэснийг хэлнэ. (Тухайн сард хүүхэд хэдэн удаа өвдсөнийг тооцохгүй).

Б Тухайн сард хүүхдийн эрүүл мэнд, өсөлт, бойжилтод ороход нөлөөлөхүйц өвчнөөр өвчилсөн бол Б гэж тэмдэглэнэ (цочмог халдварт өвчин орно).

8. Хүүхэд хамгаалал:

- Хүүхдийг үзэх, жинлэх явцад хувцсыг нь тайлахдаа хүүхдийн биед илэрч буй ямар нэг гэмтлийн шинж байвал гэмтлийн зэргийг харгалзахгүйгээр (+) гэж тэмдэглэнэ. Гэмтэлгүй бол (-) гэж тэмдэглэнэ.
- 5 хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр дэх эцэг, эхэд зориулсан асаргаа сувилгааны талаарх зөвлөмжийг эцэг эхээс асууж, лавлан, ойлгоогүй зүйлийг дахин хэлж тайлбарлана.
- Эцэг эх, асран халамжлагчаас хүүхдээ өсгөж бойжуулахад ямар бэрхшээл байгаа болон хүүхдийнхээ талаар сэтгэл зовнисон асуудал байгаа эсэхийг асууж, зөвлөлдөх нь маш чухал.
- Гэр бүлийн гишүүд “5 хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр”-ийг тогтмол ашиглаж, хүүхдийнхээ өсөлт хөгжил, эрүүл мэндийг хянаж байх нь хүүхдийн эсэн мэнд өсөж бойжих үндэс юм.
- Дээрх хүснэгтийг бөглөхдөө хүүхдийнхээ дэргэд байж тэмдэглэх ба жин урт өндрийг тэмдэглэхийн өмнө уг дэвтрийн арын хуудас дахь өсөлтийн хүснэгтэд цэглэн тэмдэглэгээ хийнэ.

Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч хүүхдийн эрүүл мэндийн дүгнэлтийг дараах насанд хийнэ

Нярай хүүхдийг төрсний дараах 7 хоногт амаржих газрын нярайн эмч болон өрхийн эмч “Тав хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр”-т байгаа нярайн эрүүл мэндийн хуудас бөглөн, эрүүл мэндийн байдалд дүгнэлт хийж, 1 хувийг амаржих газрын нярайн түүхийн хамт хадгална.

Хүүхдийг нэг нас хүрэхэд өрхийн эмч хүүхдийн эрүүл мэндийн байдалд дүгнэлт гарган “Тав хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр”-т 2 хувь дүгнэлт бичиж, нэг хувийг ЭМТ дээрээ хадгална.

Хүүхдийг 18 сартай, 36 сартайд иж бүрэн үзлэгт хамруулна. Иж бүрэн үзлэгийг өрх, сумын ЭМТ нэгдсэн журмаар төлөвлөгөө гарган зохион байгуулна.

Таван нас хүрэхэд өрхийн эмч хүүхдийн эрүүл мэндийн байдалд дахин дүгнэлт гаргана.

Дархлаажуулалт

Өрх сумын эмч, ээлжит үзлэгийн үед дархлаажуулалтад хугацаандаа хамрагдсан эсэхийг шалгаж “Тав хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр”-т тэмдэглэх ба хамрагдаагүй бол хэрхэн дархлаажуулалтад орохыг зөвлөх болон дархлаажуулалтын ач холбогдлыг эцэг эхэд тайлбарлаж өгнө.

ЗААВАЛ ХИЙХ ДАРХЛААЖУУЛАЛТЫН ТОВЛОЛ

Товлол	Сэргийлэх арга	Хийх вакцин (√)	Эмчийн үзлэгийн тэмдэглэл	Хийсэн огноо, цаг, минут	Вакцин аторын нэр
Төрсний дараа 24 цагийн дотор	Сүрьеэ	☐			
	В вируст гипатит 0 тун	☐			
	Халдварт саа 0 тун	☐			
2 сартайд	Халдварт саа I тун	☐			
	Таван (Сахуу, хөхүүл ханиад, татран, В вируст гепатит,хемофилюс инфлюенза В) вакцин I тун	☐			
	Пневмококкийн эсрэг вакцин I тун	☐			
3 сартайд	Халдварт саа II тун	☐			
	Таван (Сахуу, хөхүүл ханиад, татран, В вируст гепатит, хемофилюс инфлюенза В) вакцин II тун	☐			
4 сартайд	Халдварт саа III тун	☐			
	Таван (Сахуу, хөхүүл ханиад, татран, В вируст гепатит, хемофилюс инфлюенза В) вакцин III тун	☐			
	Пневмококкийн эсрэг вакцин II тун	☐			
5 сартайд	Халдварт саа IV тун	☐			
9 сартайд	Улаанбурхан, гахай хавдар, улаануд I тун	☐			
	Пневмококкийн эсрэг вакцин III тун	☐			
1нас 2 сартайд	А вируст гепатит I тун	☐			
2 настайд	Улаанбурхан, гахай хавдар, улаануд II тун	☐			
	А вируст гепатит II тун	☐			
7 настайд	Сахуу, татран I тун	☐			
15 настайд	Сахуу, татран II тун	☐			
Бусад вакцин (Бичих)					

Дархлаажуулалтын товлолын дагуу эрүүл мэндийн үзлэг хийж, тэмдэглэхдээ хүүхдэд эрүүл мэндийн үзлэг хийсэн эмч нэрээ гаргацтай бичиж, үзлэг хийсэн он сар өдрийг бичнэ. Дархлаажуулалтын товлолын дагуу хүүхдийн товлосон насанд заавал хийх вакцины нэрний ард байгаа □ нүдэнд (√) зөвлөх тэмдгээр тэмдэглэн, вакцин хийсэн огноо цаг минутыг заавал бичнэ. Вакцинатор нэрээ гаргацтай бичнэ.

Хүүхдэд хэмжилт хийх

Хүүхэд бүрийн өсөлт, хөгжил тухайн хүүхдийн биеийн онцлогоос хамаарч янз бүр байдаг. Хүүхдийн биеийн байдал, өсөлт, хөгжлийг төрсний дараах эхний 2 сарын дотор 6 удаа, түүнээс хойш сар бүр гэрийн идэвхтэй эргэлт, амбулаторийн үзлэг, дархлаажуулалтын үед тогтмол үнэлж, хянаснаар хүүхдийн биеийн өсөлтийн хоцрогдол, хоол тэжээлийн цочмог дутлыг илрүүлэх ач холбогдолтой.

0-5 хүртэлх насны хүүхдийн өсөлт, хөгжлийг:

- Урт/өндөр–нас
- Жин–нас
- Жин - урт/өндөр
- БЖИ (биеийн жингийн индекс) – нас гэсэн дөрвөн үзүүлэлтээр үнэлнэ. Урт/өндрийг см-аар, жинг кг-аар илэрхийлдэг.

Зураг. Хүүхдийн өсөлтийг үнэлэх хүснэгт

<u>Хүүхдийн биеийн урт/өндөр-насны үзүүлэлт нь:</u> 2 хүртэлх насны хүүхдэд уртыг, 2-оос дээш насны хүүхдэд өндрийг хэмжиж, насанд нь харьцуулсан харьцааг хэлнэ. Энэ үзүүлэлтээр хүүхдийн"өсөлт хоцролт", намханыг тодорхойлно. Хүүхэд хэт өндөр байх нь ховор тохиолдох бөгөөд энэ нь дотоод шүүрлийн эмгэг байж болзошгүйг илтгэнэ.

<u>Хүүхдийн биеийн жин-насны үзүүлэлт нь</u> хүүхдийн биеийн жинг насанд нь харьцуулсан харьцааг хэлнэ. Энэ үзүүлэлтээр "тураал"-ыг илрүүлдэг. Энэ үзүүлэлтээр илүүдэл жин, таргалалтыг үнэлэхгүй.

<u>Хүүхдийн жин-урт/өндрийн үзүүлэлт нь</u> биеийн жинг урт/өндөрт нь харьцуулсан харьцааг хэлнэ. Энэ үзүүлэлтээр "туранхай"-г илрүүлдэг. Энэ үзүүлэлтээр илүүдэл жин, таргалалтыг илрүүлэх ач холбогдолтой. Энэ үзүүлэлт дээр хүүхдийн хоёр хөлийн хаванг заавал шалгаж тэмдэглэнэ. Энэ нь хүүхдийн хоол тэжээлийн цочмог дутлыг тодорхойлдог.

"Тав хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр" дэх өсөлтийн хүснэгтэнд хүүхдийн өсөлт хөгжлийг тэмдэглэдэг. Хүүхдийн өсөлтийг үнэлэх хүснэгт нь 2 өөр өнгөтэй. Цэнхэр

хүснэгтийг эрэгтэй, ягаан хүснэгтийг эмэгтэй хүүхдийн өсөлтийг үнэлэхэд ашиглана. Өсөлтийн хүснэгт дэх ногоон шугам болох **“голч шугам”** өсөлтийн дунджийг заана. Өсөлтийн хүснэгт дэх ногоон, шар, улаан, хар шугамуудыг z онооны шугам гэж нэрлэдэг. Өсөлтийг тэмдэглэсэн цэгэн тэмдэглэл нь голч ногоон шугам руу ойртох тусам сайн үзүүлэлт, алслагдах тусам өсөлтийн асуудалтайг илэрхийлнэ.

Өсөлтийн хоёр буюу түүнээс олон цэгэн тэмдэглэлийг хооронд нь зураасаар холбосон холболтыг **өсөлтийн муруй** гэнэ. Энэ муруйгаар хүүхдийн өсөлтийн хандлагыг тодорхойлно.

Зураг. Жин-насны хүснэгтэд өсөлтийн муруйг тэмдэглэсэн байдал

Хүснэгт. Өсөлт, хөгжил, хоол тэжээлийн цочмогдутлыгүнэлэхүзүүлэлт

Z оноо (СХ)	Өсөлтийн үзүүлэлт		
	Урт/өндөр-нас	**Жин-нас**	**Жин-урт/өндөр**
3 – аасдээш	Хэт өндөр	-	Тарган
2-оос дээш	Өндөр	-	Илүүдэл жинтэй
1 – ээсдээш	Эрсдэл	Эрсдэл	Эрсдэл
0 (голч)	Хэвийн	Хэвийн	Хэвийн
-1-ээс доош	Эрсдэл	Эрсдэл	Эрсдэл
-2-оос доош	Өсөлт хоцрогдол/намхан	Тураал	Туранхай
-3-аас доош	Өсөлтийн хүнд хоцрогдол	Хүнд тураал	Хүнд тураал

Өсөлтийн муруйг ашиглан эцэг эх, асран халамжлагчид зөвлөгөө өгөх

Хүүхдийн өсөлт, хөгжлийн хэмжилт бүрийг 5 хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэрт тэмдэглэн тухайн хүүхдийн өсөлтийн байдлыг эцэг, эхчүүдэд мэдээлж, эрсдэлтэй буюу өөрчлөлттэй тохиолдол бүрийг эцэг эх, асран халамжлагчтай ярилцаж, шалтгааныг тодорхойлон тохирох зөвлөмж өгнө.

Хадгалах хугацаа: байнгийн

2. ***Маягтын нэр***: 6-18 НАСТАЙ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ДЭВТЭР
   Маягтын дугаар: ӨЭ-1.Б

Ойлголт, тодорхойлолт: Энэхүү маягт нь сургуулийн насны буюу 6 наснаас 17 настай хүүхдийн эрүүл мэндийг хянаж, улирал тутамд тодорхой эмчийн үзлэгт хамруулах зорилготой болно. Хүн амын эрүүл мэндийн зайлшгүй тулгамдсан асуудлын нэг болох төрөлхийн болон олдмол хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлж, хөгжлийн дэмжлэг, сэргээн засах, оролцоо, боловсролын үйлчилгээнд аль болох эрт хамруулах нь нэн чухал юм.

Манай улсад хүүхэд бүрийн жин өндрийг хянах тогтолцоотой ч хөгжлийг хянах тогтолцоо байхгүй байна. Хүүхдийн хөгжлийг тандаж хянаж, хөгжлийн хоцрогдлын эрсдэлтэй хүүхдийг олж илрүүлэх үйл явц нь анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллага өрх, сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллгаатай шууд холбогдох ёстой.

Мөн сургуулийн хүүхдүүдийн эрүүл мэндийг хянах, дэмжих зорилгоор уг маягтыг Эрүүл мэндийн байгууллагын их эмчээс гадна “Сургуулийн эмч” хөтлөхөөр оруулж байна.

Нөхөх заавар: Сургуулийн эмч болон өрх, сумын эрүүл мэндийн төвийн эмч нь Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.2.14.1-т заасны дагуу уг дэвтэрт хүүхдийн биеийн жингийн индексийг жилд 2 удаа хэмжиж, тооцоолно.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 255 дугаар тогтоолоор батлагдсан "Эрүүл шүд - Эрүүл хүүхэд" хөтөлбөрийн хэрэгжилтийг хянах, эрчимжүүлэх зорилгоор хүүхдийн Амны хөндийн эрүүл мэндийн асуудлуудыг багтаасан асуумжийг цогцоор оруулсан. Энэхүү асуумж нь мэргэжлийн шүдний эмч бус өрх, сумын эмч, сургуулийн эмч зааврын дагуу хараад тэмдэглэх боломжтойгоор оруулсан тус хүүхдийн шүдийг харж, майгтын дагуу тэмдэглэн, эмчилгээ, үйлчилгээ шаардлагтай хүүхдийг шүдний эмч, нарийн мэргэжлийн эмчийн хяналтад шуурхай явуулна.

Сургуулийн насны хүүхдийн эрүүл мэндийн хяналт, дэмжлэг нь боловсролын байгууллага дээр тулгуурлан сургуулийн эмчийн оролцоо, үүрэгтэйгээр хийвэл зохистой бөгөөд ЭМБ-ууд харьяа боловм\сролын байгууллагуудтай хамтран ажиллаж, зөвшилцөн сургуулийн эмч нар хөтөлж мөрдүүлэх шаардлагатай.

Маягтыг хөтлөх эмнэлгийн мэргэжилтэн: Өрх, сумын эрүүл мэндийн төвийн их эмч, сургуулийн эмч

Хадгалах хугацаа: Байнга

3. ***Маягтын нэр***: ӨРХИЙН ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН БҮРТГЭЛ
   Маягтын дугаар: ӨЭ-2

Ойлголт, тодорхойлолт: Тухайн өрх, сумын эрүүл мэндийн төвийн үйлчлэх хүрээний өрх тус бүрээр эрүүл мэндийн бүлэг, амьдралын орчин, өрхийн гишүүн тус бүрээр эрүүл мэндийн зарим мэдээллийг бүртгэх, хянах зориулалттай бүртгэл юм.

Өрхийн эрүүл мэндийн бүлгийг дараах байдлаар тодорхойлно.
"Эрүүл өрх"- Эрүүл мэндийн III-V бүлэгт хамрагдах архаг өвчтөй хүн байхгүй бөгөөд жилд өрхийн нэг гишүүн өвчилж үзүүлсэн тоо нэгээс илүүгүй байна.

"Эрүүл мэндийн бага өртөмтгий өрх"-Гэр бүлийнхний дотор архаг өвчтэй хүн 1-с илүүгүй бөгөөд жилд өрхийн нэг гишүүн хурц өвчнөөр 3-аас олон өвдсөн байна.

"**Эрүүл мэндийн өртөмтгий өрх**" - Ам бүлийн дотор архаг өвчтэй 2 ба түүнээс олон, жилд өрхийн нэг гишүүн хурц өвчнөөр өвчилсэн тоо 3-аас олон байна.

Хүн амын эрүүл мэндийн бүлгийг дараах байдлаар тодорхойлно.

I бүлэг-"Цоо эрүүл"- Эмнэлгийн үзлэг шинжилгээнд болон сэтгэцийн ямар нэг өөрчлөлтгүй хүнийг хэлнэ.

II бүлэг- "Эрүүл" - Энэ бүлэгт эмчилгээ шаардлагагүй төрөлхийн ямар нэг согог, урьд нь ямар нэг өвчний үлдэцтэй, эсвэл өвчний эхлэл, нууц үеийн зарим илрэлтэй боловч ажлын чадвар хязгаарлагдаагүй хөдөлмөрийн чадвартай хүмүүс орно.

III бүлэг - Ээнэгшил бүхий архаг өвчтөй хүмүүс Архаг өвчтэй боловч тухайн эрхтэн системийн үйл ажиллагаа алдагдаагүй ажил хөдөлмөрөө хийж байгаа хүмүүс

IV бүлэг - Хагас ээнэгшил бүхий архаг өвчтөй хүмүүс. Архаг өвчнөөр удаан өвчилж, эрхтэн системд өөрчлөлт орсон (субкомпенсацийн байдал) өвчин гэмтлийн улмаас эрхтэн системийн үйл ажиллагаа буурч хөдөлмөрийн чадвар үе үе алддаг, хөдөлмөрийн чадвараа 50%-иас дээш алдаж, тэтгэвэр тэтгэмжинд хамрагдсан хүмүүс,

V бүлэг - Ээнэгшилээ алдсан архаг өвчтөй хүмүүс Голдуу хэвтрийн дэглэм баримталдаг, декомпенсацийн байдалтай архаг хүнд өвчтэй, хөдөлмөрийн чадвараа 50%-иас дээш алдаж, тэтгэвэр тэтгэмжинд хамрагдсан хүмүүс орно.

Нөхөх заавар: Уг маягтыг үндэслэн ЭМТ101.1 тайлан гарна. Өрхийн хүн амын эрүүл мэндийн бүртгэлийг H-info V3.0 программд оруулж тогтмол хөдөлгөөн хийж байх хэрэгтэй.
Өрхийн усан хангамж, халаалт болон бие засах газар /жорлон/, боловсролыг кодчлох зааврын дагуу бичих бөгөөд кодлох заавар ороогүй зарим мэдээллийг дараах байдлаар тэмдэглэнэ.: Үүнд:

- **Усан хангамж:** төвлөрсөн-1, худаг, зөөврийн-2, гол булаг шанд-3, задгай-4
- **Халаалт:** төвлөрсөн-1, ердийн-2
- **Жорлон:** төвлөрсөн-1 , стандартын нүхэн-2, стандартын нүхэн бус-3, задгай-4
- **Хорт зуршил:** А-архи, Т-тамхи, хоёуланг нь хэрэглэдэг бол АТ гэж бичнэ.
- **Жирэмслэлтээс сэргийлэх эм хэрэгслэл:** Үүнд: Ерөндөг-1, эм-2, тариа-3, суулгац-4, бэлгэвч-5, стерилизаци-6. Хэрэв 2 аргыг зэрэг хэрэглэдэг бол аль илүү хэрэглэж буй арга хэрэгслэлийг тавина.

Маягтыг хөтлөх эмнэлгийн мэргэжилтэн: Өрхийн сувилагч, сумын болон багийн бага эмч

Хадгалах хугацаа: Байнга

Хяналт, баталгаажилт: Тухайн өрх, сумын эрүүл мэндийн төвийн их эмч дээрх маягтын хөтлөлт, үнэн зөв байдалд сар туамд хяналт тавьж баталгаажуулна.

4. ***Маягтын нэр***: ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ ӨСӨЛТ, ХӨГЖЛИЙН ХЯНАЛТЫН КАРТ

Маягтын дугаар: ӨЭ-3.А

Ойлголт, тодорхойлолт: Уг маягт нь тухайн өрх, сумын эрүүл мэндийн төвийн харьяалалд байгаа болон түр хугацаанд хяналтад байгаа хүүхэд тус бүрээр хүүхдийн өсөлтийг нэг нас хүртэл сар бүрээр, хоёр нас хүртэл 3 сараар, 5 нас хүртэл нэг жилээр холбогдох үзлэг, хэмжилт, өвчлөлийн байдлаар бүртгэнэ.

Нөхөх заавар: Өрх, сумын эрүүл мэндийн төвийн сувилагч, бага эмч нар нь хүүхдийн өсөлтийг маягтын дагуу хянаж, зааврын дагуу бөглөн үнэн зөв тэмдэглэж, бөглөнө. Хүүхдийн өсөлт, хоол тэжээл, амин дэм, эрдсийн хэрэглээг зааврын дагуу тэмдэглэж, хүүхдийн өвчлөлийн байдлыг эмчийн үзлэгийг үндэслэн эмчийн зааврын дагуу тэмдэглэл хийнэ.
ӨЭ-3А болон ӨЭ-3Б маягтуудыг үндэслэн ЭМТ 101.2-3 тайлангууд гарна.

Хадгалах хугацаа: 20 жил

Хяналт, баталгаажилт: Тухайн өрх, сумын эрүүл мэндийн төвийн их эмч дээрх маягтын хөтлөлт, үнэн зөв байдалд сар туамд хяналт тавьж баталгаажуулна.

5. ***Маягтын нэр***: ХҮҮХДИЙН ӨСӨЛТ, ХӨГЖЛИЙН БҮРТГЭЛИЙН МАЯГТ
   Маягтын дугаар: ӨЭ-3.Б

Ойлголт, тодорхойлолт: Уг маягт нь тухайн өрх, сумын эрүүл мэндийн төвийн харьяалалд байгаа болон түр хугацаанд хяналтад байгаа хүүхдүүдийн өсөлт, хоол тэжээлийн байдал, өвчлөлийг тодорхой насны ангиллаар бүртгэж хянах маягт юм.

Нөхөх заавар: Өрх, сумын эрүүл мэндийн төвийн сувилагч, бага эмч нар нь Хүүхдийн эрүүл өсөлт, хөгжлийн хяналтын карт ӨЭ-3А маягтыг үндэслэн, зааврын дагуу үнэн зөв тэмдэглэж, бөглөнө.
Насны ангиллыг 0-6 сартай, 7-12 сартай, 24 сартай, 36 сартай, 48 сартай, 59 сартай хүүхдийн үзлэг, хэмжилтийн мэдээллийг оруулах ба “хэмжвэл зохих” мөрөнд тухайн өрх, сумын эрүүл мэндийн төвийн хяналтад байгаа болон түр оршин суугч иргэдийн хүүхдийн тоог сар бүрээр тооцоолон тэмдэглэнэ. “Хэмжсэн” мөрөнд тухайн сард өсөлт, хөгжлийн хяналтад хамрагдсан хүүхдийн тоог тэмдэглэж, өсөлт, хоол тэжээлийн байдал, амин дэм, эрдсийн хэрэглээ, өвчлөлийн байдлыг зааврын дагуу үнэн зөв тэмдэглэнэ.

Маягтыг хөтлөх эмнэлгийн мэргэжилтэн: Өрхийн сувилагч, сумын болон багийн бага эмч

Хадгалах хугацаа: 20 жил

Хяналт, баталгаажилт: Тухайн өрх, сумын эрүүл мэндийн төвийн их эмч дээрх маягтын хөтлөлт, үнэн зөв байдалд сар тутамд хяналт тавьж баталгаажуулна.

6. ***Маягтын нэр***: 2 САР ХҮРТЭЛХ ХҮҮХДИЙН ҮЗЛЭГИЙН МАЯГТ
   Маягтын дугаар: ӨЭ-4.А

Ойлголт, тодорхойлолт: Уг маягт нь тухайн өрх, сумын эрүүл мэндийн төвийн харьяалалд байгаа нь нярай хүүхдэд үзлэг хийх тутамд энэ маягтыг бөглөнө. Үзлэгийг ЭМС-ын тушаалаар батлагдсан эмнэлзүйн удирдамжийн дагуу үзлэгийг хийж илэрч байгаа, зовиур, шинж тэмдгүүдийг нарийвчлан тодорхойлж, эмчилгээг тэмдэглэнэ.

Нөхөх заавар: Өрх, сумын эрүүл мэндийн төвийн сувилагч, бага эмч нар нь Хүүхдийн эрүүл өсөлт, хөгжлийн хяналтын карт ӨЭ-3А маягтыг үндэслэн, зааврын дагуу үнэн зөв тэмдэглэж, бөглөнө.
Насны ангиллыг 0-6 сартай, 7-12 сартай, 24 сартай, 36 сартай, 48 сартай, 59 сартай хүүхдийн үзлэг, хэмжилтийн мэдээллийг оруулах ба "хэмжвэл зохих" мөрөнд тухайн өрх, сумын эрүүл мэндийн төвийн хяналтад байгаа болон түр оршин суугч иргэдийн хүүхдийн тоог сар бүрээр тооцоолон тэмдэглэнэ. "Хэмжсэн" мөрөнд тухайн сард өсөлт, хөгжлийн хяналтад хамрагдсан хүүхдийн тоог тэмдэглэж, өсөлт, хоол тэжээлийн байдал, амин дэм, эрдсийн хэрэглээ, өвчлөлийн байдлыг зааврын дагуу үнэн зөв тэмдэглэнэ.

Маягтыг хөтлөх эмнэлгийн мэргэжилтэн: Өрх, сумын эрүүл мэндийн төвийн их эмч

Хадгалах хугацаа: 5 жил

7. ***Маягтын нэр***: ХОЁР САРААС 5 ХҮРТЭЛХ НАСНЫ ӨВЧТЭЙ ХҮҮХДИЙН ҮЗЛЭГИЙН МАЯГТ
   Маягтын дугаар: ӨЭ-4.Б

Ойлголт, тодорхойлолт: Уг маягт нь тухайн өрх, сумын эрүүл мэндийн төвийн харьяалалд байгаа өвчилсөн хүүхэд ирж үзүүлэх үед хөтлөгдөнө.

Нөхөх заавар: Өвчний шинж тэмдэг илэрч, үзлэгт орж хийлгэж буй 2 сараас 5 хүртэлх насны хүүхдэд уг маягтыг хөтлөх ба илэрч байгаа, зовиур, шинж тэмдгүүдийг нарийвчлан тодорхойлж, эмчилгээг тэмдэглэх шинж тэмдгүүдийг нарийвчлан тодорхойлж, эмчилгээг тэмдэглэнэ.

Маягтыг хөтлөх эмнэлгийн мэргэжилтэн: Өрх, сумын эрүүл мэндийн төвийн их эмч

Хадгалах хугацаа: 15 жил

8. ***Маягтын нэр***: ДАРХЛААЖУУЛАЛТАД ХАМРАГДСАН 0-15 НАСТАЙ ХҮҮХДИЙН НЭГДСЭН БҮРТГЭЛ
   Маягтын дугаар: ӨЭ-5.А

Ойлголт, тодорхойлолт: Хүүхэд ямар вакцины, хэддүгээр тунд, хичнээн тун хэмжээтэй, хэзээ, хаана хамрагдсаныг тодорхойлох бүртгэл юм.

Нөхөх заавар: Вакцинатор сувилагч хүүхдэд вакцин хийх бүртээ холбогдох асуултын дагуу бүрэн, гаргацтай бөглөнө. Вакцин хийсэн сар, өдөр, цаг минут, тун хэмжээ, серийн дугаарыг бүрэн, зөв тэмдэглэх ба хийсэн вакцины тунг (+)тэмдгээр тэмдэглэнэ. Өрхийн эмч, дархлаажуулалт хариуцсан эмч, тархвар судлагч хяналт тавина.

Уг бүртгэлийн мэдээллийг сар бүрийн заавал хийх дархлаажуулалтын хамралтын мэдээг гаргахад ашиглана.

"Урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан байдал"-ыг бөглөхдөө заавал хийх дархлаажуулалтын сарын төлөвлөгөө, эх, хүүхдийн ягаан дэвтэр, урьдчилан сэргийлэх тарилгын карт, дархлаажуулалтын өдөр тутмын бүртгэл зэрэгт үндэслэн үнэн зөв, бүрэн бөглөнө.

Маягтыг хөтлөх эмнэлгийн мэргэжилтэн: Өрх, сумын эмч, өрхийн сувилагч, сумын болон багийн бага эмч

Хадгалах хугацаа: 5 жил

Хяналт, баталгаажилт: Тухайн өрх, сумын эрүүл мэндийн төвийн их эмч, эрхлэгч эмч дээрх маягтын хөтлөлт, үнэн зөв байдалд сар тутамд хяналт тавьж баталгаажуулна.

9. ***Маягтын нэр***: ТОВЛОЛЫН БУС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТАРИЛГАД ХАМРАГДСАН ХҮМҮҮСИЙН БҮРТГЭЛ
   Маягтын дугаар: ӨЭ-5.Б

Ойлголт, тодорхойлолт: Хүүхэд ямар вакцины, хэддүгээр тунд, хичнээн тун хэмжээтэй, хэзээ, хаана хамрагдсаныг тодорхойлох бүртгэл юм.

Нөхөх заавар: Вакцинатор сувилагч хүүхдэд вакцин хийх бүртээ холбогдох асуултын дагуу бүрэн, гаргацтай бөглөнө. Вакцин хийсэн сар, өдөр, цаг минут, тун хэмжээ, серийн дугаарыг бүрэн, зөв тэмдэглэх ба хийсэн вакцины тунг (+)тэмдгээр тэмдэглэнэ. Өрхийн эмч, дархлаажуулалт хариуцсан эмч, тархвар судлагч хяналт тавина.

Уг бүртгэлийн мэдээллийг сар бүрийн заавал хийх дархлаажуулалтын хамралтын мэдээг гаргахад ашиглана.

“Урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан байдал”-ыг бөглөхдөө заавал хийх дархлаажуулалтын сарын төлөвлөгөө, эх, хүүхдийн ягаан дэвтэр, урьдчилан сэргийлэх тарилгын карт, дархлаажуулалтын өдөр тутмын бүртгэл зэрэгт үндэслэн үнэн зөв, бүрэн бөглөнө.

Маягтыг хөтлөх эмнэлгийн мэргэжилтэн: Өрх, сумын эмч, өрхийн сувилагч, сумын болон багийн бага эмч

Хадгалах хугацаа: 5 жил

Хяналт, баталгаажилт: Тухайн өрх, сумын эрүүл мэндийн төвийн их эмч, эрхлэгч эмч дээрх маягтын хөтлөлт, үнэн зөв байдалд сар тутамд хяналт тавьж баталгаажуулна.

10. ***Маягтын нэр***: ТОВЛОЛЫН БУС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТАРИЛГАД ХАМРАГДСАН ХҮМҮҮСИЙН БҮРТГЭЛ
    Маягтын дугаар: ӨЭ-5.А

Ойлголт, тодорхойлолт: Уг бүртгэлийн мэдээллийг тархвар судлал, нэмэлт, сайн дурын дархлаажуулалтын хамралтын үед хөтлөгдөх бүртгэл юм.

Нөхөх заавар: Уг бүртгэлийг вакцинатор, өрх, сумын сувилагч, бага, их эмч нар бүртгэнэ.

Маягтыг хөтлөх эмнэлгийн мэргэжилтэн: Өрх, сумын эмч, өрхийн сувилагч, сумын болон багийн бага эмч

Хадгалах хугацаа: 5 жил

Хяналт, баталгаажилт: Тухайн өрх, сумын эрүүл мэндийн төвийн их эмч, эрхлэгч эмч дээрх маягтын хөтлөлт, үнэн зөв байдалд сар тутамд хяналт тавьж баталгаажуулна.

1. Харьяа сум, өрхийн эрүүл мэндийн төвийн сувилагч хөтөлж, жил бүр шинэчлэх ба өрхийн эмч, эрхлэгч, дарга нар хяналт тавина.

11. Дархлаажуулалтад хамрагдсан 0-15 насны хүүхдийн нэгдсэн бүртгэл ӨЭ-5.1

12. Товлолын бус урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан хүмүүсийн бүртгэл ӨЭ-5.3

13. Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийн бүртгэл ӨЭ-5.4

Бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудын их эмч, бага эмч, сувилагч нар дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийг сэжиглэсэн, оношлосон тохиолдол бүрийг бүртгэнэ.

14. Урьдчилан сэргийлэх тарилгын орлого зарлагын өдөр тутмын бүртгэл ӨЭ-5.5

Орлого, зарлагын өдөр тутмын бүртгэлд вакцины үлдэгдлийг өдөр бүр тэмдэглэнэ. Багана бүрт тохирох мэдээллийг үнэн зөв, бүрэн бөглөнө. Вакцин татан авахад нэг төрлийн вакцины өөр үйлдвэрлэгчийн вакцин ирвэл түүнийг шинэ хуудаснаас бүртгэж эхэлнэ. Үлдэгдэл байгаа тунгаа хуучин хуудас дээрээ дуусгана. Уусгагч шингэн, тариур, аюулгүй хайрцагны орлого, зарлагыг бүртгэнэ.

А- Тарьсан болон хуваарилсан он, сар, өдрийг тэмдэглэнэ.

Б- Вакцин захилах бүрт захиалгын хуудас бөглөх бөгөөд үүнийг дугаарласан байх ёстой. Уг дугаарыг тэмдэглэнэ.

В- Хүлээн авч байгаа эсвэл зарцуулж байгаа вакцины серийн дугаарыг бүтэн бичнэ.

Г- Хүлээн авч байгаа эсвэл зарцуулж байгаа вакцины дуусах хугацааг тэмдэглэнэ.

Д- Вакцин хүлээн авах бүрт он, сар, өдрийг тэмдэглэнэ.

Е- Вакцин хүлээн авах үед хэм хяналтын хэрэгсэл ямар байсан тухай тэмдэглэнэ. ВШМ хэддүгээр шатанд байсан, термометрийн заалт хэдийг зааж байсан, хөлдөлтийг тандах заагуур хэвийн байсан эсэх гэх мэт ямар хэм хяналтын хэрэгсэл байснаас шалтгаалж уг нүдийг бөглөнө.

Ё- ХӨСҮТ болон аймаг, дүүргээс нэгжид вакцин хуваарилсан тохиолдолд тухайн хуваарилж байгаа ЭМБ-ын нэрийг бичнэ. Энэ нь сум, ӨЭМТ, дархлаажуулалтын нэгжид хамаарахгүй.

Ж- Хэдэн хүн тун вакцин орлогод хүлээн авсанаа бичнэ. З, И, К хэсгийг дархлаажуулалтын нэгжид хөтлөнө.

ХӨСҮТ, аймаг, дүүргээс хуваарилалт хийж байгаа тохиолдолд зарцуулалтыг К /бүгд зарлага/ багананд бичнэ.

З- Хэдэн хүн тунг тарьсан тоог бичнэ.

И- Хэдэн хүн тунг устгасан тоог бичнэ. Вакцин, биобэлдмэл устгах журмын дагуу устгалын протокол үйлдэнэ.

К- Бүгд зарлага хэсэгт тарьсан тун дээр устгасан тунг нэмж бичнэ.

Л- Эцсийн үлдэгдлээ бичнэ. Үлдэгдэл = Өмнөх үлдэгдэл+орлого-бүгд зарлага

Сар бүрийн эцэст улаан шугам татаж орлого, тарьсан тун, устгасан тун, бүгд зарлага, эцсийн үлдэгдлээ нэгтгэн бичнэ. Сарын эцэст хөргөгчинд байгаа вакцины үлдэгдлийг тоолж, дүнг орлого зарлагын бүртгэлтэй тулган хянасны дараа тооллогын протокол үйлдэн, зарцуулалтын мэдээг маягтын дагуу гаргана. Дууссан дэвтрийг архивлана.

0-15 настай хүүхдийг дархлаажуулах сарын төлөвлөгөө ба хамралт ӨЭ-6

Уг төлөвлөгөө нь тухайн сард вакцинд хамрагдвал зохих хүүхдийн судалгааг гаргаж, дархлаажуулалтад хамруулсан хүүхдийг тэмдэглэх бүртгэл бөгөөд дархлаажуулалтын сар бүрийн хамралтын мэдээ гаргахад ашиглана. Харьяа сум, өрхийн эрүүл мэндийн төвийн сувилагч, бага, их эмч нар сар бүр гаргана. Өрхийн эмч, дархлаажуулалт хариуцсан эмч, тархвар судлагч хяналт тавина.

Сэргийлэх тарилгаас татгалзсан тухай мэдээлэх хуудас ӨЭ-6.А

Сэргийлэх тарилгаас татгалзсан тухай мэдээг тухай бүр бүртгэж, дараа сарын 10-ны дотор ХӨСҮТ-д immunization@nccd.gov.mn цахим хаягаар ирүүлэх ба мөн сар бүр статистикийн албан ёсны мэдээлэлд оруулна.

Хүүхдийн урьдчилан сэргийлэх тарилгын гэрчилгээ ӨЭ-7

Хүүхэд тус бүрийг заавал хийх дархлаажуулалтын товлолын дагуу вакциныг хэзээ хийснийг тэмдэглэх маягт юм. Хүүхдийг дархлаажуулсан вакцинатор сувилагч хөтөлнө.

СТ-9 Нярайн вакцин хийсэн тухай бүртгэл

1. Амаржих газар, төрөх тасгийн вакцинатор сувилагч өдөр тутамд заавал хийх дархлаажуулалтад хамруулсан нярай хүүхдийн бүртгэлийг хөтлөх ба дархлаажуулалт хариуцсан бага, их эмч нар хяналт тавина.
2. Нярайд вакцин хийгээгүй үед вакцины тухай мэдээллийг хоосон орхих ба вакцинд хамрагдаагүй шалтгааныг товч дурьдана.
3. Тогтмол хаягт иргэний үнэмлэх дээрх хаягыг бүртгэх ба 2 утасны дугаар авахыг хичээнэ.
4. Уг бүртгэлийн мэдээллийг сар бүрийн заавал хийх дархлаажуулалтын хамралтын мэдээг гаргахад ашиглана.

“Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бүртгэл” ӨЭ-8

Энэ бүртгэлд үйлчлэх хүрээний хөгжлийн бэрхшээлтэй бүх хүнийг бүртгэнэ. Өрх, сумын эмч хөтөлнө. ӨЭ-8, ӨЭ-9, ӨЭ-10 маягтуудыг үндэслэн ЭМТ101.5.1-3 тайлан гарна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн: Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогийн улмаас бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь бүрэн болон 12 сараас дээш хугацаагаар хязгаарлагдсан хүнийг "**хөгжлийн бэрхшээлтэй**" хүн гэнэ. Хөгжлийн бэрхшээлийн төрлийг дараах байдлаар ойлгоно. Үүнд:

Төрөлхийн: Хөгжлийн бэрхшээлийн төрөлд удамшлын эмгэг, согог, жирэмсний болон төрөх үеийн хүндрэлээс шалтгаалан бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогтой болж, бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадваргүй хүнийг хамруулна.

Олдмол: Хөгжлийн бэрхшээлийн төрөлд ахуйн болон үйлдвэрлэлийн осол, гэмтэл, эрдийн болон мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэхүйн согогтой болж, бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадваргүй хүнийг хамруулна.

Хөгжлийн бэрхшээлийн илэрсэн хэлбэрийг дараах байдлаар ойлгоно. Үүнд:

1. ***Харааны:*** Харааны эрхтний гэмтэл, согог, өвчин эмгэгийн улмаас хүний"харах" хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан. /2 нүдний хараа бүрэн эсвэл хагас алдагдсан, / - 12 / - / -20 / хүртлэх харааны шил зүүдэг хүмүүс, нэг нүд нь огт байхгүй юмуу эсвэл протезтой нөгөө нүд нь шилээр засрахгүй тохиолдол хамаарна/
2. ***Ярианы:*** Хэл, ярианы эрхтний гэмтэл, согог, өвчин, эмгэгийн улмаас хүний "ярих" хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан/ авиан дуудлагын өөрчлөлттэй, тультраа, ээрүү, гацаа гэх мэт хүмүүс орно/
3. ***Сонсголын:*** Сонсголын болон хэл, ярианы эрхтний гэмтэл, согог, өвчин эмгэгийн улмаас хүний "сонсох" хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан. /Төрөлхийн болон өвчний улмаас үүссэн дүлийрэлүүд, 70 дицепилээс дээш сонсголын алдагдалтай, бууралттай/
4. ***Хөдөлгөөний:*** Биеийн тодорхой хэсгийг хөдөлгөх чадваргүйн улмаас хүний амьдралын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг гүйцэтгэх чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан. /Саа, саажилт, үе мөч, яс, булчингийн системийн эмгэг өөрчлөлтөөс хөдлөх чадвараа алдсан, мөч тайралттай, бие бялдрын өөрчлөлттэй, одой, нанизм, майга тавхайтай хүмүүс орно/
5. ***Сэтгэцийн:*** Сэтгэцийн эмгэг нь бодох сэтгэх, мэдрэх ухамсарлахуйн болон зан төлөвийн өөрчлөлтөөр илрэх бөгөөд үүнийхээ улмаас хүний нийгэмд биеэ авч явах байдал нь өөрчлөгдсөн, гадаад (төрөх үеийн хүндрэлүүдийн үлдэцийн улмаас 0-3 насанд тэнэгрэх) болон дотоод (хромосомын өөрчлөлт, бодисын солилцоо дутмагшил гэх мэт) шалтгааны улмаас ойлгох, сэтгэх, мэдрэх үйл ажиллагаа нь хязгаарлагдсан оюун ухааны бэрхшээлийг сэтгэцийн эмгэг гэж ойлгоно. /Нойрны хямралтай, нүдэнд нь хий юм харагддаг, ганцаараа ярьж хөхөрдөг, их уур уцаартай, архи болон эм, мансууруулах бодист донтой хүмүүс орно/
6. ***Хавсарсан бэрхшээл:*** Нэг хүнд 1- ээс дээш төрлийн хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, согог тохиолдвол бүртгэнэ. /Оюун ухааны хомсдолтой хүүхэд, хөдөлгөөний өөрчлөлттэй, хэл ярианы дутагдалтай хүмүүс байж болно/
7. ***Бусад:*** Хөгжлийн бэрхшээлийн дээр дурдсан хэлбэрээс бусад хэлбэрийг үүнд хамааруулна. /Тухайлбал: дотор эрхтний эмгэгүүд, хавдар гэх мэт/

"Хөгжлийн бэрхшээлтэй хүний ахиц дэвшлийг үнэлэх маягт"ӨЭ-9

энэ маягтыг хөгжлийн бэрхшээлтэй хүн тус бүр дээр ямар ахиц дэвшил гарч байгааг үнэлэхэд ашиглана.

"Өрхийн эмчийн сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүст үзүүлсэн тусламжийн бүртгэл" ӨЭ-10

Сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүмүүс ирж үзүүлэх үед маягтыг бөглөнө. Өвчлөл нь шинэ, хуучин эсэх, хяналтанд авсан эсэх, эм олгосон эсэхийг тэмдэглэх боломжтой маягт юм.

Маягтын нэр: ТАВ ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХДИЙН ЭРТ ИЛРҮҮЛЭГ ҮЗЛЭГИЙН МАЯГТ

Маягтын дугаар: *ИЭМ-1*

Үзлэг хийсэн он сар эмч хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжил, хоол тэжээл, хөгжлийг үнэлж үзлэг хийхээр гэрээр нь очсон эсвэл хүүхэд эцэг эхийн хамт ЭМТ-д ирсэн он сар өдөр.

1. **Хүүхдийн мэдээлэл:**

Хүүхдийн хаягийн хэсгийн мэдээллийг эцэг, эх, амран хамгаалагдаас асууж, үнэн зөв, бүрэн гүйцэд бөглөнө. Иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээнд бичсэн регистрийн дугаарыг үндэслэн бичнэ.

Хүүхдийн ургийн овог, эцэг, эхийн нэр, хүүхдийн нэр, нас хүйсийг анхааралтай бүрэн гүйцэд бөглөнө. Гэрийн хаягийг засаг захиргааны нэгжийн кодын дагуу кодлож бүртгэнэ. Эхийн иргэний үнэмлэхийг үндэслэн аймаг/хот, сум/дүүрэг, баг/хороо зэргийг гаргацтай бичнэ.

Жишээ: Аймаг/хот *Орхон*

Сум/дүүрэг *Жаргалант*

Баг/хороо *Улаантолгой баг*

2. Эхийн мэдээлэл

Эхийн мэдээллийн хаягийн хэсгийг кодлох зааварт заасан ангиллын дагуу тэмдэглэж, програм хангамжид оруулна.

Эхийн регистрийн дугаарыг бөглөхдөө иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээнд бичсэн регистрийн дугаарыг үндэслэн бичнэ. Регистрийн дугаар гэсэн 10 нүд бүхий хүснэгтийн эхний 2 нүдэнд үсгийг том үсгээр, сүүлийн 8 нүдэнд цифрийг тус бүрт гаргацтай бичнэ.

Кодлох аргачлалыг ашиглан гэрлэлтийн байдлыг тэмдэглэнэ. Тусгаарласан гэдэгт гэр бүлээ албан ёсоор цуцлуулаагүй тусдаа амьдарч байгаа хүмүүсийг оруулна. Гэр бүл болж хамтран амьдарч байгаа боловч иргэний бүртгэл мэдээллийн төвд бүртгүүлж гэр бүлээ батлуулаагүй хүмүүсийг батлуулаагүй гэж кодлоно.

Тамхи татдаг эсэх асуултад хэрэв тийм бол, өдөрт татдаг тамхины тоог асууж тэмдэглэнэ.

Архи уудаг эсэх талаар тэмдэглэгээг огт уудаггүй тохиолдолд үгүй гэсэн хариултыг,

Тийм гэсэн хариултыг-архийг үгүйлэх байдлаар уудаг, архины хамаарал бүхий хүмүүсийг оруулна. Хааяа-гэсэн асуултад зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд хэрэглэдэг тохиолдолд энэ тэмдэглэгээг хийнэ.

3. Эхийн эрүүл мэндийн мэдээлэл

Маягтад заасан өвчнүүд болон бусад өвчнүүдээр өвдөж, оношлогдож эмчилгээ хийлгэж байсан тохиолдолд **тийм** гэсэн тэмдэглэгээг хийж, харгалзах өвчнийг тэмдэглэх буюу бичнэ.
Өмнө нь ямар нэгэн өвчин оношлогдож, эмчлэгдэж байгаа тохиолдолд **үгүй** тэмдэглэгээг хийнэ. Эхэд жирэмсэнтэй хавсарсан эрхтэн тогтолцооны эмгэг байвал тохирох хариултын кодыг сонгоно. Нэгээс олон хариулт сонгож болно. Эхэд тохиолдсон эрхтэн тогтолцооны эмгэг дээрх хариултад эмгэгийн нэрийг тодорхой бичнэ. Халдварт ба шимэгчит өвчин байвал тодорхой бичнэ.

Эцгийн эрүүл мэндийг ямар нэгэн өвчин зовиургүй тохиолдол **Хэвийн** , тухайн нөхцөлд юм уу эсвэл урьд нь өвчин эмгэг оношлогдож, эмчлэгдэж байсан тохиолдолд **Хэвийн биш** тэмдэглэгээг хийж зовиурыг тодорхой бичиж тэмдэглэнэ.
Эхийн жирэмслэлтийн түүхийг нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний заавар удирдамжуудыг мөрдлөг болгосон болно.

Өмнөх төрөлтийн тоонд нийт төрөлтийн тоог бичнэ. Ихэр бол нэг төрөлтөнд тооцно. Эхийн төрсөн, үр хөндүүлсэн, зулбасан, мэс засал хийлгэсэн эсэхийг доогуур нь зурж хэдэн удааг асууж бичнэ.

V. Эмчийн үзлэг /хүүхэд/

Эмнэлгийн мэргэжилтэн бодит үзлэгийг ЗААВАЛ хийнэ. Үзлэг хийхдээ хүүхдийн эх болон гэр бүлийн гишүүдийг хамт байлцуулна. Хүүхэд эрүүл бол "Эрүүл" гэсэн хариултын өмнөх □ энэ нүдэнд √ тэмдгээр тэмдэглэнэ. Өвчтэй бол өөрчлөлт илэрсэн хэсэгт тэмдэглэнэ.

Үнэлгээний хэсэгт хүүхэд эрүүл бол "Эрүүл" гэсэн хариултын өмнөх □ энэ нүдэнд √ тэмдгээр тэмдэглэнэ. Өвчтэй бол ХӨЦМ-ийн дагуу үнэлэн ангилал, бусад өвчин илэрвэл тухайн өвчний онош, өсөлт хөгжлийн хоцрогдолтой бол тураал, туранхай, өсөлтийн хоцрогдол болон хоол тэжээлийн дутагдалтай эсэхийг тэмдэглэнэ.

<u>Өсөлтийг хэмжиж тэмдэглэнэ:</u> Хүүхдийн биеийн жинг хэмжин, килограммаар бичнэ. Жишээ нь: хүүхдийн жин 8 кг 700 гр байвал 8.7 кг гэж бичнэ.

<u>Хүүхдийн биеийн уртыг хэмжин тэмдэглэнэ:</u> Уртын хэмжээг сантиметрээр бичнэ. Жишээ нь: хүүхдийн өндөр 1 метр 12 см байвал 112 см гэж бичнэ.

<u>Хүүхдийн жин, уртын харьцааг тодорхойлно</u>: Биеийн жинг урт/өндөрт нь харьцуулсан харьцааг хэлнэ. Энэ үзүүлэлтээр туранхай, илүүдэл жин, таргалалтыг илрүүлэх ач холбогдолтой. Мөн хүүхдийн хоол тэжээлийн цочмог дутлыг тодорхойлдог.
Толгойн тойргийг туузан метрээр хэмжиж см-ийг тэмдэглэнэ.
Цус багадалттай бол (√) зохих тэмдэгээг хийнэ.

Хооллолтын байдал : Хөхөө хөхдөг □ Холимог □ Ердийн □ нүдэнд (√) зөвлөх тэмдгээр тэмдэглэнэ.
Хөхөө хөхдөг – Эхийн сүүгээр дагнан хооллож (Эхийн хөхний сүүнээс өөр бусад шингэн, ус, цай, шүүс зэргийг огт авахгүй байхыг хэлнэ) байгаа,

Холимог - Эхийн сүүний зэрэгцээ эхийн сүү орлуулагчаар хооллож байгаа буюу холимог хооллолтойг тэмдэглэнэ.

Шүдний эрүүл мэндийг үнэлнэ. Үүнд: Хүүхдийн шүд анх хэдэн сартайд ургасан талаар эцэг, эх асран хамгаалагчаас тодруулж тэмдэглэх ба одоо хэдэн шүдтэй байгааг үзэж тэмдэглэнэ. Шүд амны хөндийн эрүүл мэндийг хамтад нь үнэлж ямар нэгэн эмгэгүй, шүд цоорол, гажиггүй бол □ эрүүл нүдэнд (√) зөвлөх тэмдгээр тэмдэглэнэ. Хэрэв эмгэг ажиглагдвал тохирох □ нүдэнд (√) зөвлөх тэмдгээр тэмдэглэж дүгнэлтийн хэсэгт оношийг тавина.. Цооролттой бол эмчлэх шаардлагатай шүдний тоог бичнэ.
Үнэлгээний хэсэгт хүүхэд эрүүл бол "Эрүүл" гэсэн хариултын өмнөх □ энэ нүдэнд √ тэмдгээр тэмдэглэнэ. Өвчтэй бол ХӨЦМ-ийн дагуу үнэлэн ангилал, бусад өвчин илэрвэл тухайн өвчний онош, өсөлт хөгжлийн хоцрогдолтой бол тураал, туранхай, өсөлтийн хоцрогдол болон хоол тэжээлийн дутагдалтай эсэхийг тэмдэглэнэ

Дархлаажуулалт

Өрх сумын эмч, ээлжит үзлэгийн үед дархлаажуулалтад хугацаандаа хамрагдсан эсэхийг шалгаж тэмдэглэх ба хамрагдаагүй бол хэрхэн дархлаажуулалтад орохыг зөвлөх болон дархлаажуулалтын ач холбогдлыг эцэг эхэд тайлбарлаж өгнө.

Дархлаажуулалтын товлолын дагуу хүүхдийн товлосон насанд заавал хийх вакцины нэрний ард байгаа □ нүдэнд (√) зөвлөх тэмдгээр тэмдэглэн, вакцин хийсэн огноо цаг минутыг заавал бичнэ.

Хүүхдэд хэмжилт хийх

Хүүхэд бүрийн өсөлт, хөгжил тухайн хүүхдийн биеийн онцлогоос хамаарч янз бүр байдаг. Хүүхдийн биеийн байдал, өсөлт, хөгжлийг төрсний дараах эхний 2 сарын дотор 6 удаа, түүнээс хойш сар бүр гэрийн идэвхтэй эргэлт, амбулаторийн үзлэг, дархлаажуулалтын үед тогтмол үнэлж, хянаснаар хүүхдийн биеийн өсөлтийн хоцрогдол, хоол тэжээлийн цочмог дутлыг илрүүлэх ач холбогдолтой.

Зураг. Жин-насны хүснэгтэд өсөлтийн муруйг тэмдэглэсэн байдал

Хүснэгт. Өсөлт, хөгжил, хоол тэжээлийн цочмог дутлыг үнэлэх үзүүлэлт

Z оноо (СХ)	Өсөлтийн үзүүлэлт		
	Урт/өндөр-нас	**Жин-нас**	**Жин-урт/өндөр**
3 – аасдээш	Хэт өндөр	-	Тарган
2-оос дээш	Өндөр	-	Илүүдэл жинтэй
1 – ээсдээш	Эрсдэл	Эрсдэл	Эрсдэл
0 (голч)	Хэвийн	Хэвийн	Хэвийн
-1-ээс доош	Эрсдэл	Эрсдэл	Эрсдэл
-2-оос доош	Өсөлт хоцрогдол/намхан	Тураал	Туранхай
-3-аас доош	Өсөлтийн хүнд хоцрогдол	Хүнд тураал	Хүнд тураал

Өсөлтийн муруйг ашиглан эцэг эх, асран халамжлагчид зөвлөгөө өгөх

Хүүхдийн өсөлт, хөгжлийн хэмжилт бүрийг 5 хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэрт тэмдэглэн тухайн хүүхдийн өсөлтийн байдлыг эцэг, эхчүүдэд мэдээлж, эрсдэлтэй буюу өөрчлөлттэй тохиолдол бүрийг эцэг эх, асран халамжлагчтай ярилцаж, шалтгааныг тодорхойлон тохирох зөвлөмж өгнө.

Өвчний шинж тэмдэг илэрсэн бол илэрч байгаа, зовиур, шинж тэмдгүүдийг нарийвчлан тодорхойлж, эмчилгээг тэмдэглэх шинж тэмдгүүдийг нарийвчлан тодорхойлж, эмчилгээг тэмдэглэнэ. Дээд шатлалд онош баталгаажуулах шардлагатай бол тэмдэглэгээг хийж, эцэг, эх асран хамгаалагчид нарийн тайларлаж ойлгуулна.

I. Ерөнхий дүгнэлт

Эмчийн ерөнхий дүгнэлтийг дараах байдлаар гаргана.

Үзлэгт хамрагдсан хүүхдэд ямар нэгэн эмгэг шинж болон өвчлөл илрээгүй тохиолдолд **Эрүүл** гэж дүгнэнэ.

Ямар нэгэн эмгэг болон өвчлөл илэрсэн тохиолдолд үндсэн өвчнийг сонгож дээрээс доош нь дараалуулах зарчмаар сонгож бичнэ. Үндсэн өвчин гэдэг нь хамгийн их оношлогоо, эмчилгээ шаардагдах өвчнийг хэлнэ.

Нэг хүүхдэд хэдэн ч өвчлөл бүртгэгдэж болох ба авсан арга хэмжээг доорх зааврын дагуу бүртгэсэн өвчлөл тус бүрд тодорхой зааж бичнэ.

- **Амьдралын хэв маягаа өөрчлөх (зөвлөгөө)**

1. **Хооллолт** **2. Идэвхитэй хөдөлгөөн** **3. Хорт зуршил** **4.Бусад**

- Өрх, сумын ЭМТ-д хяналтанд авах **(кодоор)**

1. **3 хүртэлх сар** **2. 6 хүртэлх сар**

- Өрх, сумын ЭМТ-д эмчилгээнд хамрагдах **(кодоор)**

1. Эмийн 2. Эмийн бус

- Дээд шатлалын эмнэлэгт онош баталгаажуулах **(кодоор)**

1. Дүүргийн ЭМТ 2. АНЭ, БОЭТ3. Төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг 4. Хувь ЭМБ

- Дээд шатлалын эмнэлэгт эмчилгээнд хамрагдах **(кодоор)**

1. Дүүргийн ЭМТ 2. АНЭ, БОЭТ3. Төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг 4. Хувь ЭМБ

Үзлэгт хамрагдсан хүүхдийг эрүүл мэндийг үзлэгийг үндэслэн эрүүл мэндийн 5 бүлэгт хамруулна. /Эрүүл мэндийн бүлгийг ойлголт, тодорхойлолт бүлгээс харна уу/

Маягтыг хөтлөх эмнэлгийн мэргэжилтэн: Өрх, сумын эрүүл мэндийн төвийн их эмч, сургуулийн эмч

Хадгалах хугацаа: Байнга

Маягтын нэр: 5-18 ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХЭД, ӨСВӨР ҮЕИЙНХНИЙ ЭРТ ИЛРҮҮЛЭГ ҮЗЛЭГИЙН МАЯГТ

Маягтын дугаар: ЭИМ-2
Иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээнд бичсэн регистрийн дугаарыг үндэслэн бичнэ.

Ойлголт, тодорхойлолт: Энэхүү маягт нь 5 наснаас 17 настай хүүхдийн эрүүл мэндийг хянаж, тодорхой хугацаанд эмчийн үзлэгт хамруулах зорилготой болно. Хүн амын эрүүл мэндийн зайлшгүй тулгамдсан асуудлын нэг болох төрөлхийн болон олдмол хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлж, хөгжлийн дэмжлэг, сэргээн засах, оролцоо, боловсролын үйлчилгээнд аль болох эрт хамруулах нь нэн чухал юм.

”Осол гэмтлийн тохиолдлыг бүртгэх хуудас”-ыг үзлэг хийсэн эмч осол гэмтлийн **<u>шинэ тохиолдол</u>** бүрт хөтөлнө. Өвчтний биеийн байдалд тохируулан эрэмбэлэн ангиллын А, В, С, D зэргийн аль нэгийг сонгон дугуйлна.

А. Паспортын хэсэг	
Асуумж	Тодорхойлолт, жишээ:
А1. Эмнэлгийн нэр	Эмнэлгийн нэрийг бичихдээ эмнэлгийн нэр гэсэн 6 нүдний эхний 2 нүдэнд аймаг хотын, дараагийн 2 нүдэнд сум, дүүргийн, сүүлийн 2 нүдэнд эмнэлгийн шифрийг тус тус бичнэ. Жишээ нь: Баянхонгор аймгийн Галуут сумын эмнэлэг 0 3 1 1 0 3

А2. Эцэг /эх/-ийн нэр	Осол гэмтэлд өртсөн хүний эцэг /эх/ -ийн нэрийг бичнэ
А3. Нэр	Осол гэмтэлд өртсөн хүний өөрийн нэрийг бичнэ.
А4. Регистрийн дугаар	Гэмтсэн хүний регистрийн дугаарыг бичих ба хүснэгтийн эхний 2 нүдэнд үсэг, дараагийн 8 нүд тус бүрт нэг цифр байхаар тохируулж бичнэ.
А5. Нас	Насыг кодлохдоо нүд тус бүрд нэг цифр бичнэ. 1 нас хүрээгүй хүүхдийн насыг сараар, нярай хүүхдийг өдрөөр бичиж шифрийн ар талд сар, өдрийн аль нь болохыг тодотгож бичнэ. Тухайлбал: 11 настай гэвэл: 11 нас, харин 11 сартай гэвэл 11 сар, 11 өдөртэй гэвэл 11өдөр гэнэ. Жишээ нь. 11 сартай гэх <table><tr><td>1</td><td>1</td><td>сар</td></tr></table> мэт.
А6. Хүйс	Хүйсийг тэмдэглэхдээ хүйс эрэгтэй бол-1, эмэгтэй бол-2, хэрэв тухайн хүн огт мэдэхгүй эсвэл хариулах боломжгүй бол тодорхойгүй буюу-99 гэж зохих нүдэнд бөглөнө.
А7. Тогтмол хаяг	Тогтмол хаяг гэсэн нүдэнд тухайн хүний байнга оршин суугаа газрын засаг захиргааны нэгжийн харъяалалаар бичнэ. Эхлээд аймаг /хотын/, дараа нь сум, /дүүргийн/, сүүлд нь хороо /багийг/, гудамж /байрны/, хаалганы дугаарыг бичнэ Жишээ нь: Архангай аймгийн, Ихтамир сумын, 1-р баг, тайхрын 2-р гудамж 12 тоот
А8. Утасны дугаар	Гэмтсэн хүний утасны дугаар болон ар гэртэй нь холбоо барих утасны дугаарыг бичнэ.
А9. Ажлын газар, албан тушаал	Гэмтсэн хүний ажлын газар, албан тушаал, мэргэжлийг бичнэ.
А10. Боловсрол	Гэмтсэн хүний боловсролыг бөглөхдөө бага-1, дунд-2, мэргэжил-техникийн- 3, дээд - 4, боловсролгүй-5 гэж харалдаа зохих нүдэнд бөглөнө.
А11. Эмнэлэгт яаж ирсэн	Гэмтсэн хүн эмнэлэгт яаж ирснийг зохих кодыг дугуйлж бүртгэнэ. Өөрөө ирсэн бол-1, түргэнээр ирсэн бол-2, хариулах боломжгүй тохиолдолд бусад-98 гэсэн хэсгийг дугуйлж, юугаар ирснийг заавал тодорхой бичнэ. Жишээ нь: Гэмтсэн хүн таксигаар эмнэлэгт хүргэгдсэн <table><tr><td>Бусад ***такси***</td><td>98</td></tr></table>
А12. Согтууруулах ундаа хэрэглэсэн эсэх	Гэмтэх үедээ согтууруулах ундаа хэрэглэсэн байсан бол-1, хэрэглээгүй бол-2 гэж нүдэнд тэмдэглэнэ.
А13. Мансууруулах бодис хэрэглэсэн эсэх	Гэмтэх үедээ мансууруулах бодис хэрэглэсэн байсан бол-1, хэрэглээгүй бол-2 гэж нүдэнд тэмдэглэнэ.

А14. Өөр эмнэлэгт хандсан эсэх	Гэмтсэн хүн тухайн гэмтлээрээ аль нэгэн эмнэлэгт хандсан бол ямар эмнэлэгт хандсаныг тодруулж тохирох нүдэнд тэмдэглэнэ. Үүнд: Өрхийн Эрүүл мэндийн төв-1 Сум, тосгон, сум дундын эмнэлэг-2 Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг-3 Бүсийн оношлогоо, эмчилгээний төв-4 Төрөлжсөн нарийн мэргэжлийн төв-5 Бусад -98
А15. Гэмтсэн хугацаа	Гэмтэл авсан он, сар, өдөр, цаг, минутыг бөглөхдөө эхний 1 нүдэнд оныг, 2-р нүдэнд сарыг, 3-р нүдэнд өдрийг, 4-р нүдэнд цагийг, 5-р нүдэнд минутыг тус тус бичнэ. Жишээ нь: Гэмтсэн хүн 2011 оны 7 сарын 6-ны 24 цаг 5 минутанд гэмтсэн гэх мэт. 11 07 06 24 05
А16. Үзүүлсэн хугацаа	Энэ гэмтлээр эмнэлэгт хандсан он, сар, өдөр, цаг, минутыг бөглөхдөө эхний 1 нүдэнд оныг, 2-р нүдэнд сарыг, 3-р нүдэнд өдрийг, 4-р нүдэнд цагийг, 5-р нүдэнд минутыг тус тус бичнэ. Жишээ нь: Гэмтсэн хүн 2011 оны 7 сарын 6-ны 16 цаг 35 минутанд үзүүлсэн гэх мэт. 11 07 06 16 35
А17. Осол болсон цэгийн нэр, байршил	Осол хаана болсон цэгийн нэрийг бөглөхдөө тухайн осол болсон дүүрэг, хороо, осол болсон газрын нэрийг дэлгэрэнгүй бичнэ. Жишээ нь: ***Гурвалжингийн тойрог***

Б. Осол гэмтлийн талаарх үндсэн мэдээллийн хэсэг

Асуумж	Тодорхойлолт, жишээ
Б1. Осол гарах үеийн байршил	Осол гарах үеийн байршлыг бөглөхдөө /1-11, 98-99-р дугаараас сонгож/ зохих нүдний харалдаа хэсэгт байгаа тоог чагтлах буюу дугуйлан зурж тэмдэглэнэ. Дурьдсанаас бусад газар гэмтсэн бол-98 гэсэн нүдийг бөглөөд хаана гэмтсэнийг тодорхой бичнэ. Хэрэв осол гарсан газрыг тухайн хүн огт мэдэхгүй эсвэл хариулах боломжгүй бол тодорхойгүй буюу-99 гэж нүдэнд тэмдэглэнэ. Жишээ нь: Гэмтсэн хүн гудамжинд хальтирч унасан гэх мэт. Биеийн тамир, спортын талбай 3 Гудамж, зам (4) Худалдаа үйлчилгээний газар 5
Б2. Осол гэмтлийн шалтгаан	Осолд хүргэсэн шалтгааныг бөглөхдөө зөвхөн үндсэн 1 шалтгааныг зохих нүдний харалдаа хэсэгт тэмдэглэнэ. Жишээ нь: Хамтран амьдрагч нь зодож, халуун усаар түлсэн гэх мэт.

<table>
<tr><td></td><td>
<table>
<tr><td>Зам тээврийн осол</td><td>1</td></tr>
<tr><td>Хүчирхийлэл</td><td>2</td></tr>
<tr><td>Амиа хорлохыг завдах</td><td>3</td></tr>
</table>

Харин дурдсанаас бусад шалтгааны улмаас гэмтсэн бол-98 гэсэн нүдийг бөглөөд ямар гэмтлийн шалтгаантайг тодорхой бичнэ. Хэрэв осол гэмтлийн шалтгааны талаар тухайн хүн огт мэдэхгүй байх эсвэл хариулах боломжгүй бол тодорхойгүй буюу 99 гэж нүдэнд тэмдэглэнэ.</td></tr>
<tr><td colspan="2">Нэмэлт мэдээлэл / В, Г, Д /</td></tr>
<tr><td><u>Нэмэлт мэдээлэл / В, Г, Д /</u></td><td>Үүнд зам тээврийн осол, амиа хорлохыг завдах болон хүчирхийлэл зэрэг гэмтлийн онцгой тэргүүлэх шалтгаан бүхий зүйлсийг агуулах ба гэмтэлтэй хамааралтай цаашдын нэмэлт мэдээллийг багтаасан болно.</td></tr>
<tr><td>В. Зам тээврийн осол
В1. Зам тээврийн хэрэгслийн төрөл</td><td>Осол гарах үед тухайн хүн ямар тээврийн хэрэгслээр зорчиж байсныг бөглөхдөө /1-9-р дугаараас сонгож/ зохих нүдний харалдаа хэсэгт байгаа тоог чагтлах буюу дугуйлан зурж тэмдэглэнэ. Жишээ нь: Морь унаж яваад гэмтсэн гэх мэт
<table>
<tr><td>Нийтийн тээврийн хэрэгсэл</td><td>6</td></tr>
<tr><td>Морь</td><td>7</td></tr>
</table></td></tr>
<tr><td>В2. Ослын үед замын хөдөлгөөнд хэрхэн оролцож байсан бэ</td><td>Ослын үед тухайн хүн ямар байдлаар хөдөлгөөнд оролцож байсныг тодруулж бөглөхдөө /1-5, 98-99-р дугаараас сонгож/ зохих нүдний харалдаа хэсэгт байгаа тоог чагтлах буюу дугуйлан зурж тэмдэглэнэ. Хэрэв мориноос унаж гэмтсэн бол уралдааны мориноос унасан уу, энгийн мориноос унасан эсэхийг тодруулж бөглөнө. Дурьдсанаас бусад байдлаар замын хөдөлгөөнд оролцож байсан бол-98 гэсэн нүдийг бөглөөд замын хөдөлгөөнд өөр ямар байдлаар оролцож байсныг тодорхой бичнэ. Хэрэв тухайн хүн огт мэдэхгүй байх эсвэл хариулах боломжгүй бол тодорхойгүй буюу 99 гэж нүдэнд тэмдэглэнэ.
Жишээ нь: Хурдан мориноос унаж гэмтсэн гэх мэт.
<table>
<tr><td>Зорчигч</td><td>3</td></tr>
<tr><td>Уралдааны морь унаач</td><td>4</td></tr>
<tr><td>Энгийн морь унагч</td><td>5</td></tr>
</table></td></tr>
<tr><td>В3. Зам тээврийн ослын үед ямар зүйлтэй мөргөлдсөн</td><td>Гэмтсэн хүн зам тээврийн ослын үед ямар зүйлтэй мөргөлдсөнийг тодруулж бөглөхдөө /1-5, 98-99-р дугаараас сонгож/ зохих нүдний харалдаа хэсэгт байгаа тоог чагтлах буюу дугуйлан зурж тэмдэглэнэ. Дурьдсанаас өөр бусад ямар нэгэн зүйлтэй мөргөлдсөн бол-98 гэсэн нүдийг бөглөнө. Хэрэв тухайн хүн</td></tr>
</table>

<table>
<tr><td></td><td>огт мэдэхгүй эсвэл хариулах боломжгүй бол тодорхойгүй буюу-99 гэж нүдэнд тэмдэглэнэ.
Жишээ нь: Машинтай хажуугийн хашлага явж байгаад замын мөргөсөн гэх мэт.
<table><tr><td>Хөдөлгөөнгүй зүйл</td><td>4</td></tr><tr><td>Мөргөлдөөгүй /онхолдох/</td><td>5</td></tr></table></td></tr>
<tr><td>В4. Осол гарах үед хамгаалалтын бүс хэрэглэсэн эсэх</td><td>Гэмтсэн хүн осол гарах үед хамгаалалтын бүс хэрэглэсэн эсэхийг зохих нүдний харалдаа хэсэгт байгаа тоог дугуйлан зурж тэмдэглэнэ.
Жишээ нь: Машин жолоодож байх үедээ хамгаалалтын бүс хэрэглээгүй гэх мэт
<table><tr><td colspan="2">Хамгаалалтын бүс</td></tr><tr><td>Тийм</td><td>1</td></tr><tr><td>Үгүй</td><td>2</td></tr></table></td></tr>
<tr><td>В5. Осол гарах үед хамгаалалтын малгай хэрэглэсэн эсэх</td><td>Гэмтсэн хүн осол гарах үед хамгаалалтын малгай хэрэглэсэн эсэхийг зохих нүдний харалдаа хэсэгт байгаа тоог дугуйлан зурж тэмдэглэнэ.
Жишээ нь: Мотоциклоор зорчиж явах үедээ хамгаалалтын малгай хэрэглээгүй гэх мэт.
<table><tr><td colspan="2">Хамгаалалтын малгай</td></tr><tr><td>Тийм</td><td>1</td></tr><tr><td>Үгүй</td><td>2</td></tr></table></td></tr>
<tr><td>В6. Зам тээврийн осолд хичнээн хүн өртсөн</td><td>Зам тээврийн осолд өртөгсөдийн тоог бөглөхдөө тухайн үед хичнээн хүн осолд өртсөнийг тохирох нүдэнд бөглөнө.
Жишээ нь: Зам тээврийн ослын үед 5 хүн гэмтсэн гэх мэт
<table><tr><td>Зам тээврийн осолд өртөгсдийн тоо</td><td>1</td><td>2</td><td>3</td><td>4_өөс дээш</td></tr></table></td></tr>
<tr><td>Г. Хүн хоорондын хүчирхийллийн мэдээлэл
Г1. Хүчирхийллийн хэлбэр</td><td>Хүчирхийлэл үүсгэсэн хэлбэрийг тодруулж бөглөхдөө /1-6, 98-99-р дугаараас сонгож/ зохих нүдний харалдаа хэсэгт байгаа тоог чагтлах буюу дугуйлан зурж тэмдэглэнэ. Дурьдсанаас бусад хэлбэрийн хүчирхийллээр үйлдэгдсэн бол -98 гэсэн нүдийг бөглөөд ямар хэлбэрийн хүчирхийлэлд өртсөнийг тодорхой бичнэ. Хэрэв тухайн хүн огт мэдэхгүй байх эсвэл хариулах боломжгүй бол тодорхойгүй-99 гэж тэмдэглэнэ.
Жишээ нь: Эрүүлжүүлэхийн байранд цагдаад зодуулсан гэх мэт.</td></tr>
</table>

<table>
<tr><td></td><td>
<table>
<tr><td>Эдийн засгийн хэлбэр</td><td>4</td></tr>
<tr><td>Хууль хяналтын байгууллагын дарамт</td><td>5</td></tr>
<tr><td>Хар тамхитай холбоотой</td><td>6</td></tr>
</table>
</td></tr>
<tr><td>Г2. Хүчирхийлэлд хэрэглэсэн зүйл, арга</td><td>Хүчирхийлэлд өртөх үед хүчирхийлэгчийн ашигласан зүйлийг бөглөхдөө /1-12, 98-99-р дугаараас сонгож/ зохих нүдний харалдаа хэсэгт байгаа тоог чагтлах буюу дугуйлан зурж тэмдэглэнэ. Дурьдсанаас бусад зүйлийг ашигласан бол-98 гэсэн нүдийг бөглөөд ямар зүйлс ашигласныг тодорхой бичнэ.Хэрэв тухайн хүн огт мэдэхгүй эсвэл хариулах боломжгүй бол тодорхойгүй буюу-99 гэж нүдэнд тэмдэглэнэ.
Жишээ нь: Хүчирхийлэх үедээ халуун зүйлээр түлсэн гэх мэт.
<table>
<tr><td>Галт зэвсэг,буугаар/Х93-95/</td><td>3</td></tr>
<tr><td>Тэсрэх дэлбэрэх зүйлээр халдах /Х96/</td><td>4</td></tr>
<tr><td>Утаа, гал дөлөөр түлэх /Х98/</td><td>5</td></tr>
</table>
</td></tr>
<tr><td>Г3. Хүчирхийлэлд хэдэн хүн оролцсон</td><td>Хэдэн хүчирхийлэгч оролцсоныг бөглөхдөө зохих нүдний харалдаа хэсэгт байгаа тоог чагтлах буюу дугуйлан зурж бөглөнө.
Жишээ нь: Нөхөртөө зодуулсан гэх мэт.
<table>
<tr><th colspan="2">Г3 Хэдэн хүчирхийлэгч оролцсон бэ?</th></tr>
<tr><td>нэг</td><td>1</td></tr>
<tr><td>хоёр</td><td>2</td></tr>
<tr><td>гурав</td><td>3</td></tr>
</table>
</td></tr>
<tr><td>Г4. Хүчирхийлэл үзүүлэгчийн хүйс</td><td>Гол хүчирхийлэгчийн хүйсийг тэмдэглэхдээ хүйс эрэгтэй бол-1, эмэгтэй бол-2, хэрэв тухайн хүн огт мэдэхгүй эсвэл хариулах боломжгүй бол тодорхойгүй буюу-99 гэж зохих нүдэнд бөглөнө.</td></tr>
<tr><td>Г5. Хүчирхийлэгч хохирогч хоорондын холбоо</td><td>Хүчирхийллийн хохирогч болон хохироогч хоёрын хоорондын холбоо хамаарлыг бөглөхдөө /1-7, 98-99-р дугаараас сонгож/ зохих нүдний харалдаа хэсэгт байгаа тоог чагтлах буюу дугуйлан зурж тэмдэглэнэ. Дурьдсанаас бусад холбоо хамаарал байгаа бол-98 гэсэн нүдийг бөглөөд ямар хамааралтайг тодорхой бичнэ. Хэрэв тухайн хүн огт мэдэхгүй эсвэл хариулах боломжгүй бол тодорхойгүй буюу-99 гэж нүдэнд тэмдэглэнэ.
Жишээ нь: Хойд эцэг нь зодсон гэх мэт.</td></tr>
</table>

<table>
<tr><td></td><td>
<table>
<tr><td>Эх эцэг</td><td>2</td></tr>
<tr><td>Бусад хамаатан</td><td>3</td></tr>
</table>
</td></tr>
<tr><td>Д. Амиа хорлох, санаатай өөрийгөө гэмтээх осол гэмтлийн мэдээлэл
Д1. Амиа хорлоход хүргэсэн хэлбэр</td><td>Амиа хорлохыг завдах үедээ хэрэглэсэн арга, зүйлсийг бөглөхдөө /1-20, 98-99-р дугаараас сонгож/ зохих нүдний харалдаа хэсэгт байгаа тоог чагтлах буюу дугуйлан зурж тэмдэглэнэ. Дурьдсанаас бусад зүйлийг ашигласан бол-98 гэсэн нүдийг бөглөөд ямар зүйлс ашигласныг тодорхой бичнэ. Хэрэв тухайн хүн огт мэдэхгүй эсвэл хариулах боломжгүй бол тодорхойгүй буюу-99 гэж нүдэнд тэмдэглэнэ.
Жишээ нь: өөрийгөө шилээр зүссэн гэх мэт.
<table>
<tr><td>Иртэй зүйлээр</td><td>6</td></tr>
<tr><td>Мохоо зүйлээр</td><td>7</td></tr>
<tr><td>Өндрөөс үсрэх /Х80/</td><td>8</td></tr>
</table>
</td></tr>
<tr><td>Д2. Өөрийгөө гэмтээхдээ хэрэглэсэн зүйл</td><td>Өөрийгөө гэмтээх, амиа хорлоход нөлөөлсөн хүчин зүйлсийг бөглөхдөө /1-8, 98- 99-р дугаараас сонгож/ зохих нүдний харалдаа хэсэгт байгаа тоог чагтлах буюу дугуйлан зурж тэмдэглэнэ. Дурьдсанаас бусад холбоо хамаарал байгаа бол-98 гэсэн нүдийг бөглөөд ямар хамааралтайг тодорхой бичнэ. Хэрэв тухайн хүн огт мэдэхгүй эсвэл хариулах боломжгүй бол тодорхойгүй буюу-99 гэж нүдэнд тэмдэглэнэ.

Жишээ нь: Шашин шүтлэгтэй холбоотой өндрөөс унасан гэх мэт.
<table>
<tr><td>Гэр бүлийн гишүүд маргалдах</td><td>7</td></tr>
<tr><td>Ажлын байрны дарамт</td><td>8</td></tr>
<tr><td>Бусад ___шашин шүтлэг</td><td>98</td></tr>
</table>
</td></tr>
<tr><td>Е. Осол гэмтлийн талаарх тусгай тэмдэглэл
Е1. Тусгай тэмдэглэл</td><td>Осол гэмтлийн талаарх тусгай тэмдэглэлийг бөглөхдөө_тухайн осол гэмтлийн талаарх онцгой, өвөрмөц тохиолдлын дүр зургийг дэлгэрэнгүй бичнэ.
Жишээ нь: Нохойд хазуулж гэмтсэн тохиолдолд эзэнтэй эсвэл гудамжны нохойд хазуулсан эсэхийг тодруулж бичих гэх мэт гэмтэл тус бүрт нэмэлт мэдээллийг тэмдэглэнэ.</td></tr>
<tr><td>Е2. Гэмтлийн онош</td><td>Гэмтлийн оношийн хэсгийг бөглөхдөө эмч клиникийн үндсэн оношийг дэлгэрэнгүй, бүрэн гүйцэд, гаргацтай бичнэ.</td></tr>
</table>

Е3. Шилжүүлсэн хэлбэр	Гэмтсэн хүнийг эмнэлгийн аль хэсэг рүү шилжүүлснийг бөглөхдөө зохих нүдийг дугуйлна. Жишээ нь: Тасаг руу бол-1, Дүүргийн ЭМТ рүү бол-5
Е4. Авсан арга хэмжээ	Гэмтсэн хүнд авсан арга хэмжээг бөглөхдөө үзлэгийн эмчийн хийсэн эмчилгээний болон оношлогооны бүхий л үйлдлийг тэмдэглэнэ.
Е5. Эмчийн гарын үсэг	Эмчийн гарын үсгийг бөглөхдөө маягт бөглөсөн эмч гарын үсгээ зурж, хувийн тамга тэмдгээ дарж баталгаажуулна.

Түлэгдлийн шалтгаантай осол гэмтлийг бүртгэх нэмэлт хуудас СТ-34

"Түлэгдэлтийн шалтгаант осол гэмтлийн тохиолдлыг бүртгэх нэмэлт хуудас" маягтыг түлэгдэлтийн улмаас **<u>хэвтэн эмчлүүлж буй тохиолдол</u>** бүрт эмчлэгч эмч хөтөлнө.

А. Паспортын хэсэг	
Асуумж	Тодорхойлолт, жишээ
А1. Эмнэлгийн нэр	Эмнэлгийн нэрийг бичихдээ эмнэлгийн нэр гэсэн 6 нүдний эхний 2 нүдэнд аймаг хотын, дараагийн 2 нүдэнд сум, дүүргийн, сүүлийн 2 нүдэнд эмнэлгийн шифрийг тус тус бичнэ. Жишээ нь: Баянхонгор аймгийн Галуут сумын эмнэлэг 0 3 1 1 0 3
А2. Эцэг /эх/-ийн нэр	Осол гэмтэлд өртсөн хүний эцэг /эх/ -ийн нэрийг бичнэ
А3. Нэр	Осол гэмтэлд өртсөн хүний өөрийн нэрийг бичнэ.
А4. Регистрийн дугаар	Гэмтсэн хүний регистрийн дугаарыг бичих ба хүснэгтийн эхний 2 нүдэнд үсэг, дараагийн 8 нүд тус бүрт нэг цифр байхаар тохируулж бичнэ.
А5. Нас	Насыг кодлохдоо нүд тус бүрд нэг цифр бичнэ. 1 нас хүрээгүй хүүхдийн насыг сараар, нярай хүүхдийг өдрөөр бичиж шифрийн ар талд сар, өдрийн аль нь болохыг тодотгож бичнэ. Тухайлбал: 11 настай гэвэл: 11 нас, харин 11 сартай гэвэл 11 сар, 11 өдөртэй гэвэл 11өдөр гэнэ. Жишээ нь. 11 сартай 1 1 сар гэх мэт.
А6. Хүйс	Хүйсийг тэмдэглэхдээ хүйс эрэгтэй бол-1, эмэгтэй бол-2, хэрэв тухайн хүн огт мэдэхгүй эсвэл хариулах боломжгүй бол тодорхойгүй буюу-99 гэж зохих нүдэнд бөглөнө.
А7. Тогтмол хаяг	Тогтмол хаяг гэсэн нүдэнд тухайн хүний байнга оршин суугаа газрын засаг захиргааны нэгжийн харъяалалаар бичнэ. Эхлээд аймаг /хотын/, дараа нь сум, /дүүргийн/, сүүлд нь хороо /багийг/, гудамж /байрны/, хаалганы дугаарыг бичнэ Жишээ нь:
	Архангай аймгийн, Ихтамир сумын, 1-р баг, тайхрын 2-р гудамж 12 тоот

А8. Утасны дугаар	Гэмтсэн хүний утасны дугаар болон ар гэртэй нь холбоо барих утасны дугаарыг бичнэ.
А9. Ажлын газар, албан тушаал	Гэмтсэн хүний ажлын газар, албан тушаал, мэргэжлийг бичнэ.
А10. Боловсрол	Гэмтсэн хүний боловсролыг бөглөхдөө бага-1, дунд-2, мэргэжил-техникийн-3, дээд - 4, боловсролгүй-5 гэж харалдаа зохих нүдэнд бөглөнө.
А11. Асран хамгаалагч /сахиур/	Түлэгдсэн үйлчлүүлэгч эмнэлэгт хэвтэж байхдаа сахиулсан сахиурын мэдээлэл орно. Жишээ нь: Эцэг эх нь сахисан бол-1, хэрвээ заасан жагсаалтад дурдаагүй сахиуртай бол бусад-98 гээд тайлбарыг бичнэ. Жнь: өвөө нь гэх мэт
А12. Түлэгдэх үед хэнтэй хамт байсан бэ?	10 наснаас доош настай үйлчлүүлэгч бол түлэгдэж гэмтэх үедээ хэнтэй хамт байсныг тохирох кодоор тэмдэглэнэ. Жишээ нь: ганцаараа байсан бол-1, эцэг эхийн хамт байсан бол-2 гэх мэт
А13. Түлэгдэлд өртсөн хүний тоо	Эмнэлгийн тусламж авч буй уг түлэгдлийн шалтгаантай осол гэмтэлд хэдэн хүн өртсөн бэ гэдгийг тодруулж бичнэ. Жишээ нь: Нэг хүн өртсөн бол-1 гэх мэт
А14. Түлэгдсэн он сар өдөр	Гэмтэл авсан он, сар, өдөр, цаг, минутыг бөглөхдөө эхний 1 нүдэнд оныг, 2-р нүдэнд сарыг, 3-р нүдэнд өдрийг, 4-р нүдэнд цагийг, 5-р нүдэнд минутыг тус тус бичнэ. Жишээ нь: Гэмтсэн хүн 2011 оны 7 сарын 6-ны 24 цаг 5 минутанд гэмтсэн гэх мэт. 11 | 07 | 06 | 24 | 05
А15. Эмнэлэгт үзүүлсэн он сар өдөр	Энэ гэмтлээр эмнэлэгт хандсан он, сар, өдөр, цаг, минутыг бөглөхдөө эхний 1 нүдэнд оныг, 2-р нүдэнд сарыг, 3-р нүдэнд өдрийг, 4-р нүдэнд цагийг, 5-р нүдэнд минутыг тус тус бичнэ. Жишээ нь: Гэмтсэн хүн 2011 оны 7 сарын 6-ны 16 цаг 35 минутанд үзүүлсэн гэх мэт. 11 | 07 | 06 | 16 | 35
А16. Эмнэлэгт хэвтсэн он сар өдөр	Энэ гэмтлээр эмнэлэгт хандсан он, сар, өдөр, цаг, минутыг бөглөхдөө эхний 1 нүдэнд оныг, 2-р нүдэнд сарыг, 3-р нүдэнд өдрийг, 4-р нүдэнд цагийг, 5-р нүдэнд минутыг тус тус бичнэ. Жишээ нь: Гэмтсэн хүн 2011 оны 7 сарын 6-ны 16 цаг 35 минутанд үзүүлсэн гэх мэт. 11 | 07 | 06 | 16 | 35
А17. Түлэгдэлд өртөхөд нөлөөлсөн хүчин зүйл	Түлэгдэлд өртөхөд нөлөөлсөн эрүүл мэндийн болоод бусад хүчин зүйлийг тодруулан тэмдэглэнэ. Жишээ нь түлэгдэх үедээ согтуурруулах мансуурруулах бодис хэрэглэсэн байсан бол-2 гэх мэт
А18. Бусад эрхтний талаас хавсарсан гэмтэл	Түлэгдэж гэмтэх үед бусад эрхтэн тогтолцоонд давхар авсан гэмтэл байгаа бол энэ хэсэгт тодруулж бичнэ. Жишээ нь: Түлэгдэх үедээ давхар аль нэг ясны хугарал авсан бол-5 гэх мэт

А19. Осол болсон цэгийн нэр, байршил	Осол хаана болсон цэгийн нэрийг бөглөхдөө тухайн осол болсон дүүрэг, хороо, осол болсон газрын нэрийг дэлгэрэнгүй бичнэ. Жишээ нь: СХД, 10 хороо, Гурвалжингийн тойрог
Б. Түлэгдлийн байршил тодорхойлох хэсэг	
Асуумж	Тодорхойлолт, жишээ
Б1. Биеийн хэдэн хувь түлэгдсэн бэ?	Эмчлэгч эмч түлэгдлийн хувийг тодорхойлсон байдлаар энэ хэсэгт тэмдэглэнэ. Жишээ нь: Биеийн 15 хувь түлэгдсэн бол 15% гэх мэт
Б2. Амьсгалын зам гэмтсэн эсэх	Амьсгалын зам гэмтсэн бол -1, гэмтээгүй бол-2 гэж тэмдэглэнэ.
Б3-Б7 Түлэгдлийн байршил	Түлэгдлийн байршлыг нарийвчлан тодорхойлж тэмдэглэнэ. Их бие, толгой хүзүү, гар, хөл, сарвууны хэсэгт байрлах түлэгдлийн байршлыг нарийн тодорхойлж бичнэ. Жишээ нь: өгзөг хэсэгт түлэгдсэн бол Б3. Их бие гэсэн хэсгийн 4 гэсэн кодыг сонгоно.
В-Ж. Түлэгдлийн шалтгаан тодорхойлох хэсэг	
Асуумж	Тодорхойлолт, жишээ
В. Түлэгдсэн зүйл	
В1. Халуун гадаргуу	Ямар нэг халуун гадаргуунд хүрэлцэж түлэгдсэн тохиолдолд тодруулж тэмдэглэнэ. Жишээ нь: Хоол хийх хэрэгслийн халуун гадаргуунд хүрэлцэж түлэгдсэн бол-1 гм
В2. Халуун хий шингэн	Халуун шингэнд түлэгдсэн бол энэ хэсгийн бөглөх ба хоол хийх үйл ажиллагаатай холбоотой түлэгдсэн бол Г хэсгийг бөглөнө. Жишээ нь халуун ууранд түлэгдсэн бол-1, халуун хоолонд түлэгдсэн бол 2-ыг дугуйлаад Г хэсгийг дэлгэрүүлж тэмдэглэнэ.
В3. Цахилгааны түлэгдэл	Цахилгаанд түлэгдсэн үед тэмдэглэнэ. Жишээ нь өндөр хүчдэлд түлэгдсэн бол-3 гэх мэт
В4. Химийн түлэгдэл	Химийн бодист түлэгдсэн бол химийн бодис нь гэр ахуйн хэрэглээний эсвэл мэргэжлийн ажилтай холбоотой химийн бодис байсан эсэхийг тодорхойлж бичнэ. Гэр ахуйн бол-1 гэх мэт /уксус/
В5. Үрэлтийн түлэгдэл	Түлэх нөлөө бүхий бодисоор амьсгалах, арьс салстад хүрэлцэж түлэгдсэн үед энэ хэсэгт тэмдэглэнэ. Жишээ нь амьсгалын замын түлэх үйлчилгээтэй бодисоор амьсгалж түлэгдсэн бол-1 гэх мэт
В6-В8 хэсэг Галд түлэгдсэн түлэгдэл	Гэр ахуйн орчинд галд өртсөн үед энэ хэсгийг хөтлөнө. Жишээ нь хоол хийх үед гарсан галд өртсөн бол-1 гэх мэт Халаалтын хэрэгсэлтэй холбоотой

В6. Гэр ахуйн орчинд галд өртөх	галд өртсөн бол Д, Гэрэлтүүлэх хэрэгсэлтэй холбоотой галд өртсөн бол Е, Санаатайгаар гаргасан галд өртсөн бол Ж хэсгийг дэлгэрүүлэн тэмдэглэнэ.
В7. Мэргэжлээс шалтгаалах галд өртөх	Ажил мэргэжилтэй холбоотой галд өртсөн тохиолдолд энэ хэсэгт тэмдэглэнэ. Жишээ нь Хоол үйлдвэрлэлийн үед гарсан галд өртсөн бол-1 гэх мэт
Г. Хоол хийх, бэлтгэх үед түлэгдсэн тохиолдлыг тодруулах хэсэг	
Г1. Хоол хийх, бэлтгэх үед юунд түлэгдсэн?	Хоол хийх бэлтгэх явцад түлэгдсэн бол юунд түлэгдсэнийг тодруулж тэмдэглэнэ. Жишээ нь: Халуун тогоонд түлэгдсэн бол-4 гэх мэт
Г2. Хоол бэлтгэх үйл явцтай холбоотой түлэгдэх үед болсон үйл явдал	Хоол бэлтгэх үйл явцтай холбоотой түлэгдэх үед болсон үйл явдлыг нарийвчлэн тодруулж тэмдэглэнэ. Жишээ нь дотор нь унаж түлэгдсэн бол-2 гэх мэт
Г3. Саванд байсан зүйл	Саванд байсан түлэгдэлтэд хүргэсэн бодисын тодруулж тэмдэглэнэ. Саванд халуун сүү байсан бол-1 гэх мэт
Г4. Хоол хийх талбайн өндөр	Хоол хийдэг зуух, цахилгаан зуух зэрэг нь хэр хэмжээний өндөрт байрладаг болохыг тодруулж бичнэ. Жишээ нь газар байдаг бол-1 гэх мэт
Г5. Хоол хийдэг газар нь амьдрах хэсгээс тусдаа эсэх	Хоол хийдэг хэсэг нь амьдрах хэсгээс тусдаа байрладаг эсэхийг тодруулж тэмдэглэнэ. Жишээ нь гэрт амьдардаг бол үгүй буюу-2, орон сууцанд амьдардаг галын өрөө тусдаа бол-1, гал тогоо зочны өрөө хамт бол-2 гэх мэт
Д. Халаалтын хэрэгсэлтэй холбоотой түлэгдэлтийн үед тодруулах хэсэг	
Д1. Гэрийн халаалтын улмаас гал гарах	Гэрийн халаалтын хэрэгсэлтэй холбоотой гал гарсан бол ямар үйл явцын улмаас гарсан болохыг тодруулж тэмдэглэнэ. Жишээ нь Халаалтын хэрэгсэл залгасан залгуур, утаснаас гал гарсан бол-4 гэх мэт
Д2. Халаалтын эх үүсвэр	Халаалтын хэрэгсэлд ашиглаж байсан галын эх үүсвэрийг тодруулж бичнэ. Жишээ нь Мод нүүрс түлж байсан бол-1, цахилгаан хэрэгслээс гарсан гал бол-5 гэх мэт
Е. Гэрийн гэрэлтүүлгийн хэрэгсэлтэй холбоотой түлэгдэлтийн үед тодруулах хэсэг	
Е1. Гэрийн гэрэлтүүлгийн улмаас гал гарах	Гэрийн гэрэлтүүлгийн хэрэгсэлтэй холбоотой гарсан галд өртсөн үед энэ хэсгийг тодруулан тэмдэглэнэ. Жишээ нь: Гэрэл болон лаа дэнлүүний орчимд байсан материалд галд авалцсан улмаас гарсан галд түлэгдсэн бол-1 гэх мэт
Е2. Гэрэлтүүлгийн хэрэгслийн төрөл	Гал гарах шалтгаан болсон гэрэлтүүлгийн хэрэгслийн төрлийг тодруулж бичнэ. Жишээ нь: Лаа байсан бол-1, цахилгаан хэрэгсэл байсан бол-2 гэх мэт

Ж. Санаатай үйлдэл байсан тохиолдолд тодруулах хэсэг	
Ж1. Санаатайгаар түлсэн шалтгаан	Санаатайгаар өөрийгөө болон бусдыг түлж гэмтээсэн тохиолдолд энэ хэсгийг тодруулан тэмдэглэнэ. Жишээ нь санаатайгаар өөрийгөө түлсэн бол-1, бусдыг түлсэн бол-2 гэх мэт
Ж2. Учир битүүлэг байдалтай түлэгдсэн тохиолдолд эмнэлзүйн шинж	Учир битүүлэг тохиолдлын үед Санаатай үйлдэл байх эмнэлзүйн шинж тэмдэг байгаа эсэхийг тодорхойлж тэмдэглэнэ. Өндөр магадлалтай бол-1, тодорхойлох боломжгүй бол мэдэхгүй-99 гэх мэт
Ж3. Санаатайгаар түлэгдэлтэд хүргэсэн шалтгааны эх үүсвэр	Гал гаргахад ашигласан зүйлийн эх үүсвэрийг тодорхойлон тэмдэглэнэ. Жишээ нь: Нүүрс бол-3, мод бол-7 гэх мэт
Түлэгдлийн шалтгаан	Түлэгдэлтэд хүргэсэн шалтгааныг өвчний олон улсын 10-р ангиллын дагуу үгээр бичих болон кодоор тэмдэглэнэ. Жишээ нь:Халуун хоол, цайнд түлэгдсэн бол X10, Шатамхай биет шатахад түлэгдсэн бол X04, Цахилгаан гүйдэл дамжуулах шугаманд өртөж түлэгдсэн бол W85 гэх мэт
Түлэгдлийн онош	Түлэгдсэн гэмтсэн өвчтний оношийн өвчний олон улсын 10-р ангиллын дагуу үгээр бичих болон кодоор тэмдэглэнэ. Их бие халууны ба химийн үйлчлэлээр түлэгдсэн бол T21, бугуй сарвуу халууны ба химийн үйлчлэлээр түлэгдсэн T23 гэх мэт
Авсан арга хэмжээ	Түлэгдэлтийн улмаас эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн үйлчлүүлэгчид хийгдсэн эмчилгээний болон оношлогооны бүхий л үйлдлийг эмчлэгч эмч тэмдэглэнэ.

Хөдөлгөөн засал эмчилгээний хуудас АМ-34

Хөдөлгөөн засал эмчилгээний хуудсыг сэргээн засах эмчилгээний тасаг нэгжид хөдөлгөөн засалчийн мэргэжил эзэмшсэн мэргэжилтэн хөтөлнө.

1. Бүртгэлийн хэсэгт овог нэр, нас, хүйс, гэрийн хаяг, амьдралын нөхцөл /орон сууц, байшин, гэр г.м/, ажил эрхлэлт /ажил эрхэлдэг, группт, тэтгэвэрт г.м/, ажлын орчин нөхцөл /хүнд, хортой, хэвийн, мэргэжил, удаан суудаг, зогсоо ажилтай, хүнд юм өргөдөг г.м/-ээр хөдөлгөөний идэвхтэй байдлыг асууж бичнэ.
2. Өвчтөнд одоо байгаа зовуурь, өвчин үүссэн шалтгаан, MRI, CP, X-Ray шинжилгээний дүгнэлтийг бичнэ.
3. Үндсэн оношийг олон улсын өвчний X ангиллын дагуу, хөдөлгөөн засалчийн оношийг олон улсын үйлийн ангиллын дагуу бичнэ
4. Өвчин эхэлсэн хугацаа, эмнэлэгт үзүүлсэн буюу хэвтсэн, хөдөлгөөн засал эмчилгээ эхэлсэн ба дууссан зэрэг огноог тэмдэглэнэ.

5. Үйлчлүүлэгчид өвдөлт байгаа эсэх, өвдөлтийн хүчийг баллаар, байрлалыг зурган дээр тэмдэглэнэ.
6. Өдөр тутмын үйл ажиллагааны чадвар /Modified Barthel Indes/-ыг хүснэгт дэх асуултын дагуу бөглөнө. Үйлдлийг гүйцэтгэж чадна, чадахгүй, бүрэн бие даасан зэрэг үнэлгээгээр өдөр тутамд зайлшгүй хийгдэх үйл ажиллагаанууд /хувийн ариун цэвэр, усанд орох, хооллох г.м/ өөртөө үйлчлэх чадвар тус бүрийг үнэлж, нийт оноог 0-100 баллаар дүгнэнэ.
7. Төрх байдлын анализ: үйлчлүүлэгчийн зогсох байрлал, суух байрлалыг урдаас, хажуунаас, араас харсан байдлаар дүгнэнэ.
8. Алхааны анализ: үйлчлүүлэгчийг алхуулж үнэлнэ. Алхах чадваргүй бол тухайн байдал /тэргэнцэртэй г.м/-ыг бичнэ.
9. Үений далайц, булчингийн хүчний хэмжилтийг хийхдээ том, жижиг үе хэмжигч гонометрийн тусламжтайгаар хэвтээ ба суугаа байрлалд үеийг тогтвортой байдалд хөдөлгөөн тус бүрийг хийлгэж, градусаар хэмжиж, хүснэгтэнд тус бүрд нь тэмдэглэнэ.
10. Тухайн үйлчлүүлэгчийн хөдөлгөөний алдагдал, бие даах чадварын бэрхшээлүүдийг тодорхойлж жагсааж бичнэ.
11. Үйлчлүүлэгч эсвэл асран хамгаалагчтай нь ярилцан тухайн хүний хийж чадахыг хүсч байгаа үйлдэл, чадварыг сонгон бэрхшээлтэй асуудалд тохирсон эмчилгээний үр дүнд хүрэх урт болон богино хугацааны эмчилгээний зорилго, хугацааг тодорхойлж бичнэ.
12. Урт болон богино хугацааны зорилгодоо хүрэхийн тулд эмчилгээний төлөвлөгөө боловсруулна.

Хөдөлмөр засал эмчилгээний хуудас АМ-35

Хөдөлмөр засал эмчилгээний хуудсыг сэргээн засах эмчилгээний тасаг нэгжийн хөдөлмөр засалчийн мэргэжил эзэмшсэн мэргэжилтэн хөтөлнө.

1. Бүртгэлийн хэсэгт овог нэр, нас, хүйс, өвчний түүхийн дугаар бичнэ.

2. Оношийг олон улсын үйлийн ангилал /ICF/-ын дагуу бичнэ.

3. Өдөр тутмын үйл ажиллагааны чадвар /Modified Barthel Indes/-ыг хүснэгт дэх асуултын дагуу бөглөнө. Үйлдлийг гүйцэтгэж чадна, чадахгүй, бүрэн бие даасан зэрэг үнэлгээгээр өдөр тутамд зайлшгүй хийгдэх үйл ажиллагаанууд /хувийн ариун цэвэр, усанд орох, хооллох г.м/ өөртөө үйлчлэх чадвар тус бүрийг үнэлж, нийт оноог 0-100 баллаар дүгнэнэ.

4. Үений далайц, булчингийн хүчний хэмжилтийг хийхдээ том, жижиг үе хэмжигч гонометрийн тусламжтайгаар хэвтээ ба суугаа байрлалд үеийг хөдөлгөөнгүй тогтвортой байдалд хөдөлгөөн тус бүрийг хийлгэж, градусаар хэмжиж, хүснэгтэнд тус бүрд нь тэмдэглэнэ.

5. Тухайн үйлчлүүлэгчийн биемахбод болон танин мэдэхүйн бэрхшээлүүдийг тодорхойлж жагсааж бичнэ.

7. Үйлчлүүлэгч эсвэл асран хамгаалагчтай нь ярилцан тухайн хүний хийж чадахыг хүсч байгаа үйлдэл, чадварыг сонгон бэрхшээлтэй асуудалд тохирсон эмчилгээний үр дүнд хүрэх урт болон ойрын хугацааны эмчилгээний зорилго, хугацааг тодорхойлж бичнэ.

8. Урт, ба ойрын хугацааны зорилгодоо хүрэхийн тулд эмчилгээний төлөвлөгөө боловсруулна.

Яаралтай тусламжийн хуудас хөтлөх ерөнхий аргачилал:

1. Яаралтай тусламжийн хуудсыг төрийн болон хувийн хэвшлийн эмнэлгүүдийн яаралтай тусламжийн хэсгээр үйлчлүүлсэн хүн бүрд хөтлөнө.
2. Яаралтай тусламжийн хуудсыг 2 хувь үйлдэн нэг хэсгийг өвчтөн түүний ар гэрийнхэнд нэг хувийг нь тухайн эмнэлгийн авч архивлана.
3. Тухайн ЭМБ-ийн лого болон дардасийг хуудасны зүүн дээд буланд байрлуулна.
4. Хуудасны дугаарлалт дахин давтагдахгүй,өвчтөн хүлээн авсан бүртгэлийн дугаартай тохирч байх (жич: хуудасны дугаар тухайн жил буюу 2018 он, жилийн эхнээс нэг гэж тоологдоно. №-18/0001)
5. Ерөнхий мэдээллийн хэсэг.
    a. Өвчтөний овог нэрийг бүрэн гүйцэт тод гаргацтай бичнэ.
    b. Регистерийн дугаарыг заавал бичнэ. Тухайн хүн ухаангүй эсвэл гадаад иргэн байвал шалтгааныг бичнэ.
    c. Эрүүл мэндийн даатгалын дэвтэрийг дугаарыг бүрэн гүйцэт бөглөнө.
    d. Харьяалал болон хаягийн бүртгэлийг дэлгэрэнгүй бүртгэх
    e. 72 цагийн дотор давтан үйлчлүүсэн тохиолдолд тохирох хэсгийг заавал бүртгэх
    f. Осол гэмтлийн асуумжтай тохиолдолд цагдаад мэдэгдсэн эсэхийг тодруулж тэмдэглэл хөтөлсний дараа мэдэгдээгүй тохиолдолд заавал цагдаагийн байгууллагад мэдэгдэнэ.
    g. Осол гэмтлийн шалтгаан, газар,цаг хугацаа, анхны тусламж үзүүлсэн эсэх, үзүүлсэн хүний нэр албан тушаал, авсан арга хэмжээний талаар тэмдэглэлд тусгана.
    h. Тухайн өвчтөний ирэх үеийн зовиурыг товч тодорхой бичнэ.
6. Анхны үзлэг: эрэмбэлэн ялгэлтын мэргэжилтэн анхны үнэлгээг түргэн шуурхай бодиттой гарганэ.
7. Эрт сэрэмжлүүлэх үнэлгээ: тухайн үнэлгээг эрт сэрэмжлүүлэх үнэлгээний дагуу үнэлнэ.
8. Тархвар зүйн асуумжийг заавал гүйцэт бөглөнө.
9. Дээрхийг үнэн зөв бөглөсөн дохиолдолд эрэмбэлэн ялгалтын мэргэжилтэн баталгаажуулж нэрээ гаргацтай татлахгүй бичнэ.
10. Урьдчилсан оношыг тавьж ӨОУА-10-аар код тавьж гарын үсэн зурж баталгаажуулна.

Стационарт хөтлөгдөх анхан шатны маягтуудын хөтлөх заавар

Өвчний түүх СТ-1

ТОДОРХОЙЛОЛТ: Өвчний түүх хөтлөлт гэдэг нь эмчлүүлэгчид хийгдэж буй оношилгоо, эмчилгээний явц, үр дүнг тусгасан эрх зүйн баримт бичиг юм.

Өвчний түүхийн үндсэн хэсгийг хэвтэн эмчлүүлэх тасагтай бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудад хөтлөх ба өвчний түүхийн нарийн мэргэжлийн эмчийн 12 хавсралтыг лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудын тухайн тасагт нэмэлтээр хөтлөнө.

Өвчний түүх хөтлөхөд тавигдах ерөнхий шаардлага

1. Өвчний түүхийг монгол хэл дээр, нэг өнгийн бэхээр, гаргацтай бичнэ.
2. Эмнэлгийн мэргэжилтэн бүр нэрээ гаргацтай бичнэ.
3. Онош, нэр томьёог өвчний олон улсын ангилалаар, англи- монгол хэл дээр бичнэ.
4. Өвчний түүхэнд эмнэлгээс гарах, шилжих үеийн эпикриз, эмчлүүлэгчийн анамнез, бодит үзлэг, клиникийн урьдчилсан онош, клиникийн оношийн үндэслэл, өдөр тутмын үзлэг, өвчний явц үр дүн, эмчилгээний төлөвлөлт зэргийг тодорхой, ойлгомжтой үг хэллэгээр илэрхийлэн бичнэ.
5. Өдөр тутмын үзлэгийн тэмдэглэлд эмчлүүлэгчийн эмчилгээний үр дүнгийн өөрчлөлт, сайжиралт, эдгэрэлтийн болон хүндрэлийн динамик шалгууруудыг шинж тэмдэгээр, үзлэгээр, лабораторын үзүүлэлтээр оруулна.
6. Хөнгөн явцтай, урт хугацаагаар эмчлэгдэх өвчний үед 2 хоног тутамд үзлэгийн тэмдэглэл хөтөлж болно.
7. Хүнд эмчлүүлэгчийг үзлэг, оношилгоо, эмчилгээ хийсэн тухай бүрт тэмдэглэл хөтлөн цаг, минутыг заана.
8. Эмчлүүлэгч болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч заагдсан эмнэлгийн тусламж, үйлчилгээ, оношилгоо, эмчилгээнээс татгалзсан тохиолдолд бичгээр баталгаажуулна.
9. Тасгийн эрхлэгч нь төлөвлөгөөт журмаар хэвтсэн эмчлүүлэгчийг эмнэлэгт хэвтсэнээс хойш 2 өдрийн дотор, хүнд болон хүндэвтэр эмчлүүлэгчийг хэвтсэн өдөр нь үзнэ.
10. Тасгийн эрхлэгчийн тойрон үзлэгийг долоо хоногт 1-2 удаа хийж, өвчний түүхэнд үзлэг, эмнэлзүйн онош, оношийн үндэслэл, зөвлөгөө зэргийг тэмдэглэж, гарын үсгээр баталгаажуулна.
11. Зөвлөх эмч нарын үзлэгийн бичлэгт зөвлөх эмчийн мэргэжил, овог, нэр, үзлэг хийсэн өдөр, цаг, илэрсэн эмгэг өөрчлөлтүүд, эмнэл зүйн онош, зөвлөгөө зэргийг тусгана.
12. Эмч нарын хамтарсан үзлэгийн тэмдэглэлийг бичиж, оролцсон эмч бүрийн гарын үсгээр баталгаажуулах ба гарсан шийдвэрийг биелүүлнэ.
13. Резидент эмчийн гарын үсгийг эмчлэгч эмч баталгаажуулна.
14. Амь насанд эрсдэлтэй ажилбар хийхийн өмнө эмчлүүлэгч болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагчаас зөвшөөрөл авч, өвчний түүхэнд хавсаргана.
15. Өвчний түүхэнд хяналт-шинжилгээ, үнэлгээг жилд 2-оос доошгүй удаа хийх ба шаардлагатай үед түүвэрчилсэн хяналт шинжилгээ үнэлгээ хийнэ.
16. Өвчний түүхийн хуудас бүрийг статистикч эмч, бүртгэл мэдээллийн ажилтан дугаарлана.

Бүртгэл:

- Энэ хэсгийг эмчлүүлэгч болон асран хамгаалагч, ар гэрийнхэнээс асуун бөглөх ба ажлын газар, албан тушаал, мэргэжил, гэрийн хаяг, хэвтэх үеийн оношийг ерөнхий шаардлагын дагуу гаргадахуйц, тодорхой бичнэ.

- Цусны бүлгийг тэмдэглэхдээ эмчлүүлэгчээс асуухаас гадна, цус сэлбэх эмчилгээ хийсэн тохиолдолд заавал баталгаажуулсан байна.

Эмнэлгээс гарах, шилжих үеийн эпикриз:

- Үндсэн онош, дагалдах оношийг ӨОУА-10, үйлдлийн оношийг ҮОУА-9-ийн дагуу англи-монгол хэл дээр гаргацтай бичин, хүндрэл, дагалдах өвчнийг тусгана.
- Эмчлэгч эмч солигдох, нэг тасгаас өөр тасагт шилжих бүрт шилжүүлэх дүгнэлт бичиж, гарын үсгээр баталгаажуулна.
- Өвчний төгсгөл, эмнэлгээс гарсан, шилжсэн, нас барсан байдлыг "√ " тэмдэглэн, он сар, өдөр, ор хоног, эмчилгээний зардлыг тоогоор илэрхийлж, гаргацтай бичнэ.
- Эмнэлгээс гарах үеийн дүгнэлтэд хэвтэн эмчлүүлсэн өвчний түүхийг товч тусган, илэрч байсан шинж тэмдгүүдийн динамик, хийсэн эмчилгээ, түүний үр дүн, цаашид баримтлах дэглэм зэргийг өвчний түүх болон амбулаторын картанд /2 хувь/ бичиж эмчлэгч эмч, тасгийн эрхлэгч нар гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулна.
- Эмчлүүлэгч нас барсан тохиолдолд өвчний түүхэнд эмнэлзүйн төгсгөлийн дүгнэлтийг бичнэ. Төгсгөлийн дүгнэлтэнд өвчлөлийн түүх, шинж тэмдгүүдийн өөрчлөлт, оношилгооны зорилгоор хийгдсэн ажилбар, хийгдсэн эмчилгээ, нас барах үеийн эмнэл зүйн илрэлүүд, нас баралтын шалтгаан, эмнэл зүйн төгсгөлийн дэлгэрэнгүй онош зэргийг бичих ба нас барсан тухай гэрчилгээг хамт бичнэ.
- Эмчлэгч болон хянасан эмч гарын үсэг зурж баталгаажуулна.

Эмчлүүлэгчийн анамнез:

- Асуумжийг эмчлүүлэгч болон асран хамгаалагч, холбогдох хүнээс цуглуулна.
- Хэвтэх үеийн зовиурыг бичихдээ *гол, тулгуурлах, санаа авах* зовиуруудыг дараалуулан бичнэ.
- Өвчин эхэлсэн, сэдэрсэн огноо, явц, шинж тэмдэг, хэвтэхээс өмнө хийгдсэн эмчилгээний талаар тодорхой бичнэ.
- Эмчлүүлэгчийн амьдралын түүхэнд эмчлүүлэгчийн товч намтарыг тусган, өвчний оношилгоонд шаардагдах мэдээллийг тэмдэглэнэ.
- Мэс ажилбар, осол гэмтэл, удамшлын өвчний талаар тодорхой бичнэ.
- Бусад мэдээллийг асуумжийн дагуу "√ " тэмдэглэнэ.

Ерөнхий үзлэг:

- Энэ хэсэгт асуумжийн дагуу "√ " тэмдэглэнэ

Бодит үзлэгийн хэсэг:

- Өвчний түүх хөтлөх ерөнхий шаардлагын дагуу эрхтэн тогтолцооны үзлэгийг монгол хэл дээр, нэг өнгийн бэхээр, гаргацтай бичнэ.
- Өвчний онцлог, шалтгаанаас хамааран зарим эрхтэн тогтолцооны үзлэгийг илүү дэлгэрэнгүй хийж тэмдэглэл хөтөлнө.

Клиникийн урьдчилсан онош:

- Оношийг үндсэн, дагалдах гэсэн дараалаар бичин, хүндрэлийг зааж өгнө.
- Энэ хэсэгт ялган оношлох эмгэгүүд ба хам шинжүүд, хийгдэх шинжилгээ, яаралтай хийгдэх эмчилгээг зааж өгөх ба эмч заавал гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

Клиникийн оношийн үндэслэл:

- Оношийн үндэслэлийг 3-5 хоногт багтаан бичиж, үндсэн ба дагалдах оношийг тавин, хүндрэлийг тусгана.
- Клиникийн оношийн үндэслэлийг зовиур, асуумж, бодит үзлэг, лабораторын шинжилгээ, үйл оношийн шинжилгээний гол дүгнэлтэд тулгуурлан гаргана.
- Эмчлүүлэгч нас барсан тохиолдолд эмнэлзүйн төгсгөлийн онош бичнэ. Эмнэл зүйн төгсгөлийн оношийг эмнэл зүйн шинж тэмдэг, явцын онцлогийг тусган үндсэн өвчин,

түүний хүндрэл, дагалдах өвчин гэж ялган өвчний олон улсын 10-р ангиллын дагуу бичсэн байна.

Эмчилгээ, хоол сувилгааны заалт

- Эмчилгээ нь өвчний шалтгаан, эмгэг жам, шинж тэмдэгт чиглэсэн байна.
- Эмчилгээ, хоол, сувилгааны заалтыг үзлэгийн тэмдэгдэл хэсэгт бичих заалтыг өөрчлөх, хуудас эргүүлэх бүрт бичнэ.
- Жижүүр эмчийн заасан эмчилгээ нь зөвхөн тухайн жижүүрийн хугацаанд хүчинтэй байна. Уг эмчилгээг үргэлжлүүлэн хэрэглэх тохиолдолд эмчлэгч эмч дахин бичнэ.
- Эмийн олон улсын нэр, тун, тун хоорондын зай, хэрэглэх арга, давтамж, хугацааг тодорхой зааж бичнэ.
- Эм нэмсэн, хассан, өөрчилсөн тохиолдолд өдрийн тэмдэглэлд үндэслэлийг тусгана.
- Мэс ажилбар хийхдээ 16 хүртэлх насны хүүхдэд эцэг, эх, асран хамгаалагчийн зөвшөөрлийг авна.

Цус, цусан бүтээгдэхүүн сэлбэх:

- Эмчлүүлэгчид цус, цусан бүтээгдэхүүн сэлбэх үндэслэлийг эмнэлзүйн болон лабораторын үзүүлэлтэд тулгуурлан гаргаж, өвчний түүхэнд тэмдэглэн баримтжуулах холбогдох стандарт, удирдамжийг мөрдлөг болгоно.
- Цус, цусан бүтээгдэхүүн захиалах болох сэлбэсэн талаар зохих маягтуудыг бүрэн, гаргацтай хөтлөн, өвчний түүхэнд хавсаргана.
- Цус, цусан бүтээгдэхүүн сэлбэсэнтэй холбоотой урвал хүндрэл, сөрөг урвал илэрсэн тохиолдолд мэдээлэх маягтуудыг бүрэн, гаргацтай бөглөн сэлбэсэн цус, цусан бүтээгдэхүүний үлдэгдэл, хувийн тохироо тодорхойлсон сорьц, урвал өгсний дараах сорьцны хамт цусны албанд хүргүүлнэ.

Хориглох зүйл

- Өвчний түүхэнд баллах, дарах, засах зэрэг үйлдлийг хориглоно.
- Өвчний түүхийг эмчлэгч эмчээс өөр хүн бичихийг хориглоно.

Төрөлтийн түүх

Партограммийг хөтлөх заавар

Партограммийг төрөлтийн идэвхтэй үе буюу умайн хүзүү 4 см нээгдсэн үеэс тэмдэглэж эхэлнэ.

Доорх зүйлийг партограмм дээр тэмдэглэнэ.

Жирэмсэн эмэгтэйн тухай мэдээлэл: нэр, нас, жирэмслэлт, төрөлтийн тоо, хүлээн авсан он, сар, өдөр, цаг, хором, ураг орчмын шингэн гарсан цагийг тэмдэглэнэ.

Ургийн зүрхний цохилт: хагас цаг тутамд тэмдэглэнэ.

Ураг орчмын шингэний байдал: Ураг орчмын шингэн гарсан тохиолдолд үтрээний үзлэг хийх бүрдээ шингэний өнгийг тэмдэглэнэ.

- Б: Ургийн шингэний бүрхүүл хальс бүтэн
- Х: Ураг орчмын шингэний бүрхүүл хальс урагдсан

- Т: Ураг орчмын шингэн тунгалаг
- З: Ураг орчмын шингэн зунгагны хольцтой
- Ц: Ураг орчмын шингэн цусны хольцтой

Ургийн толгойн хэлбэржилт:

- 1: + ясны ирмэгүүд хоорондоо дөнгөж нийлсэн байна.
- 2: ++ ясны ирмэгүүд зөрсөн байх ба хуруугаар дарахад зөрлөг нь багасна.
- 3: +++ ясны ирмэгүүд зөрж давхарласан, хуруугаар дарахад зөрлөг нь багасахгүй.

Умайн хүзүүний нээгдэлт: Үтрээний шинжилгээ хийх бүртумайн хүзүүний байдлыг үнэлж, хэрээсээр Х тэмдэглэнэ.

Хянах шугам:Умайн хүзүү 4 см ба түүнээс илүү нээгдэхэд эхэлж тэмдэглээд цагт 1 см –ээр нэмэгдэж бүрэн нээгдэх хүртэл зурагдана.

Арга хэмжээний шугам: Хянах шугамын баруун талд 4 цагийн зайтай параллель байрлана.

Хэвлийг тэмтэрч ургийн толгойн доошлолтыг үнэлэхдээ: Толгойг умдаг яснаас дээш тэмтрэгдэх байдлаас хамааруулж 5 барилд хуваадаг. Үтрээни йүзлэг бүрт тэмдэглэнэ. 0/5-д дух нь умдагны түвшинд байна.

Цаг: Хүлээн авснаас эхлэн цагийг тэмдэглэнэ.

Хугацаа: Хүлээн авснаас хойш /партограф хөтөлснөөс/ төрөлт үргэлжилж байгаа хугацаа.

Базлалт: Бүдүүвчийг хагас цаг тутамд, 10 хормын турш үзэж базлалтын тоог, үргэлжлэх хугацааг секундээр нь тэмдэглэж бөглөх.

- 20 секундээс бага: цэгчилж
- 20-40 секундын хооронд: ташуу зураасаар
- 40 секундээс их байх: бүрэн будна

Окситоцин: 30 хором тутамд 1 хормын турш дусч байгаа дуслын тоо, судсаар таригдаж буй шингэний доторх окситоцины нийт тун хэмжээг тэмдэглэнэ.

Өгсөн эм: Хэрэглэсэн эмийг тэмдэглэнэ.

Судасны лугшилт: 30 хором тутамд цэгээр /*/ тэмдэглэнэ.

Артерийн даралт: 4 цаг тутамд /сумаар/ тэмдэглэнэ.

Биеийн халуун: 2 цаг тутам тэмдэглэнэ.

Ууараг, ацетоны хэмжээ: Шээсний хэмжээ, бусад зүйлийг тэмдэглэнэ.

Сувилагч, эмчлүүлэгчийн биеийн байдлыг үнэлэх хуудас СМ-1 Хавсралт 11, Сувилгааны тэмдэглэл СМ-2 Хавсралт 12, Өвдөлтийг хянах хуудас СМ-3 Хавсралт 13, Шингэний балансыг хянах хуудас СМ-4 Хавсралт 14

1. “СТ-1А/Б Хавсралт 2 Өвчтөний амин үзүүлэлтийн хуудас”, “СМ-1 Хавсралт 11 Сувилагч эмчлүүлэгчийн биеийн байдлыг үнэлэх хуудас”, “СМ-2 Хавсралт 12: Сувилгааны тэмдэглэл,

сонгомолоор “СМ-4 Хавсралт 14: Шингэний баланс хянах хуудас”, “СМ-3 Хавсралт 13: Өвдөлт хянах хуудас”-ыг бүхэлд нь “Сувилгааны түүх” гэж нэрлэнэ.

2. Сувилгааны түүх нь сувилахуйн мэргэжлийн тусламж, үйлчилгээг үзүүлсэн тухайг баримтжуулан, нотолгоо болох үүднээс өвчний түүхийн хамт хадгалагдана.
3. СТ-1А/Б Хавсралт 2 Өвчтөний амин үзүүлэлтийн хуудас сувилах эрх бүхий сувилагч, хэвтэн эмчлүүлж буй хүүхэд, насанд хүрэгчдэд, “СМ-1; СМ-2; СМ-3; СМ-4” маягтыг эрчимт эмчилгээний тасгаас бусад хэвтэн эмчлүүлж байгаа насанд хүрэгчдэд хөтлөнө.
4. “СМ-1; СМ-2; СМ-3; СМ-4” маягтыг (хүүхдийн, эрчимт эмчилгээний) хэвтэн эмчлүүлэх тасаг болон хэвтэн эмчлүүлэхээс бусад тасаг, нэгж, амбулаторийн сувилахуйн тусламж, үйлчилгээнд хэрэглэх асуудлыг тухайн байгууллагын сувилгааны албаны шийдвэрийг үндэслэн бүтнээр болон сонгомол, хэсэгчилсэн байдлаар хөтөлж болно.
5. Сувилагч, сувилгааны түүхийг цэвэр, гаргацтай, нямбай хөтлөн, гарын үсгийг товчлохгүй бичих бөгөөд энэхүү үйл ажиллагаанд тасгийн ахлах сувилагч өдөр тутмын хяналт, үнэлгээг тавьж хэрэгжүүлнэ.
6. Сувилгааны түүхийг өвчний түүхтэй хамт байхаар хавтаст баримт үүсгэх боловч, сувилгааны түүхийн хэсгийг нь сувилагч шаардлагатай үед дангаар нь авч сувилах үйл ажиллагаанд хэрэглэх боломжтой байдлаар хэвлэсэн байна.

Эмчлүүлэгчийн биеийн байдлыг сувилагч, анхлан үнэлэх.

1. СТ-1А,Б Хавсралт 2 хуудсыг хүлээн авах, яаралтай тусламжийн тасгийн сувилагч эхэлж, цаашид тухайн ээлжинд ажиллаж буй өдрийн болон ээлжийн сувилагч үйлчлүүлэгчийг эмнэлгээс гарах хүртэл хөтөлнө.
2. СМ-1; СМ-2; СМ-3; СМ-4 хуудсыг эмчлүүлэгчийг эмнэлэгт хэвтсэний дараах 24 цагт багтаан хөтлөнө. Энэхүү 24 цагийн дотор ямар ээлжинд, ямар сувилагч эхний үнэлгээг өгөх тухай асуудлыг, сувилагчдын ажлын ачааллыг тэнцүүлэх дотоод зохицуулалтын зарчмаар, сувилгааны албаны дарга журамлана.
3. Эмчлүүлэгчийн биеийн байдлыг сувилагч анхлан үнэлснийг тасгийн ахлах сувилагч (арга зүйч) шалган баталгаажуулж, үнэлгээг хэдий хугацааны дараа дахин хийх шаардлагатайг СМ-1 хуудасны тусгай тэмдэглэл хэсэгт бичиж тэмдэглэнэ.
4. Цаашид ахлах сувилагчийн тэмдэглэлийг үндэслэн тухайн ээлжийн болон өдрийн сувилагч нар хөтлөнө.

Хөтлөх заавар.

СТ-1А/Б Хавсралт 2 Өвчтөний амин үзүүлэлтийн хуудас

1. Хуудсыг сувилагч, эмчлүүлэгчийн биеийн халуун, цусны даралт, судасны лугшилт, амьсгал хэвийн хэмжээндээ байгаа эсэхийг үзэж, амьсгалыг -хөх, биеийн халууныг -хар, судасны цохилтыг -улаан өнгийн балаар зохих хүснэгтэд бөглөнө.
2. Энэхүү хуудсанд цусны даралт, хоолны дугаар, биеийн жинг үзэж, өтгөн шингэний давтамжийг асууж тэмдэглэн, гарын үсэг зурж баталгаажуулна.
3. Хуудсыг ээлжийн сувилагч нар өдөр бүр хөтөлнө.

Сувилагч эмчлүүлэгчийн биеийн байдлыг үнэлэх хуудас (Маягт СМ-1)

1. Хуудсыг хөтлөхдөө үйлчлүүлэгчийг аль болох түүнд эвтэйхэн байрлалд байлган асуух, ярилцах, биеийн байдлыг амьсгал, зүрх судасны хэсгээс эхлэн үнэлэх, бодит үзлэг хийх

хэлбэрээр хөтлөх ба үйлчлүүлэгчийн нэмэлтээр хэлсэн өгүүлэмжийг сонсч, тэмдэглэх байдлаар хөтөлнө.
2. Үнэлгээний асуулт бүрт тохирох хариултыг тус хуудасны ард буй *зааврын дагуу тийм, үгүй, хамаарахгүй гэсэн тэмдэглэгээний аль нэгээс сонгон тэмдэглэнэ.
3. Эдгээр тэмдэглэгээний аль нэгийг тавиагүй, тэмдэглэгээ хийгдээгүй нүд үлдээж болохгүйг анхаарна.
4. Сувилагч, тухайн бүлэг асуудлыг үнэлж дуусаад (Жнь: амьсгал, зүрх судасны бүлэг) түүний ард буй сувилгааны асуудлуудаас тохирох нэг асуудлыг сонгон түүний дугаарыг үнэлгээний төгсгөлд буй бүлэг асуудлын (7) нэрний ард байрлах нүдэнд тэмдэглэнэ. Ж-нь: Ханиалгалт, цэртэй гэж үнэлсэн бол “Амьсгалын замын цэвэршилт алдагдсан” гэсэн асуудлыг сонгон “**#3**“ тэмдгийг тохирох нүдэнд тавьж, сувилгааны тэмдэглэл(СМ-2)-ийн асуудлын дугаар мөрөнд оруулж, сувилах төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлж, дүгнэх зарчмаар ажиллана.
5. Үнэлгээний хэсгийн бүх үзүүлэлт хэвийн гэж үнэлсэн бол энэ хэсэг дээр сувилах төлөвлөгөө зохиох шаардлагаггүй бөгөөд, харин өдөр тутам үзүүлсэн асаргаа, сувилгааны хэсэг болон бусад үзүүлсэн сувилахуйн тусламж, дараагийн ээлжийн сувилагч анхаарах асуудлыг заавал бичиж тэмдэглэнэ.

Сувилгааны тэмдэглэл (Маягт СМ-2)

1. Сувилагч СМ-1 хуудас буюу үнэлгээг үндэслэн эмчлүүлэгчид хийсэн асаргаа сувилгаа, эмчийн заалтын дагуу хийсэн эмчилгээг тухайн үйлдлийг хийсэн тухай бүрт бичиж тэмдэглэх зорилготой.
2. Эмчлүүлэгчийн биеийн байдалд өгсөн үнэлгээ, гарсан асуудал бүрийн дагуу сувилахуйн тусламж үйлчилгээг “сувилах төлөвлөгөө” хэсэгт эмчлүүлэгчтэй харилцан ярилцаж, зөвшилцөж, төлөвлөх ба асаргаа сувилгааг хийсний дүнд өвчтөний биеийн байдалд гарсан гол үр дүн, дүгнэлт, тэмдэглэлийг “хэрэгжүүлэлт/ дүгнэлт” гэсэн хэсэгт бичиж гарын үсгээр баталгаажуулна.
3. Эмчлүүлэгчийн биеийн байдлаас /хүнд, хөнгөн/ шалтгаалан сувилгааны үнэлгээгээр илрүүлсэн асуудлыг бүрэн арилтал сувилагчийн авсан арга хэмжээ, үзүүлсэн асаргаа сувилгааг цаг алдалгүй бичиж, тэмдэглэнэ.

Сонгомолоор хэрэглэх сувилгааны тэмдэглэлүүд

1. Маягт СМ-4 Шингэний баланс хянах хуудас
2. Маягт СМ-3 Өвдөлтийг хянах хуудас /сонгомолоор хэрэглэх/

1. Шингэний баланс хянах (СМ-4) хуудсыг хөтлөх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд сонгомолоор биед орсон болон биеэс гарсан шингэний тэнцвэрт байдлыг хянах зорилгоор сувилагч нэг бүрчлэн хэмжиж тэмдэглэх буюу эсвэл асран халамжлагчид орсон гарсан шингэнийг хэрхэн хэмжих тухай зааж тэмдэглүүлнэ. Сувилагч хянаж, гарын үсэг зурж баталгаажуулна.
2. Өвдөлтийг хянах (СМ-3) хуудсыг өвдөлтийг үнэлэх, өвдөлтийг багасгах сувилгааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх зорилгоор их өвдөлттэй эмчлүүлэгчид сонгомолоор авч хэрэглэнэ.

3. Эмчлүүлэгч өөрөө өвдөлтийн хүчийг тодорхойлж чадахгүй байгаа тохиолдолд нүүр царайны байдлаар харуулсан зургийг ашиглан тодорхойлж болно.
4. Хуудсыг сувилагч хөтлөн, баталгаажуулна.

Гемодиализын хяналтын карт СТ-2-ыг гемодиализын тасаг нэгжид эмчлэгч эмч хөтлөнө.
Стандартаар эмчилгээнд орсон хүний тоо гэдэг нь Бөөрний өвчний төгсгөлийн шатанд орсон хүний эмчилгээний стандартаар 7 хоногт 12-15 цаг аппаратад орох заалттай. Энэ заалтын дагуу 7 хоногт 12-15 цагаар орсон хүнийг хэлнэ.
Стандарт бусаар орсон үйлчлүүлэгдийн тоо /багана 23/ гэдэг нь 7 хоногт 12 цагаас бага хугацаагаар орсон хүнийг хэлнэ.
Тухайн онд хийгдсэн нийт сеансын тоо гэдэг нь 1 өвчтөн 1 удаад диализын аппаратад 4 цаг орох ёстой. Өвчтөнийг 1 удаад 4 цагийн хугацаанд аппаратад оруулсан тоог бичнэ.

"Төрөлхийн хөгжлийн гажгийг мэдээлэх хуудас" СТ-11 хөтлөх заавар

СТ-11 маягтыг аргачлал, жишээг ашиглан хөтөлнө.

Асуумж	Аргачлал-Тодорхойлолт - Жишээ
	А. Ерөнхий мэдээлэл
Асуулт 1: Мэдээлсэн он, сар, өдөр	Эмч мэдээлэх хуудсыг бөглөсөн хугацааг он, сар, өдөр, цаг, минутаар бичнэ. *Жишээ: 2014 он 4 сар 8 өдөр 13 цаг 30 минут* гэж тэмдэглэнэ.
Асуулт 2: Мэдээлсэн газар	Мэдээлсэн газрын талаар дэлгэрэнгүй бичнэ. *Жишээ: Мэдээлсэн газар:* Аймаг/хот: *Ховд* Сум/дүүрэг *Манхан* Эмнэлгийн нэр: *Сумын эрүүл мэндийн төв* Мэдээлсэн эмчийн нэр: *Дашийн Дэлгэрмаа*
	Б. Эхийн талаарх мэдээлэл
Асуулт 1: Эхийн регистрийн дугаар	Регистрийн дугаарыг бөглөхдөө тухайн нярайн эхийн иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээнд бичсэн регистрийн дугаарыг үндэслэн бичнэ. Регистрийн дугаар гэсэн 10 нүд бүхий хүснэгтийн эхний 2 нүдэнд үсгийг том үсгээр, сүүлийн 8 нүдэнд цифрийг тус бүрт гаргацтай бичнэ. *Жишээ: А Н 8 6 0 2 2 4 6 5*
